

Улсын бүртгэлийн  
дугаар: .....

Нууцын зэрэглэл:  
Б

Аравтын бүрэн  
ангиллын код

Төсөл хэрэгжүүлэх даалгаварын  
дугаар: .....

**БАТЛАН ХАМГААЛАХЫН  
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХҮРЭЭЛЭН**

**“МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН АЮУЛГҮЙ  
БАЙДАЛ БА БАТЛАН ХАМГААЛАХ ЧАДАВХЫН  
ӨСӨЛТӨД ХИЙХ ДҮН ШИНЖИЛГЭЭ” ШИФР:  
“ЭДИЙН ЗАСАГ” ТӨСЛИЙН ТАЙЛАН**

Даалгаварт төслийн тайлан

Төслийн удирдагч: Т.Соронзонболд

Захиалагч байгууллага: БХЯ-ны ШУТЗ

Санхүүжүүлэгч байгууллага: БХЯ

Гүйцэтгэгч байгууллага: БХЭШХ

Тайлан өмчлөгч: Батлан хамгаалах эрдэм шинжилгээний хүрээлэн.  
13300 Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 16-р хороо,  
Нянтайсүрэнгийн гудамж, Улаанхуаран.

Улаанбаатар хот. 2018 он

Улсын бүртгэлийн  
дугаар: .....

Нууцын зэрэглэл:  
Б

Аравтын бүрэн  
ангиллын код

Төсөл хэрэгжүүлэх даалгаврын  
дугаар: .....

**БАТЛАН ХАМГААЛАХ  
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХҮРЭЭЛЭН**

**“МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН АЮУЛГҮЙ  
БАЙДАЛ БА БАТЛАН ХАМГААЛАХ ЧАДАВХЫН  
ӨСӨЛТӨД ХИЙХ ДҮН ШИНЖИЛГЭЭ” ШИФР:  
“ЭДИЙН ЗАСАГ” ТӨСЛИЙН ТАЙЛАН**

**Даалгаварт төслийн тайлан**

<b>Төслийн удирдагч:</b>	<b>Т.Соронзонболд.</b> - БХЭШХ-ийн БХДШТ-ийн дарга, доктор (Ph.D), профессор, хурандаа
<b>Төслийн гүйцэтгэгчид:</b>	<b>Х.Батсүх.</b> - ҮБХИС-ийн Санхүүгийн хэлтсийн дарга, хурандаа <b>Лха.Баяр.</b> - БХЭШХ-ийн БХДШТ-ийн ЭША, доктор (Ph.D), дэд хурандаа <b>Б.Нэргүй.</b> - БХЭШХ-ийн БХДШТ-ийн ЭША, докторант, хошууч <b>Б.Содбилэг.</b> - БХЭШХ-ийн БХДШТ-ийн ЭША, докторант, хошууч <b>П.Цэдэв.</b> - БХЭШХ-ийн БХДШТ-ийн ЭШАА, доктор (Ph.D), профессор <b>Б.Баатарсүрэн.</b> - БХЭШХ-ийн БХДШТ-ийн ЭША, докторант <b>Д.Энхчимэг.</b> - ҮБХИС-ийн багш, БХДШТ-ийн доктор (Ph.D)
<b>Захиалагч байгууллага:</b>	БХЯ-ны ШУТЗ
<b>Тайлан өмчлөгч:</b>	Батлан хамгаалах эрдэм шинжилгээний хүрээлэн. 13300 Улаанбаатар, Баянзүрх дүүрэг, 16-р хороо, Нянтайсүрэнгийн гудамж, Улаанхуаран, ҮБХИС

Утас: 11-453942, Факс: 70150173, Цахим хаяг:  
<http://www.mids.gov.mn>; [mids@mndu.gov.mn](mailto:mids@mndu.gov.mn);  
[def\\_analyses@mndu.gov.mn](mailto:def_analyses@mndu.gov.mn)

## ГАРЧИГ

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ ..... 4

УДИРТГАЛ .....5

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ЭДИЙН ЗАСГИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ТҮҮНИЙ ОРЧИН, ХҮЧИН ЗҮЙЛС НЬ БАТЛАН ХАМГААЛАХ ЧАДАВХАД НӨЛӨӨЛӨХ ЗҮЙ ТОГТОЛ, СУРГАМЖ

- 1.1. Эдийн засгийн аюулгүй байдлын хүчин зүйл, Батлан хамгаалах ашиг сонирхол, чадавхад нөлөөлөх онол, арга зүйн үндэс ..... 9
- 1.2. Батлан хамгаалахын төсвийн мөн чанар, үүрэг ..... 20
- 1.3. Гадаадын зарим Улс орон эдийн засаг, Батлан хамгаалах чадавхын өсөлтөөрөө аюулгүй байдлаа хангаж буй сургамж ..... 26

Дүгнэлт

ХОЁРДУГААР БҮЛЭГ. МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, БАТЛАН ХАМГААЛАХ ЧАДАВХЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

- 2.1. Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдлын гадаад, дотоод хүчин зүйлсэд хийсэн шинжилгээ ..... 34
- 2.2. Монгол Улсын Батлан хамгаалахын төсвийн санхүүжилтийн өнөөгийн байдалд хийсэн шинжилгээ ..... 55

Дүгнэлт

ГУРАВДУГААР БҮЛЭГ. МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛТАЙ УЯЛДУУЛЖ, БАТЛАН ХАМГААЛАХ ЭДИЙН ЗАСГИЙН ЧАДАВХЫГ НЭМЭГДҮҮЛЭХ АРГА ЗАМ

- 3.1. Монгол Улсын эдийн засаг болон Батлан хамгаалах чадавхын уялдаа холбоог сайжруулах арга зам ..... 67
- 3.2. Монгол Улсын Батлан хамгаалахын чадавхыг нэмэгдүүлэх эдийн засгийн бусад арга замууд ..... 77

Дүгнэлт

ТӨГСГӨЛ ..... 83

ЭШЛЭЛ АВСАН СУРВАЛЖ, СУДАЛГААНЫ БҮТЭЭЛИЙН ЖАГСААЛТ .....92

## ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

АҮ	Аж үйлдвэр
БХЭЗ	Батлан хамгаалахын эдийн засаг
БХЭЗЧ	Батлан хамгаалахын эдийн засгийн чадавх
БХЯ	Батлан хамгаалах яам
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЗХ	Зэвсэгт хүчин
ЗХЖШ	Зэвсэгт хүчний жанжин штаб
НАТО	Умард Атлантын хамтын гэрээний байгууллага
НББ	Нягтлан бодох бүртгэл
ОУВС	Олон улсын валютийн сан
ҮАБ	Үндэсний аюулгүй байдал
ҮЭЗАБ	Үндэсний эдийн засгийн аюулгүй байдал
ХБКА	Хамгийн бага квадратын арга
ХЗХБ	Химийн зэвсгээс хориглох байгууллага
ХҮИ	Хэрэглээний үнийн индекс
ЦАХ	Цэргийн алба хаагч
ЭЗАБ	Эдийн засгийн аюулгүй байдал

## УДИРТГАЛ

### **Судалгааны үндэслэл:**

Аюулгүй байдлын төлөв чиг хандлага нь урьдчилан таахын аргагүй өөрчлөмтгий, шинж чанарыг агуулах болж, түүнд нөлөө үзүүлэгч хүчин зүйлсийн хүрээ үлэмж тэлсэн нь учирч болзошгүй аюул, хохирлын магадлалыг ихэсгэн, ихээхэн сөрөг үр дагаврыг дагуулах боллоо. Ийм нөхцөл байдал нь улс орон бүр аюулгүй байдлаа хангах тодорхой эдийн засгийн чадавхтай, түүнийгээ хэрэгжүүлэх арга замаа зайлшгүй эргэн харж, шинэчлэх шаардлагыг бий болгож байна. Дэлхийн эдийн засгийн системийн даяарчлалын үйл явц нь хямралын процесс, шинэ аюул заналыг үндэсний аюулгүй байдалд бий болгож байгаа тул үүнд тохирсон арга хэмжээг төрөөс авах шаардлага тулгарч байна.

Улс орнуудын эдийн засгийн байдал нь Батлан хамгаалах ашиг сонирхол, чадавхад нөлөөлж байдаг зүй тогтолтой.

Монгол Улсын эдийн засгийн өнөөгийн байдал тогтворгүй, савалгаатай байгаа нь үндэсний аюулгүй байдал, улмаар Батлан хамгаалах чадавхад сөрөг нөлөөлөл үүсгэж болзошгүй юм.

Улс орны эдийн засгийн өсөлтийг өөдрөг талаас нь харж Батлан хамгаалах салбарт шинэчлэлийг эрчимжүүлэх, зэвсэглэл, техникийг шинэчлэх, Зэвсэгт хүчний чадавхыг нэмэгдүүлэхэд ашиглах боломжийг судлах шаардлага ч гарч байна. Иймд Батлан хамгаалах салбарын төсөв, нөөцийг зохистой хэмжээнд нэмэгдүүлэх урт хугацааны бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөгөөр хэрэгжүүлэх шаардлага байна. Үүний тулд:

- Монгол Улсын эдийн засгийн байдлаас Батлан хамгаалах чадавх нь хэрхэн хамаарч буй байдал, түүнд шинжилгээ хийх;
- Гадаадын зарим орон эдийн засгийн бодлогоороо Батлан хамгаалах чадавхын өсөлтөө хангаж буй туршлагыг судлах;
- Монгол Улсын эдийн засгийн бодлого түүний үр өгөөж болон Батлан хамгаалах чадавхын хоорондын уялдаа холбоог гаргах;
- Улс орны эдийн засгийн байдалтайгаа уялдуулан, Батлан хамгаалах чадавхыг нэмэгдүүлэх арга замыг тодорхойлох шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

### **Судлагдсан байдал**

Сэдвийн судлагдсан байдлыг авч үзвэл төсвийн бодлогын асуудлаар бичсэн эрдэмтэн судлаачдын зохиол бүтээлүүд нь ихэвчлэн төрөөс эдийн засагт оролцох оролцооны талаар эрдэмтдийн гаргасан онолын үзэл санаанд суурилсан байна.

Батлан хамгаалах салбарын эрдэмтэн судлаачид аюулгүй байдал, олон улс ба бүс нутгийн ҮАБ, ЭЗАБ, Батлан хамгаалах бодлого, тэдгээрийн үйл ажиллагааны талаар цөөнгүй бүтээлийг туурвисан байна. Тухайлбал, Шинжлэх ухааны доктор О.Үржин, Ш.Паламдорж, Д.Мягмар, доктор Ч.Улаанхүү, З.Болдбаатар, Б.Равжаа, А.Түвшинтөгс, Ч.Сосорбарам, Б.Эрдэнэчимэг, судлаач Я.Чойжамц нарын удирдан гүйцэтгэсэн төслийн ажлын тайлан, туурвисан эрдэм шинжилгээний өгүүлэл, нийтлэлийг дурдаж болох юм.

ЭЗАБ, төсвийн асуудлаар эрдэмтэн, судлаачид онол, практикийн судалгаа хийж, үзэл бодлоо дэвшүүлсэн олон бүтээл туурвисан байна. Тухайлбал: Д.Тунгалаг "Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдлын зарим асуудал" 2001 он, "Үндэсний эдийн засгийн аюулгүй байдлын онол, практикийн зарим асуудал" 2015 он, Л.Отгонтуяа "Төсвийн зарлагын төлөвлөлтийг боловсронгуй болгох нь" 2007 он, Ж.Энхбаяр "Монгол Улсын Батлан хамгаалах эдийн засгийн чадавхыг бэхжүүлэх асуудалд" 2009 он, Ж.Энхбаяр "Батлан хамгаалахын эдийн засгийн зарим асуудал" 2010 он, А.Энхбат "Монгол Улсын санхүүгийн хөтөлбөр боловсруулах арга зүйн асуудал" 2010 он, А.Батпүрэв "Төсвийн бодлогын макро эдийн засгийн үзүүлэлтүүдэд нөлөөлөх нөлөөллийн шинжилгээ" 2013 он, Д.Оюунцэцэг "Төсвийн бодлогын үр дүнгийн үнэлгээ" 2014 он, Т.Намсрай, Д.Нанжид "Батлан хамгаалах төсөв боловсруулах арга зүйн асуудал" 2016 он, Д.Энхчимэг "Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдлыг төсвийн бодлогоор дэмжих арга зам" 2016 он зэрэг бүтээлүүд байна.

### **Судалгааны зорилго:**

Монгол Улсын эдийн засгийн байдлаас Батлан хамгаалах чадавх нь хэрхэн хамаарч буй байдлыг судалж, Батлан хамгаалах чадавхыг нэмэгдүүлэх арга замыг тодорхойлох, энэ талаарх санал, зөвлөмжийг боловсруулахад оршино.

### **Судалгааны зорилт:**

- Эдийн засгийн аюулгүй байдал, түүний орчин, хүчин зүйлс нь Батлан хамгаалах чадавхад нөлөөлөх зүй тогтол, сургамжийг тодорхойлох.
- Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдал, Батлан хамгаалах чадавхын өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийх.
- Монгол Улсын эдийн засгийн өнөөгийн байдалтай уялдуулж, Батлан хамгаалах чадавхыг нэмэгдүүлэх арга замыг тодруулах.

**Судалгааны объект:**

Монгол Улсын эдийн засгийн байдал ба Монгол Улсын нэгдсэн болон Батлан хамгаалахын төсөв

**Судлах зүйл:**

Батлан хамгаалах чадавхыг нэмэгдүүлэх арга зам

**Судалгааны ажлын хязгаарлалтууд:** Судалгааны ажилд дараах хязгаарлалтуудыг тавьсан болно. Үүнд:

- ЭЗАБ-ын шалгуур үзүүлэлтүүдэд төсвийн хүчин зүйл нөлөөлөх асуудлыг судална.
- Төсвийн орлогыг зөвхөн төсвийн зарлагын санхүүжилтийн эх үүсвэр талаас нь авч үзнэ. Төсвийн төлөвлөлт хяналтын тогтолцоог иж бүрнээр нь авч үзэхгүй загвар талаас нь судална.
- Төсвийн орлого оруулахгүй зарлага гаргадаг салбаруудын хувьд төлөөлөл болгон аюулгүй байдлын тэргүүлэх салбар болох Батлан хамгаалах салбарын жишээн дээр ЭЗАБ-д нийцсэн төсвийн санхүүжилтийн хувилбарын үндэслэлийг тооцно.
- Батлан хамгаалах төсвийн хүрээнд судалгаа явуулна.

**Судалгааны арга:**

Санал асуулга, мэдээлэл олборлох, харьцуулан жиших, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, бүтэц тогтолцооны аргуудыг хэрэглэв. Мөн гадаадын болон өөрийн орны эрдэмтэн судлаачдын эрхлэн гаргасан ном, товхимол, өгүүлэл, нийтлэл зэргийг онол арга зүйн хэрэглүүр болгон ашигласан болно.

**Судалгааны ажлын онол, практикийн ач холбогдол:**

ЭЗАБ-ын онолын судалгаа хийж ЭЗАБ-ын шалгуур үзүүлэлтүүдийг өргөжүүлэн үнэлэлт, дүгнэлт хийсэн.

ЭЗАБ-ыг хангахад төсвийн бодлого нөлөөлөх онолын үндэслэлийг математик загварчлалын үүднээс судлан шинжилж, Монгол Улсын ЭЗАБ-ыг хангахад төсвийн бодлогын үзүүлэх нөлөө, хүчин зүйлсийн шинжилгээ хийж, төсвийн төлөвлөлт, хэрэгжилтийг үр дүнтэй болгох арга механизмын талаар тодорхой санал дэвшүүлсэн:

- Эдийн засгийн аюулгүй байдал, түүний орчин, хүчин зүйлс нь Батлан хамгаалах чадавхад нөлөөлөх зүй тогтол, сургамжийг тодорхойлсон;
- Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдал, Батлан хамгаалах чадавхын өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийсэн;
- БХ-ын төсвийн хөрөнгө оруулалтын өгөөжийг дээшлүүлэх арга замыг тодорхойлсон;
- ЭЗАБ-ыг хангах боломжид нийцсэн Батлан хамгаалах төсөв боловсруулах аргазүйн асуудал чухал болохыг дэвшүүлэн тавьсан;
- Монгол Улсын эдийн засгийн өнөөгийн байдалтай уялдуулж, Батлан хамгаалах чадавхыг нэмэгдүүлэх арга замыг тодорхойлсон зэрэгт судалгааны ажлын шинэлэг тал болон практик ач холбогдол оршиж байна гэж үзлээ.

### **Судалгааны ажлыг гүйцэтгэсэн байдал:**

Энэхүү судалгааны ажлын бүтэц нь удиртгал, 3 бүлэг, 7 дэд хэсэгтэй, бүлэг тус бүрийн дүгнэлт, төгсгөл, эшлэл авсан сурвалж, судалгааны бүтээлийн жагсаалт хэсгээс бүрдэнэ. Бүгд 13 зураг, 14 хүснэгт бүхий 92 хуудастай болно.

“Эдийн засгийн аюулгүй байдал, түүний орчин, хүчин зүйлс нь Батлан хамгаалах чадавхад нөлөөлөх зүй тогтол, сургамж” хэмээх нэгдүгээр бүлгийг доктор, профессор П.Цэдэв, доктор Д.Энхчимэг, 1.3 зүйлийг доктор, профессор П.Цэдэв, доктор Б.Содбилэг, “Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдал, Батлан хамгаалах чадавхын өнөөгийн байдалд хийсэн дүн шинжилгээ” гэсэн хоёрдугаар бүлгийг доктор, профессор П.Цэдэв, доктор Д.Энхчимэг, хурандаа Х.Батсүх, “Монгол Улсын эдийн засгийн өнөөгийн байдалтай уялдуулж, Батлан хамгаалах эдийн засгийн чадавхыг нэмэгдүүлэх арга зам” хэмээх гуравдугаар бүлгийг доктор, профессор, хурандаа Т.Соронзонболд, докторант, хошууч Б.Нэргүй, доктор, дэд хурандаа Лха.Баяр, докторант Б.Баатарсүрэн, удиртгал, төгсгөлийн хэсгийг доктор, профессор П.Цэдэв, докторант Б.Баатарсүрэн, зөвлөмжийг хурандаа Т.Соронзонболд, дэд хурандаа Лха.Баяр нар боловсруулав.



## **НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. ЭДИЙН ЗАСГИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, БАТЛАН ХАМГААЛАХ АШИГ СОНИРХОЛ ЧАДАВХАД НӨЛӨӨЛӨХ ЗҮЙ ТОГТОЛ, СУРГАМЖ**

### **1.1. Эдийн засгийн аюулгүй байдлын хүчин зүйл, Батлан хамгаалах ашиг сонирхол чадавхад нөлөөлөх онол, аргазүйн үндэс**

Улсын тусгаар тогтнол, бие даасан байдал, ард түмний язгуур ашиг сонирхол баталгаатай хангагдах нь үндэсний эдийн засгийн хөгжилтэй холбогдож, харилцан уялдаатай орших тул үндэсний аюулгүй байдлын үндсэн бүрэлдэхүүн хэсэг бол эдийн засгийн аюулгүй байдал юм. Эдийн засгийн аюулгүй байдал нь үндэсний эдийн засгийн хөгжлийн нэг гол угтвар нөхцөл болохын дээр улсын оршин тогтнох үндэс, иргэдийн эрх, эрх чөлөө, нийгмийн хөгжил дэвшил, соёл иргэншил, нийгэм, төрийн байгууллын аюулгүй байдал, Батлан хамгаалах чадавх, байгаль экологийн тэнцвэрийг хангах нөхцөлийг бүрдүүлнэ.

“Монгол Улсын үндэсний язгуур эрх ашигт монголын ард түмэн, соёл иргэншил оршин тогтнох, Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэр, хил хязгаарын халдашгүй болон бүрэн бүтэн байдал, үндэсний эв нэгдэл, үндсэн хуульт байгууллын аюулгүй байдал, эдийн засгийн бие даасан байдал, экологийн тэнцвэрт хөгжил багтана.”<sup>1</sup> гэж тодорхойлсон нь эдийн засгийн аюулгүй байдал үндэсний эрх ашгийн салшгүй хэсэг, үндэсний аюулгүй байдлын гол тулгуур, оршин тогтнохуйн үндэс суурь болохыг илэрхийлж байгаа юм.

Монгол Улсын Үндсэн хуулийн “Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна”<sup>2</sup> гэсэн заалт нь эдийн засгийн аюулгүй байдлыг хангах эрхзүйн суурь болно. Мөн “Монгол Улс дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байна”<sup>3</sup> гэсэн заалтын дагуу зах зээлийн эдийн засаг өөрийн дотоод хуулиар хөгжихөд нь төрөөс дэмжин, тэнцвэртэй байдлаа хадгалах, тогтвортой өсөлтийг хангах, хямрал, эрсдэлд өртөхгүй дархлаатай байх нөхцөлүүдийг бүрдүүлэх эрхзүй, удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээг оновчтой авч байх төрийн зохицуулалтын механизмуудыг Монгол Улсын Үндсэн хуульд тусгасан байна.

<sup>1</sup> Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал. УБ., 2010 он.

<sup>2</sup> Монгол Улсын Үндсэн хууль. УБ., 1992 он. 5-ын 4 дүгээр заалт

<sup>3</sup> Монгол Улсын Үндсэн хууль УБ., 1992 он. 5-ын 1 дүгээр заалт

Эдийн засгийн хөгжилд нөлөөлж буй хүчин зүйлс өөрчлөгдөхийн хэрээр эдийн засгийн аюулгүй байдлын тодорхойлолт ч шинэчлэгдэж байдаг.

Оросын эрдэмтэн Л.И.Абалкин “Үндэсний эдийн засгийн тусгаар тогтнол, эдийн засгийн өсөлт хөгжил, бие даан хөгжиж дэвших чадвар нь эдийн засгийн аюулгүй байдлын мөн чанарыг илтгэгч үндсэн бүрэлдэхүүн болно”<sup>4</sup> гэж тодорхойлсон байна.

Америкийн эрдэмтэн Марк Рупертийн засгийн аюулгүй байдал нь тухайн улс гадаад харилцаа, холбоог өргөжүүлэх замаар эдийн засгийн өсөлт хөгжлийг хангах, дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвартай байх явдлаар тодорхойлогдоно” гэж үзжээ. Барууны эрдэмтэд эдийн засгийн зөв харьцаатай тогтвортой хөгжил, эдийн засгийн гадаад харилцааг удирдах, оролцох түвшин, шинэ технологи нэвтрүүлэх чадвар зэрэг нь эдийн засгийн аюулгүй байдлын хэмжүүрийг тодорхойлно гэж үзсэн байна.

Манай улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд эдийн засгийн бие даасан байдлаа хангаж хөгжих, байгальд ээлтэй, хүний аюулгүй, амгалан амьдрах боломжийг бүрдүүлсэн тогтвортой хөгжлийн загварыг бий болгох нь эдийн засгийн аюулгүй байдлыг хангах үндсэн нөхцөл мөн гэж тодорхойлсон юм.

**“Эдийн засгийн аюулгүй байдал гэж дотоод нөөц бололцоогоо ашиглан нөхөн үйлдвэрлэл явуулах, ард түмнийхээ хэрэгцээг хангах, тусгаар тогтносон байдлаа бэхжүүлэх эдийн засгийн чадавхтай байх, шаардлагатай нөхцөлд улс орноо тодорхой хугацаагаар тэтгэж чадах эдийн засгийн бүтэц бүрдсэн байдлыг хэлнэ”.** “Эдийн засгийн аюулгүй байдал нь Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлын тулгуур үндэс мөн”<sup>5</sup> хэмээн тодорхойлсон байна.

Олон улсын эдийн засгийн тогтолцооны хүрээнд үндэсний эдийн засгийн эзлэх байр суурийг бэхжүүлэх, дотоод, гадаад эх үүсвэрийг оновчтой хослуулан харьцангуй бие даасан шинжтэй аж ахуйн бүтцийг бүрдүүлэх нь тухайн орны эдийн засгийн аюулгүй байдлын гол чиглэл болно.

Үндэсний эдийн засгийн аюулгүй байдал алдагдвал улсын тусгаар тогтнол, язгуур ашиг сонирхол хохирч, гадаад хүчин зүйлсээс шууд шалтгаалан эдийн засаг хараат байдалд орох аюултай. Эдийн засгийн хараат байдал гэж нийгэм, эдийн засгийн хөгжилд стратегийн чухал ач холбогдолтой үйлдвэрлэл, бүтээгдэхүүн, ажил үйлчилгээг бие даан явуулж чадахгүйд хүрч, улмаар санхүүгийн нөөц хуримтлалгүй болсны улмаас нийгмийн нөхөн үйлдвэрлэлийн нөхцөлийг хангаж

<sup>4</sup>Абалкин.Л Экономическая безопасность России: угрозы и их отражение, 47 дахь тал

<sup>5</sup> Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, 2010

чадахаа больж, эдийн засгаа тогтвортой хөгжүүлэх найдвартай суурь бүрдүүлж чадаагүйгээс бусад улс орон болон эдийн засгийн бүлэглэлийн хараат байдалд орох үйл явцыг хэлнэ.

Эдийн засгийн аюулгүй байдлын үндсэн бүрэлдэхүүн хэсгүүдийг дараах 1 дүгээр зургаар тодорхойлж болно.



1 дүгээр зураг. Эдийн засгийн аюулгүй байдлын үндсэн бүрэлдэхүүн

Дээрх зургаас үзэхэд, эдийн засгийн аюулгүй байдлын үндсэн бүрэлдэхүүн хэсэг нь макро эдийн засгийн бодлого, микро эдийн засгийн бодлого, эдийн засгийн салбарын эрх зүйн зохицуулалт гэсэн 3 хэсэгт тулгуурлана.

### **Бүрэлдэхүүн хэсэг тус бүрийн товч тайлбарыг авч үзье.**

Эдийн засгийн аюулгүй байдлын объект гэдэг нь аюул заналд өртөж болзошгүй тусгагдахууныг ойлгоно. Эдийн засгийн аюулгүй байдлын объектын олон хэлбэрүүдэд: иргэн, хувийн ба улсын үйлдвэр, үйлдвэрлэлийн нөөц, стратегийн бүтээгдэхүүн, үндэсний эдийн засаг, улс гүрэн, олон улсын тогтолцоо хамаарна.

Эдийн засгийн аюулгүй байдлын субъект нь объектод чиглэгдсэн эх үүсвэрийн идэвхтэй байдал ба нийгэм-эдийн засгийн өсөлт хөгжил, тогтвортой байдалд нөлөөлөх үндсэн хүчин зүйл болдог. Энд Засгийн газар нийгэм эдийн засгийн бодлого боловсруулах, хууль санаачлах, хэрэгжүүлэх, шүүх засаглалд

оролцох эрхтэйгээр эдийн засгийн аюулгүй байдлын субъект болдог. Түүнчлэн иргэн, байгууллага, улс орон, бүс нутгийн тогтолцоо нь эдийн засгийн аюулгүй байдалд нөлөөлөгч субъектын үүргийг гүйцэтгэнэ. Заримдаа судалгааны объект нь субъект болох тохиолдол байна.

Бүс нутаг нь нэг талаас улсын эдийн засгийн аюулгүй байдлыг хангах үйл явцын гол объект болдог бол нөгөө талаас бүс нутаг өөрөө эдийн засгийн бодлогыг хэрэгжүүлэгч бие даасан субъект болох нь бий. Субъектийн объектод чиглэгдсэн эх үүсвэрийн нөлөөлөл, түүний үр дүнтэй байдал нь улсын эдийн засгийн аюулгүй байдалд нөлөөлөх гол хүчин зүйл болдог.

Төрийн санхүү-мөнгөний бодлого, гадаад харилцаа, нийгмийн хамгааллын бодлого зэрэг нь субъектын үйл ажиллагааны идэвхтэй хэлбэр болно. Дээр дурдснаас үзвэл улсын эдийн засгийн аюулгүй байдалд объектив, субъектив шинжтэй хүчин зүйлс нөлөөлж байна.

Эдийн засгийн аюулгүй байдлын хүчин зүйл, Батлан хамгаалах ашиг сонирхол чадавхад нөлөөлөх онол, аргазүйн үндсийг тодруулахын тулд нэр томъёоны тодорхойлолт, тэдгээрийн уялдаа холбоог авч үзэх нь зүйтэй юм.

**“Батлан хамгаалах”** гэж Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг гадны зэвсэгт халдлага, түрэмгийллээс хамгаалахад улсын бэлэн байдлыг хангах, хамгаалах зорилго бүхий улс төр, эдийн засаг, нийгэм, эрх зүй, мэдээллийн болон цэргийн нэгдмэл арга хэмжээг<sup>6</sup> хэлдэг.

**Батлан хамгаалах үйл ажиллагаа нь** үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны бүрэлдэхүүн хэсэг бөгөөд Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, хил хязгаарын халдашгүй дархан байдлыг хангах, хамгаалах зорилго бүхий улс төр, эдийн засаг, нийгэм, эрх зүй, цэргийн арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх нэгдмэл удирдлага, зохион байгуулалт, зохицуулалтын цогц мөн<sup>7</sup>

Батлан хамгаалах асуудал нь нийт улс орон, байгууллага, айл өрх, хувь хүн бүрт хамааралтай хэн бүхний анхаарлын төвд ямагт байдаг нэн чухал тулгамдсан асуудал юм. Өөрөөр хэлбэл гадны болзошгүй аюул занал буюу бусад улс орны зүгээс хүч хэрэглэж болзошгүй байдлаас өөрийн улсын нутаг дэвсгэр, иргэд, материаллаг болон оюуны үнэт зүйлсийг хамгаалах явдлыг бэхжүүлэхэд чиглэсэн улс орны үйлдэл юм. Орчин үед дайны аюул занал бүрэн арилаагүй учраас улс

<sup>6</sup> “Монгол улсын батлан хамгаалах бодлогын үндэс” 2.1 дүгээр заалт

<sup>7</sup> “Монгол улсын батлан хамгаалах бодлогын үндэс” 2.1 дүгээр заалт

орны Батлан хамгаалах зорилтын эдийн засгийн үндсийг хангах чиглэлд бодит алхам хийх асуудал хурцаар тавигдаж байна.

**Монгол Улсын батлан хамгаалах бодлого нь** Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд заасан үндэсний язгуур ашиг сонирхолд тулгуурлах бөгөөд улсын дотоод, гадаад аюулгүй байдлын орчин нь батлан хамгаалах зорилго, зарчим, чиглэлийг тодорхойлох үндэс болно<sup>8</sup>. Тухайлбал, батлан хамгаалах бодлого нь ҮАБ-ын бодлогын бүрэлдэхүүн хэсэг, улс орноо гадны зэвсэгт халдлагаас хамгаалах, түүний бэлтгэлийг хангах үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тодорхойлдог төрийн бодлого байна. Эдийн засгийн арга замаар батлан хамгаалах зорилтыг хангах нь төрийн нэг чухал үүрэг юм.

**“Батлан хамгаалах чадавх”** гэж улсын эдийн засаг, хүн амын эрүүл мэнд, боловсрол, төрийн цэргийн байгуулал, мэдээллийн болон улс төр-дипломатын чадавхын нэгдлийг<sup>9</sup> хэлнэ.

**Төрийн эдийн засгийн бодлого нь** нийгэм эдийн засгийн хэрэгцээг хангах талаар аж ахуй эрхлэгч байгууллагуудын хоорондын харилцааг хангах системийг хамран эдийн засгийн цогц бодлогыг шийдэх оновчтой арга замыг хайхад гол үүрэг гүйцэтгэдэг.

Сүүлийн үед манай зарим судлаачид "мэдлэгт суурилсан эдийн засгийг байгуулна" гэж ихээхэн ярих болжээ. Гэвч ямар тооцоо, судалгаанд үндэслэж эдийн засгийн бүтцийг сайжруулж мэдлэгт суурилсан хэлбэртэй эдийн засаг болгоно хэмээн төлөвлөхөд хүргэж байгаа нь тодорхойгүй байна.

**Мэдлэгт суурилсан эдийн засаг гэдэг нь** (хамгийн энгийнээр хэлбэл) эдийн засгийн өсөлтөд технологийн дэвшил, мэдлэг боловсролыг бүрэн дүүрэн оролцуулж, эдгээрээс шалтгаалдаг өндөр технологийн бүтээгдэхүүн, үйлдвэрлэл эскпорт болон дотоодын нийт бүтээгдэхүүний ихэнх хувийг эзэлдэг байхыг хэлнэ<sup>10</sup>. Өөрөөр хэлбэл тухайн эдийн засгийн үйлдвэрлэж буй бүтээгдэхүүн, үйлчилгээний ихэнх хэсгийг өндөр технологийн бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, үйлчилгээ эзэлдэг байх, түүнийгээ бусад оронд экспортолдог байх, хөдөлмөрийн зах зээл нь өндөр ур чадвартай, нарийн мэргэшсэн, өндөр боловсролтой ажиллах хүчтэй байх, улс орон нь технологийн хөгжил, боловсролоороо тэргүүлэгч байх шаардлагатай юм. Дараах хүснэгтэд Татяана Субботинагийн “Beyond economic growth” номонд

<sup>8</sup> Мөн тэнд 1.1 дүгээр заалт

<sup>9</sup> Монгол Улсын Батлан хамгаалах тухай, (шинэчилсэн найруулга) 3.1.2

<sup>10</sup> А.Заяадэлгэр “Боловсролын эдийн засаг”. УБ., 2011. х-118.

дүрсэлсэн эдийн засгийн хөгжлийн үе шатын талаарх таамаглалыг 1 дүгээр хүснэгтэд үзүүлэв.

1 дүгээр хүснэгт

Эдийн засгийн хөгжлийн үе шат

Шинж чанар	Үйлдвэржилтийн өмнөх	Үйлдвэржилтийн	Үйлдвэржилтийн дараах буюу мэдлэгт суурилсан
Эдийн засгийн тэргүүлж буй сектор	Хөдөө, аж ахуй	Үйлдвэр	Үйлчилгээ
Гол технологийн шинж	Хөдөлмөр-байгалийн нөөц	Биет капитал	Мэдлэг
Гол нэрийн хэрэглээний бараа	Хүнс гар хийцийн хувцас	Үйлдвэрлэлийн бараа, бүтээгдэхүүн	Мэдээлэл, мэдлэгийн үйлчилгээ
Ихэнх үйлдвэрлэлийн үйл явцын шинж чанар	Хүн-Байгалийн үйл ажиллагаа	Хүн-машины үйл ажиллагаа	Хүн-хүний үйл ажиллагаа
Эдийн засгийн өсөлтийн болон баялаг бүтээж буй гол хүчин зүйл	Байгалийн баялаг/ Байгалийн бүтээмж (Хөрсний үржил шим, биологийн нөөц, цаг агаар)	Ажиллах хүчний бүтээмж	Инноваци /оюуны бүтээл

Эх сурвалж: Soubbotiona (2004). "Beyond economic growth"., 2<sup>nd</sup> ed, Word Bank

Мэдлэгт суурилсан эдийн засгийн гол шинж чанарт:

- Эдийн засгийн тэргүүлэх сектор нь үйлчилгээний салбар байх,
- Үйлдвэрлэл, үйлчилгээний гол технологи нь мэдлэг байх,  
Гол нэрийн хэрэглээний бараа нь мэдлэг, мэдээлэл байх,
- Ихэнх үйлдвэрлэлийн үйл явцын шинж чанар нь хүн-хүний үйл ажиллагаа байх,
- Эдийн засагт баялаг бүтээж буй гол хүчин зүйл нь инноваци, оюуны бүтээл байх зэрэг багтана.

"Мэдлэгт суурилсан эдийн засагт байгуулах" нь тийм хялбар зорилт биш. Эдийн засгийн өнөөгийн ийм хөгжлөөс шууд мэдлэгт суурилсан эдийн засагтай улс орныг байгуулах нь богино болон дунд хугацаанд боломж бага юм. Улс орон хөгжлийнхөө хүрэх түвшнийхээ болон өнөөгийн эдийн засгийн байдлын талаар бодитой дүгнэлт хийж зөв зорилтыг зөв цаг хугацаанд дэвшүүлэх хэрэгтэй<sup>11</sup>.

Эндээс эдийн засаг хөгжих тусам байгалийн баялаг, хүний биеийн хөдөлмөрийг хэрэглэх хэлбэрээс татгалзаж, хүний оюун ухааныг хэрэглэх хандлага руу явж байна гэж дүгнэж болно. Хөгжил муутай эдийн засаг хөдөө аж ахуй, байгалийн баялагт тулгуурлан хөгждөг бол хөгжилтэй эдийн засагт Оюутолгой, Таван толгой,

<sup>11</sup> А.Заяадэлгэр "Боловсролын эдийн засаг". УБ., 2011. х-117.

Эрдэнэт толгой (Эрдэнэтийг мөн дээр үед буюу ашиглахаас өмнө ингэж нэрлэдэг байжээ) зэрэг орд тийм ч их хэрэгтэй биш байдаг бололтой.

Хөдөө аж ахуй, олборлох үйлдвэрлэлийн салбар дотоодын нийт бүтээгдэхүүний 44 орчим хувийг үйлдвэрлэж байгаа учраас эдгээр салбарыг манай эдийн засгийн тэргүүлэгч салбар гэж үзэж болно. Гол технологийн шинж чанараар хөдөлмөр-байгалийн нөөцийг илүү ашигладаг гэж үзвэл үйлдвэржилтийн өмнөх, харин гол нэрийн хэрэглээний барааны шинж чанараар үйлдвэрлэлийн бараа, бүтээгдэхүүн илүү хэрэглэдэг гэж үзвэл үйлдвэржилтийн шатанд явж байна. Гэвч хэрэглээний барааны ихэнхийг экспортоор авдаг бол хүнс, гар хийцийн хувцас гол төлөв хэрэглэдэг гэсэн шинж чанартай болж магадгүй. Мөн дийлэнх үйлдвэрлэлийн үйл явц хүн-байгалийн, харин үлдэх хэсэг нь хүн-машины үйл ажиллагаагаар явагддаг гэж таамаглаж байна. Эдийн засгийн буюу баялаг нэмж бүтээж буй гол хүчин зүйлийн шинж чанараар бол эргэлзээгүй үйлдвэржилтийн өмнөх шатанд байгаа юм байна.

Мэдлэгт суурилсан эдийн засгийг байгуулж байгаа гэж тооцогдож буй улс орны дотоодын нийт бүтээгдэхүүний бүтцийн ихэнх хэсэг нь өндөр технологийн бараа, үйлчилгээний экспорт, хөдөлмөрийн зах зээлийн бүтцийн ихэнх хэсэг нь мэргэжилтэй ажиллах хүчин байдаг. Мэдлэгт суурилсан эдийн засаг байгуулж байна гэж зарлаагүй орнуудын хувьд ч судалгаа хөгжлийн үзүүлэлтүүд эрс нэмэгдэж байгаа тухай судлаачид бичжээ. Сүүлийн 10 жилд өндөр технологийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспорт Европын орнуудад 2 дахин, Хятад улсад 4 дахин нэмэгджээ. Мөн технологийн хөгжлийг даган өндөр технологийн үйлдвэрлэлийн төрөл өөрчлөгдсөөр байна.

Улс төрийн тогтвортой байдал, улс гүрний тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, гадаад ба дотоод аюул заналхийллийн нөлөөллийг эсэргүүцэх чадвар, нийгэм эдийн засгийн байдалд тэсвэртэй байх чанар ЭЗАБ-ыг хангаж байгаа үнэлэмжээр тухайн улс орны эдийн засгийн батлан хамгаалах чадамжийг тодорхойлдог.

**Эдийн засаг нь** Зэвсэгт хүчний хөгжил, зэвсэгт тэмцлийн хэлбэр, арга барил, дайны шинж байдал, түүнийг байршуулах боломж, үргэлжлэх хугацаа, явц болон төгсгөлд олон талын нөлөө үзүүлдэг. Төр нь үндэсний стратегийн зорилго, чиглэлийн дагуу санхүүгийн механизмаар дамжуулан мөнгөн санхүүг бүрдүүлж ашиглана.

Улс орны санхүүгийн боломж, стратегийн төлөвлөлтийн үндэслэл, шаардагдах хөрөнгийн тооцоо, тэдгээрт тохирсон Зэвсэгт хүчний санхүүжилт

зэргийг тооцохгүйгээр үндэсний стратегийн зорилго, чиглэлийг амжилттай хэрэгжүүлж чадахгүй. Улс орны Батлан хамгаалах ба аюулгүй байдлыг хангахад материалын болон хүний нөөцийн зардал шаардагдана. Улс орныхоо эдийн засгийг болон дайны эдийн засгийн далд зорилго, агуулга, мөн чанар зэргийг зөв танин мэдэх нь цэргийн эдийн засгийн ухааны онол, арга зүйн ойлголтоор илэрхийлэгдэх бөгөөд практикт дайны ялалт, ялагдал нь эдийн засгийн учир шалтгаанаар тодорхойлогддог байна.

Батлан хамгаалах эдийн засгийн чадавх (БХЭЗЧ) -ын тухай ойлголтыг авч үзэхийн тулд “чадавх” буюу “potential” гэдэг үгийн агуулгыг авч үзвэл чадавх, чадамж, боломж, бололцоо гэсэн үг бөгөөд потенциал гэдэг нь аливаа салбарт байгаа боломж хэрэгслийн цогц. Тухайлбал, улс орны эдийн засгийн чадавх. Энэ нь тайван цагт болон дайн байлдаан явуулахад хэрэгцээтэй эдийн засаг, улс төр, сэтгэлзүйн болон цэргийн нөөц боломжийн цогц юм.

**Батлан хамгаалах эдийн засгийн чадавх** гэдэг нь аливаа улс орны улс төр, БХ зорилтыг шийдвэрлэх зорилгоор улсын эрх ашигт ашиглагддаг, ашиглаж болох эдийн засгийн чадавхын бүрэлдэхүүн хэсэг нь юм. БХЭЗЧ нь улс орны тайван цагийн болон дайны үеийн эдийн засгийн хангалтад түүний дотор ЗХ-ний хэрэгцээнд хүрэлцэхүйц цэргийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн боломжит дээд хэмжээний цогц ойлголт юм.

БХЭЗЧ нь улс орны улс төр, эдийн засгийн тогтвортой байдал, хөгжлийн түвшин, шинжлэх ухаан, технологи, инновацийн менежмент зэргээс хамаарч тэдгээрт тулгуурлах нь тодорхой байна. ЭЗАБ, Батлан хамгаалах ашиг сонирхол чадавхад нөлөөлөх зүй тогтлыг дараах байдлаар авч үздэг.

БХЭЗЧ-д нөлөөлөгч дотоод, гадаад хүчин зүйлс нь:

**а. Дотоод хүчин зүйлс:**

- Улс төрийн хүчин зүйлс /улс төр, засаглалын чадавх, төрийн захиргааны аппарат/
- Нийгэм соёлын хүчин зүйлс /түүх соёлын уламжлал, шашин шүтлэг/
- Эдийн засгийн хүчин зүйлс /уламжлалт аж ауй, олон талт эдийн засгийн бүтэц, үйлдвэрлэх хүчний хөгжил, эдийн засгийн субъектүүдийн харилцаа/
- Хүн амын өсөлт /тоо, чанар, боловсрол, хүмүүжил, төлөвшил, эх оронч үндэсний үзэл, ЗХ-ний бие бүрэлдэхүүний мэргэжлийн чадвар, дайчилгааны нөөц/



- Шинжлэх ухаан, технологийн хүчин зүйлс /технологи дамжуулалт, нутагшуулалт, эзэмшилт, шинэ технологи зохион бүтээх, хуучныг шинэчлэн сайжруулах инноваци/
- Байгаль экологийн хүчин зүйлс /байршил, нутаг дэвсгэрийн хэмжээ, цаг агаар, уур амьсгал/ зэргээр нөхцөлдөнө.

#### **б. Гадаад хүчин зүйлс:**

- Гадаад худалдаа эдийн засгийн хамтын ажиллагаа.
- Олон улсын валют санхүүгийн харилцаа.
- Гадаад улс орон, олон улсын байгууллагаас хэт их өрийн дарамтад орох.
- Стратегийн ач холбогдолтой экспортын бүтээгдэхүүний өөрчлөлт, стратегийн ач холбогдолтой салбарт гадаадын хөрөнгө оруулагчийн нөлөө өсөх.

Улс орны эдийн засгийн БХ чадавхын төлөвийг нийгэм, улс төрийн тогтвортой байдал, улс гүрний тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, гадаад ба дотоод аюул заналхийллийн нөлөөллийг эсэргүүцэх чадвар, нийгэм эдийн засгийн байдалд тэсвэртэй байх чанар, эдийн засгийн аюулгүй байдлыг хангаж байгаа зэрэг үнэлэмжээр тодорхойлж болох юм. Аливаа улс орныг Батлан хамгаалах ямар ч хувилбар байсан энэ нь зөвхөн эдийн засгийн боломж чадавхаас хамаарч түүнд тулгуурлах болно. Мөн улс орны эдийн засгийн хэвшилд гарсан хувьсал, өөрчлөлт нь БХЭЗ-ийг бүрдүүлэн бэхжүүлэх арга замыг шинэчлэх үндэс болдог.

**Улс үндэсний Батлан хамгаалах эрх ашигт заналхийлэх утгаар нь:** ажилгүйдэл, ядуурал, төсвийн алдагдал, өвчин тахлын тархалт, мансууруулах бодис, зэвсгийн наймаа, цөмийн болон үй олноор хөнөөх зэвсэг, бусад зэвсэг, тийм хөнөөх хэрэгсэл үйлдвэрлэх нууц алдагдах, олон улсын терроризм, үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг, байгаль экологийн сүйрэл, зэргийг аюул заналд тооцон ойлгоно.

Эдийн засгийн хямрал, хүнсний бүтээгдэхүүний чанарын асуудал, үнийн өсөлт, тэрчлэн гадаад ертөнцтэй холбосон нийгэм эдийн засгийн хамтын ажиллагаа, хүрээлэн буй орчны асуудал зэрэг нь аюулгүй байдлын цэргийн бус хүчин зүйлд нухацтай анхаарахыг шаардаж байна.

Батлан хамгаалах эрх ашиг, ЭЗАБ, БХЭЗ-т нөлөөлөх үндсэн хоёр хүчин зүйл байна. **Нэгдүгээрт**, үндэсний эдийн засгийн хөгжлийн түвшин, өрсөлдөх чадвар. **Хоёрдугаарт**, дэлхийн олон улсын зах зээл дээр эзлэх байр суурь, улс орнуудын өрсөлдөөний түвшин юм.

Өрсөлдөх чадвар нь өргөн агуулгатай ойлголт бөгөөд эдийн засгийн тогтвортой байдлыг хангах үндсэн хүчин зүйл болдог. Хөгжлийн тогтвортой байдлаа хадгалахын тулд аль ч орон дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвартай байж байр сууриа бэхжүүлэх шаардлагатай юм.

БХЭЗЧ-ын үзүүлэлтийн босго утгыг гадаад, дотоод хүчин зүйлээр үнэлж дүгнэнэ. Иймд ЭЗАБ, БХЭЗЧ-ыг хангахын тулд дэлхий нийтийн хөгжлийн хандлага, тухайн орны өвөрмөц онцлог харьцангуй давуу талд тулгуурласан стратеги, тактик, төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх шаардлагатай.

*Өнөөдөр манай БХЭЗЧ-ын хүрээнд дараах нийтлэг аюул заналууд бий болсон гэж үзэж болно. Үүнд:*

- Газрын тос, хүнс, өргөн хэрэглээний барааны **импортоос хамааралтай, түүхий эдийн экспорт голлосон байна.**
- Байгалийн баялаг, гадаадын хөрөнгө оруулалтад тавих **хяналт алдагдсан**, үндэсний үйлдвэрлэл, хөдөлмөрийн **нөөц доройтсон байна.**
- Улсын байгалийн баялагийн төлөөх өрсөлдөөн нь **геополитикийн шинэ эрсдэл** бий болгож байна.
- Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжихдээ төрийн зохицуулалтыг алдагдуулж үйлдвэрлэлийн үндсэн фондыг **өмч хувьчлалаар үрэгдүүлэн** доройтуулсан байна.
- Эдийн засгийн бие даасан байдал хангагдаагүй, стратегийн хүнс, бараагаар өөрийгөө хангаж чадахгүй, гадаад зах зээл, ялангуяа хөрш орнуудаас ихээхэн **хамааралтай** хэвээр байна.
- Үнийн өсөлтөд өртөмтгий, хэт **өрөөсгөл бүтэцтэй** хэвээр байна.
- Хүнд суртал, авилга, монополь ноёрхсон бизнес давамгайлж, шударга өрсөлдөөн, хөрөнгө оруулалтын **орчин тогтворгүй** байна.

Батлан хамгаалах бодлогын эдийн засгийн чиглэл нь Монгол Улсын тогтвортой хөгжлийг хангаж, Батлан хамгаалах чадавхыг бэхжүүлэхэд чиглэнэ<sup>12</sup>.

Монгол Улсын эдийн засгийн бодлого, төлөвлөлт, стратегийн ач холбогдолтой уул уурхай, үйлдвэрлэл, дэд бүтцийг хөгжүүлэх, гадны хөрөнгө оруулалт, ажиллах хүчийг ашиглах үйл ажиллагааг үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах эрх ашигт нийцүүлж байна<sup>13</sup> гэж заасан байна. Дээрх байдал нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын Батлан хамгаалах бодлогын үндэс баримт бичгүүдэд тусгалаа олсон байна.

<sup>12</sup> “Монгол улсын батлан хамгаалах бодлогын үндэс” 4.1 заалт

<sup>13</sup>Мөн тэнд

Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” –д “Монгол Улс 2030 онд нэг хүнд ногдох орлогоороо дунд орлоготой орнуудын тэргүүлэх эгнээнд хүрсэн, тогтвортой өсч байгаа эдийн засгийн олон салбартай, нийгмийн хүрээнд дундаж болон чинээлэг дундаж давхарга давамгайлсан, экологийн тэнцвэртэй байдлыг хадгалсан, тогтвортой ардчилсан засаглалтай улс болно”<sup>14</sup> гэсэн билээ.

Чухамхүү өнөөгийн байдлаар манай улсын эдийн засгийн хөгжил, аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж буй гадаад, дотоод хүчин зүйлсийг дараах байдлаар тодорхойлж болно. Үүнд:

**1. Гадаад хүчин зүйлс:**

а. стратегийн ач холбогдол бүхий экспортын бүтээгдэхүүний үнэ унах, зах зээлээ алдах;

б. гадаад орны түүхий эдийн нийлүүлэгч, хавсарга болох, экспортод байгалийн баялаг, түүхий эд зонхилох байр суурь эзлэх;

в. стратегийн ач холбогдолтой бүтээгдэхүүн, хүнсний бүтээгдэхүүний импортоос дотоодын эдийн засаг хамааралтай болох;

г. гадаад улс орон, олон улсын байгууллагаас хэт их өрийн дарамтад орох;

д. стратегийн ач холбогдолтой салбарт гадаадын хөрөнгө оруулагчийн нөлөө өсөх.

**2. Дотоод хүчин зүйлс:**

а. үндэсний үйлдвэрлэл, боловсруулах үйлдвэрлэл уналтад орох;

б. монгол малын удмын сан, сүргийн бүтцийн тэнцвэртэй харьцаа алдагдах;

в. газар тариалангийн салбар уналтад орох, хүнсний аюулгүй байдал алдагдах;

г. уул уурхайн салбарын хөгжил хоцрогдох, зөвхөн олборлох, тээвэрлэх технологи нэвтрэх;

д. дэд бүтцийн хөгжил хоцрогдох;

е. төрийн санхүүгийн бодлогын үр ашиг буурах, төсвийн алдагдал өсөх;

ё. банкны салбар хямралд орох, инфляцийн түвшин нэмэгдэх;

ж. ядуурал гүнзгийрэх зэрэг сөрөг нөлөөтэй хүчин зүйлсийг дурдаж болно.

Манай улсын эдийн засгийн хөгжил, аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж буй гадаад, дотоод хүчин зүйлсүүдийг аль болох багасгах талаар оновчтой бодлого баримтлах нь харагдаж байна.

---

<sup>14</sup> Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”

## 1.2. Батлан хамгаалахын төсвийн мөн чанар, үүрэг

Улсын төсөв бол улс орны санхүүгийн системийн чухал элемент юм. Үүний хамт улсын санхүүгийн системд Батлан хамгаалах ба аюулгүй байдлын ашиг сонирхолд ашиглах мөнгөн хөрөнгийн сан болох батлан хамгаалах санхүү багтдаг. Улс орны Батлан хамгаалах ба аюулгүй байдлыг хангахад материалын болон хүний нөөцийн зардал шаардагдана. Энэ нөөцийг Батлан хамгаалах ба аюулгүй байдлын хүрээнд татах гол нөхцөл бол Батлан хамгаалах хэмээх ойлголтод багтдаг мөнгөн хөрөнгийн зохих санг бүрдүүлэх ашиглах явдал мөн. Батлан хамгаалахын төсөв бол хуулийн хүрээнд санхүүгийн жилийн турш цэргийн зардалд төсөвлөсөн улсын төсвийн бүрэлдэхүүн хэсэг юм.

Батлан хамгаалахын төсөв нь **нэгдүгээрт**, цэргийн хэрэгцээг хангахад цэргийн бүтээгдэхүүний хэсгийн үнийн илэрхийлэл болно. **Хоёрдугаарт**, Батлан хамгаалах удирдах байгууллага, батлан хамгаалах аж үйлдвэрийн цогцолборууд, БХ-ын салбаруудын хооронд санхүүгийн хэрэгслийг дахин хуваарилах хэрэгслийн үүрэг гүйцэтгэдэг. **Гуравдугаарт**, Батлан хамгаалахын төсөв нь улс орны санхүүгийн системд голлох үүрэгтэй байдаг. **Дөрөвдүгээрт**, Батлан хамгаалахын төсөв Батлан хамгаалах эдийн засгийг бэхжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэнэ.

### ***Батлан хамгаалахын төсвийн мөн чанар, үүргүүд нь:***

- Батлан хамгаалахын төсөв нь эх орноо батлан хамгаалахад бэлтгэх, болзошгүй үед дайныг явуулах зорилгод мөнгөн хөрөнгийг дайчлах, үндэсний орлогыг дахин хуваарилах хэрэгсэл болдог. Улсын мөнгөн санд татвар хураах замаар үндэсний орлогын дахин хуваарилалтыг хэрэгжүүлнэ.
- Татварын орлогын зэрэгцээ улсад бэлэн мөнгөний нөөцийг татах бас нэг чухал хэрэгсэл бол улсын зээл юм. Дараа нь улс зээл ба зээлийн хүүгээ төлөхдөө татварыг ашигладаг тул зээл татвар хоёр нягт харилцан уялдаатай. Зарим жил, ялангуяа улсад орж буй татварын хэмжээ зардлыг нөхөхөд хүрэлцэхгүй, зээл авах боломж бага байдаг. Дайны жилүүдэд улс мөнгөний эмисс хийж эхэлдэг.
- Дайнд бэлтгэх ба дайн явуулахын тулд мөнгөн хөрөнгө татан авч, дахин хуваарилах төр засгийн чадвар нь түүний батлан хамгаалах эдийн засгийн хүчин чадлын маш чухал үзүүлэлт юм. Хэдийгээр санхүү, түүний дотор цэргийн төсөв нь материаллаг үйлдвэрлэлийг бодвол хоёрдогч шинжтэй

боловч тэд дайны бэлтгэл ба дайны явцын хангалтын жирийн нэг хэрэгсэл биш.

- Батлан хамгаалахын төсөв нь улсын сан хөмөргөөс мөнгөн хөрөнгө татан авч, дайны хэрэгцээнд шилжүүлэн зарцуулах замаар эдийн засаг өөрт нь идэвхтэй хариу үйлчлэл үзүүлдэг.
- Батлан хамгаалахын төсөв энэ бол БХ ба ЗХ-ний эдийн засгийн арга хэмжээний санхүүгийн эх үүсвэр.

Батлан хамгаалахын төсвийг бүрдүүлснээр төр засагт мөнгөн хөрөнгийн сан бий болох бөгөөд үүнийг дайны бэлтгэл ба явцын хангалтад чиглүүлэн ашиглана. Энэ сан нь зэвсэглэл, цэргийн техник, батлан хамгаалахын материал-техникийн хангалтын бусад эд хэрэгсэл худалдан авах, ЗХ-ний бие бүрэлдэхүүнийг сургах, судалгаа шинжилгээ, зохион бүтээх ажил хийх, цэргийн объектууд барьж байгуулах, БХ-ын бусад үйл ажиллагааг санхүүжүүлэх зэрэгт зарцуулдаг. Батлан хамгаалахын төсөв бол батлан хамгаалах үйл ажиллагааг төрөөс зохицуулах хэрэгсэл. Батлан хамгаалахын үйлдвэрлэлийн хэмжээ ба ЗХ бүтэц, байршил, хөгжил, дайчилгааны боломж зэрэгт санхүүгийн төрөл бүрийн хөшүүрэг ашиглан төр нөлөөлдөг. Жил бүр төсвийн төсөл хэлэлцэхдээ хууль тогтоох байгууллага батлан хамгаалахын тодорхой хөтөлбөрүүдийг батлан, тэдгээрийг хэрэгжүүлэх хөрөнгийг төрөөс гаргах зөвшөөрөл өгдөг. Батлан хамгаалахын төсвийн бүтэц, хэмжээгээр батлан хамгаалахын бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг зохицуулах нь төрийн эдийн засгийн нөлөөллийн үндсэн арга юм.

Батлан хамгаалах арга хэмжээний зардлыг Монгол Улсын төсвөөс болон хуульд заасан бусад эх үүсвэрээс санхүүжүүлнэ. Энэ нь Батлан хамгаалах хэрэгцээг хангах эдийн засгийн чадавхыг бүрдүүлнэ. Батлан хамгаалах төсвийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хэмжээг нэмэгдүүлэх бодлого баримтална<sup>15</sup>.

Батлан хамгаалахын төсөв нь батлан хамгаалахын бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг төдийгүй БХЭЗ-ийн материал-техникийн баазын хөгжлийг санхүүгийн хувьд хангана. Тухайлбал, улс төсвийн хөрөнгөөр улсын секторт тодорхой хэмжээний үйлдвэрлэлийн хүчин чадлыг бий болгоно. Цаашдаа түүний зарим хэсгийг хувийн секторт худалдах буюу хөнгөлөлттэй нөхцөлөөр түрээслэнэ. Ингэснээр батлан хамгаалахын үйлдвэрлэлийн баазын хөгжих нөхцөлийг хангаж, хувийн компаниудын цэргийн үйлдвэрлэл дэх оролцоог

---

<sup>15</sup>Монгол Улсын Их Хурлын 2015 оны 85 дугаар тогтоолын хавсралт, "Монгол Улсын Батлан хамгаалах бодлогын үндэс"

урамшуулан идэвхжүүлнэ. Улсын ба Батлан хамгаалахын төсөв харилцан нягт уялдаатай. Улсын төсвийн хэмжээ нь Батлан хамгаалахын төсвийн хэмжээг тодорхойлдог. Үүний хамт Батлан хамгаалахын төсөв нь үндэсний Батлан хамгаалах зардалд хуулиар хуваарилсан улсын төсвийн нэг хэсэг төдийгүй улсын батлан хамгаалахын бодлогыг хэрэгжүүлэх чухал хэрэгсэл юм.

Төр нь үндэсний стратегийн зорилго, чиглэлийн дагуу санхүүгийн механизмаар дамжуулан мөнгөн санхүүг бүрдүүлж ашиглана. Улс орны санхүүгийн боломж, стратегийн төлөвлөлтийн үндэслэл, шаардагдах хөрөнгийн тооцоо, тэдгээрт тохирсон ЗХ-ний санхүүжилт зэргийг тооцохгүйгээр үндэсний стратегийн зорилго, чиглэлийг амжилттай хэрэгжүүлж чадахгүй. Энэ тохиолдолд санхүү нь мөнгөн хөрөнгийг дайчлах, нөөц хуримтлуулах, улсын цэрэг-эдийн засгийн чадавхыг нэмэгдүүлэх хэрэгслийн үүрэг гүйцэтгэдэг.

Санхүү нь ЗХ-ний ар тал найдвартай ажиллах, аж ахуйн ба оператив-стратегийн төлөвлөлт амжилттай хэрэгжих чухал нөхцөл юм. Үүний сацуу стратеги нь төрийн санхүүгийн системд хариу үйлчлэл үзүүлдэг.

Стратеги нь улс орны санхүүг өөрийн хэрэгцээнд зохицохыг шаардаж, дайны ажиллагааг амжилттай явуулах нөхцөл бүрдүүлэхэд шаардлагатай санхүүгийн нөөцийг дайчилна. Дайн ба дайны стратегийн ажиллагааны хэлбэрийг төлөвлөхдөө улс орны санхүүгийн боломжид тулгуурлана. Стратегийн аливаа шийдвэрийг гаргахдаа үндэсний санхүүгийн систем ба сөргөлдөгч улсууд, эвслийн санхүүгийн чадавхыг тооцох шаардлагатай байдаг.

Батлан хамгаалахын байгуулалтын зохион байгуулалт, бүтэц, бүрдүүлэх систем болон бусад бүрдүүлэгч хүчин зүйлүүд нь улс орны санхүүгийн боломжоор тодорхойлогдоно. Санхүүгийн системийн байдал, ЗХ-ний санхүүжилт нь байлдааны ажиллагааны шинж чанар, өрнөлд шууд тусгалаа олдог.

Санхүүгийн үүрэг олон талтай. Тэрээр батлан хамгаалахын хэрэгцээ, ЗХ-ний тайван цагийн бэлэн байдал, түүнийг дайны цагт өргөжүүлэх асуудлыг хангаж байдаг. Дайнд бэлтгэх, дайныг явуулах, дайны аюулыг зайлуулах ажиллагааны бүх шатуудад санхүүгийн хэрэгслийн хэрэглээ өөрийн онцлогтой байдаг. Батлан хамгаалах зардлын санхүүжилтийн эх үүсвэр болон үндэсний аюулгүй байдлын санхүүгийн хангалтын ашигтай хувилбарыг эрж хайх нь батлан хамгаалах санхүүгийн бодлогыг хэрэгжүүлэх чухал асуудлын нэг хэвээр байна. Батлан хамгаалах зардлын эх үүсвэрийг эдийн засгийн ба санхүүгийн гэж хоёр хуваадаг. Дотоодын нийт бүтээгдэхүүн, үндэсний орлого, гадаад эдийн засгийн нөөц зэрэг нь Батлан хамгаалах зардлын эдийн засгийн эх

үүсвэрт чухал хамааралтай. Батлан хамгаалах зардлын санхүүгийн эх үүсвэрийг төсвийн ба төсвийн гадуурх эх үүсвэр гэж хуваана.

Дэлхийн ихэнх орнуудын Батлан хамгаалах зардлын санхүүгийн гол эх үүсвэр нь холбооны буюу улсын төсөв юм. Иймээс батлан хамгаалахын зардлын баталгаатай санхүүжилтийн механизм бүрдүүлэхийн тулд төсвийн эх үүсвэрийн тогтвортой байдлын асуудлыг шийдвэрлэхээс гадна зэвсэглэл, цэргийн техник зохион бүтээх, үйлдвэрлэлийн салбарт төсвийн гадуурх эх үүсвэрийг татах асуудлыг шийдвэрлэх шаардлага батлан хамгаалахын удирдлагын өмнө тулгардаг. Энэ нь батлан хамгаалах үйлдвэрлэлийг материал-техник, хүний нөөц, санхүү-зээлийн хувьд улсаас дэмжих эрх зүйн үндсийг баталгаажуулах орчин бий болгохыг шаарддаг. Батлан хамгаалах зардлыг нөхөхөд дотоод эх үүсвэрээс гадна гадаад эх үүсвэр багагүй үүрэгтэй. Үүнд гадаадын зээл ба батлан хамгаалах тусламж багтана.

Батлан хамгаалах зардал, түүний эх үүсвэр нь цэвэр батлан хамгаалах хүчин зүйл /зэвсэглэл, цэргийн техник, тактик-техникийн үзүүлэлт, тэдгээрийн шинэчлэл/-тэй холбоотойгоос гадна улс төрийн, эдийн засгийн, нийгмийн зэрэг бусад нөхцөл байдлаас шалтгаалдаг. Түүнчлэн тухайн улсын газар зүйн байрлал, хил, цаг агаарын нөхцөл, дэд бүтцийн хөгжил, байлдааны ажиллагааны талбарын онцлог зэргийг батлан хамгаалах зардлыг тооцохдоо харгалзан үзэх шаардлагатай юм.

Дайн байлдаанд шийдвэрлэх үүрэг оролцоотой нөлөөлөгч хүчин зүйлсийн дунд эдийн засаг онцгой байр суурь эзэлдэг. Материаллаг үйлдвэрлэлийн хөгжил, нийгмийн бүлгүүдийн хоорондох харилцааны шинж чанар, тэдгээрийн эдийн засгийн ашиг сонирхол нь дайн дэгдэх үйл явц тэдгээрийн зорилго, шинж чанар, эцсийн үр дүнд ямагт үлэмж нөлөөлсөөр иржээ. Дайнд ялалт байгуулах, ялагдахгүй байх материаллаг үндсийг бүрдүүлж шийдвэрлэх нөлөө үзүүлдэг хүчин зүйлсийн нэг бол яах аргагүй улс орны эдийн засаг юм. Улс орныхоо эдийн засгийн болон дайны эдийн засгийн далд зорилго, агуулга, мөн чанар зэргийг зөв танин мэдэх нь батлан хамгаалах эдийн засгийн ухааны онол, арга зүйн ойлголтоор илэрхийлэгдэх бөгөөд практикт аливаа ялалт, ялагдах нь эдийн засгийн учир шалтгаанаар тодорхойлогддог байна.

Батлан хамгаалахын эдийн засаг нь тухайн улсын хүч чадлыг бэхжүүлэх, ЗХ-ийг орчин үеийн зэвсэг, байлдааны техник хэрэгслээр хангах зэрэг өргөн хүрээтэй асуудлыг шийдвэрлэх материаллаг үндэс болдог. Энэ нь зохион байгуулалт-техникийн ба нийгмийн гэсэн хоёр талтай байна.

**а. Зохион байгуулалт-техникийн тал нь** батлан хамгаалахын бүтээгдэхүүнийг бэлтгэхэд шаардагддаг эд агуурсын ба хүний хүчин зүйлс үйлдвэрлэлийн процессын технологи зохион байгуулалт ЗХ-д хуваарилсан материаллаг нөөцийн ашиглалтын тогтолцоог өөртөө агуулж байна.

**б. Нийгмийн тал нь** улс орны нийгэм эдийн засгийн байгууллын бааз дээр бүрэлдэн буй болсон үйлдвэрлэлийн харилцаа болж байна. Энэхүү харилцааг ерөнхий эдийн засгийн шинжлэх ухаан, тусгай ба салбарын, салбар хоорондын эдийн засгийн ухааны оролцоо дэмжлэгт тулгуурлан байж танин мэдэх боломжтой байдаг. Дайныг явуулах материаллаг бааз болон эдийн засгийн үүрэг үйлдвэрлэх хүчин хөгжих хэрээр улам хүчтэй болдог. Тухайлбал ган хайлуулах, шинэ материал үйлдвэрлэх, атомын эрчим хүч ашиглах, хими, нано технологийн шинэ аж үйлдвэр хөгжих зэрэг эдийн засгийн салбар дахь шинэ арга, технологи нь зэвсэглэл, техникийг шинэчлэх, чанаржуулах, байлдааны боломж, чадавхыг олон дахин нэмэгдүүлэхэд хүргэдэг. Хүнд хөнгөн үйлдвэрүүдийн олон салбар, төрөл амжилттай хөгжсөнөөр ЗХ-ний бие бүрэлдэхүүнийг хувцас, хоол хүнс, нэг бүрийн зэвсэглэлээр хангаад зогсохгүй анги, салбаруудыг олон зуун нэр төрлийн зэвсэг, байлдааны техник, шинэ загварын нэр төрлөөр хангах боломжийг олгодог байна. Түүнчлэн улс орны аж үйлдвэрийн хөгжлийг дагаад хүн амын соёл, боловсрол, техник, технологийн мэдлэгийн түвшин дээшилж нийгмийн хөдөлмөрийн бүтээмж өсдөг байна.

Батлан хамгаалахын - эдийн засгийн хэрэгцээ гэдэг нь улс орныг цэрэг, зэвсгийн хүчээр хамгаалахад шаардагдах материаллаг эдийн засгийн хэрэгцээний нийлмэл юм. Дайны хэрэгцээг материал хэрэгсэл, хүн хүч, мэдээллээр хангах нь улсын батлан хамгаалах эдийн засгийн хэрэгцээг хангаж байна гэсэн үг. Улсын батлан хамгаалах эдийн засгийн хэрэгцээ зөвхөн ЗХ-ний зэвсэглэл, байлдааны техник болон зэвсэгт тэмцлийн бусад хэрэгслийн хэрэгцээгээр хязгаарлагдахгүй. Батлан хамгаалахын хэрэгцээг дараах байдлаар авч үзэж болох юм. Үүнд:

- батлан хамгаалах бэлэн бүтээгдэхүүний хэрэгцээ;
- хөрөнгө ба хөрөнгө оруулалтын хэрэгцээ;
- батлан хамгаалахын мэргэжилтэй боловсон хүчин ба тэдний цалингийн хэрэгцээ гэх мэт.

Тайван болон дайны цагт ЗХ-д хэрэглэгддэг цэргийн зориулалтын бүх төрлийн бараа материалыг бэлэн бүтээгдэхүүн гэдэг. Батлан хамгаалахын зориулалттай бэлэн бараа материалыг хоёр хувааж болно.



**Нэгдүгээрт**, ЗХ-ний техник хангамжийн байдлыг харуулах материаллаг үндэс болдог байлдааны зэвсэг техник, тэмцэл явуулах хэрэгслүүд.

**Хоёрдугаарт**, ЗХ-ний бие бүрэлдэхүүний амьдрал үйл ажиллагааны хэрэгцээт бараа бүтээгдэхүүн, тоноглол, хувцас хэрэглэл, хоол хүнс, эм, ороох боох материал гэх мэт.

Батлан хамгаалах бэлэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн салшгүй элемент бол хөрөнгө ба хөрөнгө оруулалт юм. Үйлдвэрлэлийн хэрэгсэл нь үйлдвэрлэлийн багаж хэрэгслийн чанарт онцлог шаардлагуудыг тавьдаг. Батлан хамгаалахын зориулалттай бараа ялангуяа зэвсэглэл ба цэргийн техникийг хийхэд ашигладаг хөдөлмөрийн багаж хэрэгслүүд гэдэг нь ихэвчлэн өвөрмөц онцлогтой суурь машинууд, төмөрлөгийн үйлдвэрийн тоног төхөөрөмж, электрон техник, хяналт-хэмжилтийн багаж бөгөөд тэдгээрийг зөвхөн тодорхой нэр төрлийн батлан хамгаалахын бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхэд ашиглах боломжтой байдаг.

Хөрөнгө оруулалт нь үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд чиглэсэн санхүүгийн хэрэгсэл юм. Батлан хамгаалахын бэлэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээ ба динамик нь хөрөнгө оруулалтаас шалтгаална. Батлан хамгаалахын үйлдвэрлэлийн хэрэгцээнд оруулах хөрөнгө оруулалтын хэмжээг улсын санхүүгийн боломж, дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх цэргийн зардлын хэмжээ тодорхойлдог. Орчин үед батлан хамгаалахын хэрэгцээний бүтцийг дараах байдлаар авч үзэж болно:

- зэвсэг тэмцлийн хэрэгслийн хэрэгцээ;
- зэвсэглэл, цэргийн техник болон цэргийн зориулалттай, бусад бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхэд шаардлагатай, хөдөлмөрийн багаж хэрэгслийн хэрэгцээ;
- цэргийн алба хаагчид ба эдийн засгийн цэргийн секторын ажилтнуудын хэрэгцээг хангах материал хэрэгслүүд;
- ЗХ-ний орон тоо, бүтцийг бүрдүүлэх хүний нөөцийн хэрэгцээ гэх мэт хэрэгцээнүүд бий болж байна.

Орчин үеийн батлан хамгаалахын хэрэгцээг хангахын тулд эдийн засаг, Батлан хамгаалах салбарын төсөв хүчирхэг байх шаардлагатай байна.

Францын цэрэг, улс төрийн зүтгэлтэн Наполеон Бонапарт өдгөөгөөс 200 гаруй жилийн тэртээ “Улс орон өөрийн армийг тэжээхгүй юм бол өрөөлийн армийг тэжээнэ” гэж сургасан байдаг. Энэ нь улс орон батлан хамгаалах төсөвтөө зузаатган, эх орноо хамгаалах бэлтгэлтэй байхыг анхааруулсан сургаал мөн.

### **1.3. Гадаадын зарим улс орон эдийн засаг, Батлан хамгаалах чадавхын өсөлтөөрөө аюулгүй байдлаа хангаж буй сургамж**

Гадаадын орнуудын Батлан хамгаалахын төсөв нь тухайн Засгийн газрын төлбөрийн чадвараас даван гарах учиргүй байдаг байна. Батлан хамгаалах салбар нь төсвөө үндэсний аюулгүй байдлын бодлогоор тодорхойлогдсон Зэвсэгт хүчний үүрэг зориулалтад нийцсэн Зэвсэгт хүчний сургалт, бие бүрэлдэхүүн, зэвсэг техникт хуваарилан зарцуулдаг байна.

Батлан хамгаалах салбар, цэргийн байгуулалтын эрх ашгийг хөндсөн хуулийг батлах үйл ажиллагаа цаг үргэлж тохиолдоод байдаггүй. Харин жил бүр Батлан хамгаалах үйл ажиллагааны төсвийн төслийг хянах, батлах хэрэгцээ шаардлага гардаг. Батлан хамгаалах төсвийг батлах процесс нь:

1. Засгийн газар Батлан хамгаалах төсвийн төслийг боловсруулах.
2. Хууль тогтоох байгууллага хуульчлан батлах.
3. Төсвийг хуваарилах, зарцуулах.
4. Төсвийн зарцуулалтыг хянан шалгах гэсэн дөрвөн үе шатаас бүрдэнэ.

Ихэнх улс орнуудад Ерөнхий сайд, Засгийн газрын танхимын гишүүд болон Сангийн яамны төлөөллөөс бүрдсэн “төв” нь улс орны эдийн засгийн макро түвшин болон Засгийн газрын эдийн засгийн онцгой анхаарах асуудлуудыг нягтлан үзэж эхний салбаруудын дунд төсөв хуваарилах шийдвэрийг гаргадаг байна<sup>16</sup>.

Төсвийн зарцуулалтын хязгаарыг төсвийн төслийг боловсруулах эхний үе шатанд тогтоож болно. Хэрэв төсөв боловсруулах, батлах процесс нь урт удаан хугацаанд үргэлжилдэг тохиолдолд дараагийн бүтэн нэг жилийн төсвийг боловсруулах эхний үе шатанд төсвийн зарцуулалтад хязгаарлалт тогтооход хэцүү байдаг. Харин яамд нь тухайн салбарын төсвийн төслийг бодит түвшингээс хэт дээгүүр тавьдаг (төсвийн төслийг өмнөх жилийн төсвөөс байнга нэмэх гэх мэт) улсын хувьд төсвийн зарцуулалтын хатуу хязгаарыг төсвийн төслийг боловсруулах үеэс эхлэн тавих нь зохистой гэж үздэг<sup>17</sup>. Гэвч сүүлийн жилүүдэд дэлхий нийтээр инфляци өсөж байгаатай холбоотойгоор<sup>18</sup> улс орнуудын Батлан хамгаалах төсөв өсөж батлагдаж байна. Дэлхийн улс орнуудын хувьд ирээдүйд оршин тогтнох хамгийн чухал хүчин зүйл нь хүчирхэг Зэвсэгт хүчинтэй байх явдал мөн юм.

<sup>16</sup>Ерөнхийлөгчийн засаглал бүхий ихэнх улс (АНУ-ыг үүнд багтаахгүй)-д Сангийн яам нь төсвийн зарцуулалтын хязгаарыг тогтоож, тухайн Ерөнхийлөгч нь Сангийн яам болон бусад яамд хооронд үүссэн маргааныг шийдвэрлэнэ. Парламентын засаглал бүхий улсуудад төсвийн зарцуулалтад тогтоох хязгаарыг ганцхан Сангийн яам бус харин “хамтын хариуцлага” хүлээх ёстой сайд нарын зөвлөл [Засгийн газрын танхим] хамтран тогтооно.

<sup>17</sup> Salvatore Schiavo-Campo and Daniel Tommasi, “The Budget Preparation Process,” Asian Development Bank, available at [http://www.adb.org/documents/manuals/govt\\_expenditure/Chap4.PDF](http://www.adb.org/documents/manuals/govt_expenditure/Chap4.PDF) assessed 4 May 2001.

<sup>18</sup><http://data.worldbank.org/indicator/NY.GDP.DEFL.KD.ZG>

Хүчирхэг арми тухайн улсыг улам л хүчирхэг болгоно гэсэн зарчимтай байдаг. Гадаадын зарим улс орнуудын цэрэг-эдийн засгийн чадавхын төлөв байдал<sup>19</sup>: (2015 оноор)-ыг дараах хүснэгтэд үзүүллээ.

## 1.2 дугаар хүснэгт

Улс орнууд	Эдийн засгийн чадавх		Эдийн засгийн хүч чадал		Цэрэг-эдийн засгийн хүч чадал			Цэрэг-эдийн засгийн чадавх	Цэргийн хүч чадал
	Хүн ам, сая	Нутаг дэвсгэр, мян.км.кв	ДНБ, тэрбум ам доллар	Нэг хүнд ноогдох ДНБ, ам.доллар	Цэргийн зардал, тэрбум ам. доллар	ДНБ-д эзлэх цэргийн зардлын хувь	Дэлхийн цэргийн зардалд эзлэх хувь	ДНБ-ний 50%-тай тэнцэх цэргийн зардал, тэрбум ам.доллар	Зэвсэгт хүчний хүний тоо
АНУ	318.89	9826.7	17460.0	54752.4	759.5	4.35	42.76	8730.0	1433.15
ОХУ	142.47	17098.0	3568.0	25043.8	124.5	3.49	7.0	1784.0	1260.0
БНХАУ	1355.69	9596.98	17630.0	13004.0	352.6	2.0	19.8	8815.0	2993.0
Их Британи	83.74	243.6	2420.0	28898.0	60.26	2.49	3.39	1210.0	159.15
ХБНГУ	80.99	157.0	1613.0	44607.1	48.77	1.35	2.75	1806.5	181.55
БНСУ	49.0	99.72	1781.0	36347.0	52.39	2.8	2.95	890.5	659.5
Казахстан	17.95	2724.9	420.6	23400.9	5.1	1.21	0.28	210.3	70.5
Монгол	2.95	1564.1	29.35	9939.0	0.329	1.21	0.018	14.67	17.5

Дээрх хүснэгтээс үзэхэд, Монгол Улс нь гадаадын зарим улс орнуудын цэрэг-эдийн засгийн чадавхын төлөв байдал (БХ зардал, ДНБ-д эзлэх БХ зардлын хэмжээ)-аар хамгийн доош түвшинд байна.

2015 онд дэлхийн улс орнуудын цэргийн зорилгоор зарцуулсан нийт мөнгөний хэмжээ өмнөх оныхтой харьцуулахад 1 хувиар өсч, 1.676 их наяд долларт хүрсэн тухай Стокгольмийн Олон улсын энх тайвны судалгааны хүрээлэнгийн /СИПРИ/ шинжээчдийн гаргасан тайлан мэдээнд дурдсан байна.

АНУ, ОХУ, БНХАУ-ын Батлан хамгаалах салбарын төсвийг Стокгольмийн энх тайвны судалгааны хүрээлэнгээс гаргасан байдлаар харвал дараах байдалтай байна<sup>20</sup>. 2015 онд дэлхий дахины цэргийн нийт зардлын 36 хувь нь АНУ /596 тэрбум доллар/, 13 хувь нь Хятад /215 тэрбум доллар/, 5.2 хувь нь Саудын Араб /87.2 тэрбум доллар/ улсад ногдож байна. ОХУ-ын хувьд дэлхийн цэргийн нийт зардлын ердөө 4 хувь буюу 66.4 тэрбум доллар зарцуулснаар жагсаалтын дөрөвдүгээрт бичигдсэн байна. Дэлхийн ихэнх улс орны хувьд Батлан хамгаалах төсөв нь улсын төсвийн зарлагын 6 хүртэл хувь, ДНБ-ийхээ 2-3%-ийг эзэлж байвал эрүүл төсөв гэж үзэх хандлага байна. Монгол орны хувьд 2010 онд ДНБ-ний 1,3%

<sup>19</sup>Эх сурвалж: [www.sipri.org](http://www.sipri.org).

<sup>20</sup><http://www.sipri.org/media/expert-comments/exp1>

хувьтай тэнцэх хэмжээгээр батлагдаж байсан төсөв 2016 оны байдлаар 0,79% хүртлээ буурсан байна. Харин өндөр хөгжилтэй орнуудын цэргийн төсөв жигд өсөлттэй байна.

*Батлан хамгаалах санхүүжилтийн тогтолцоог боловсронгуй болгох нэг чухал чиглэл нь БНХАУ болон АНУ-д хэрэглэдэг “төлөвлөлт-хөтөлбөржүүлэлт-төсөвлөлт” гэсэн системийн хандлагыг хэрэглэх явдал хэмээн үздэг.*

БНХАУ батлан хамгаалах төсвийн зарцуулалтын сүүлийн 6 жилийг харьцуулан үзэхэд багасгасан буюу 7.6% -ийн өсөлттэй зарцуулна гэж зарласан бөгөөд 146.7 тэрбум ам.доллар буюу 954.35 тэрбум юаний санхүүжилтийг Өмнөд Хятадын тэнгисийг хамгаалахад зарцуулахаар төлөвлөжээ. Энэхүү шийдвэр нь 2010 оноос хойш анх удаагаа буурсан нь Хятадын эдийн засгийн бууралттай холбоотой. Батлан хамгаалах салбарын төсөв 2014 онд ДНБ-ний 12.2%-тай тэнцэхүйц 808,2 тэрбум юань буюу 132 тэрбум ам.доллар, 2013 онд ДНБ-ний 10.7%-тай тэнцэхүйц 720,2 тэрбум юань буюу 114 тэрбум ам.доллар, 2012 онд ДНБ-ний 11.6%-тай тэнцэхүйц 650 тэрбум юань тус тус зарцуулсан байна.

ОХУ 2015 онд батлан хамгаалах зорилгод 66.4 тэрбум доллар зарцуулсан нь 2014 оныхтой харьцуулахад 7.5 хувиар өссөн үзүүлэлт бол 2006 оныхтой харьцуулахад 91 хувиар өссөн тоо аж. Нефтийн үнэ унасантай холбоотойгоор Оросын төсвийн орлого буурсан гэж СИПРИ-ийн шинжээчид үзэж байна.

Манай улсын Батлан хамгаалах төсөв нь үндсэндээ салбарын бие бүрэлдэхүүний цалин, хүнс, хувцас, шатахуун зэрэг хангалтын зардал болдог судалгаанаас харагдаж байна. Мөн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар цэргийн дэд бүтцийн байгууламж, барилга байгууламж, зарим нэр төрлийн техник хэрэгслийг худалдан авах зарим арга хэмжээг хэрэгжүүлж байгаа боловч энэ нь батлан хамгаалах эдийн засгийн чадавхын тухайд хангалтгүй байна.

Судалгааны материалаас үзэхэд, манай улсын төсвийн доторх батлан хамгаалах зардлын хувийг үечлэн дундажлан авч үзвэл 1920-1930 онд 23,4%, 1930-1950 онд 41,3%, 1950-1970 онд 8,8%, 1970-1990 онд 10,4%, 1990-2005 онд 5,4%, 2005-2015 онд 3,3% тус тус эзэлж байна. Сүүлийн жилүүдэд улс орнуудын батлан хамгаалах төсөв тогтвортой өсч байгаа боловч урсгал зардал (цалин хөлс, нийгмийн хамгаалал, удирдлагын зардал)-аа багасгаж шинэ техник технологи, судалгаа шинжилгээний зардлаа нэмэх хандлага ажиглагдаж байна.

### **Батлан хамгаалахын их төсөвтэй улс орнуудын тухайд авч үзье.**

Дэлхийн хамгийн их батлан хамгаалахын төсөвтэй улс оронд 2015 оны байдлаар АНУ хэдийгээр цэргийн зардал нь өмнөх оныхоосоо 2.4 хувиар буурч,

759,5 тэрбум доллар болсон ч тухайн үзүүлэлтээр нэгдүгээрт бичигдсэн хэвээр байна. Хятад болон Саудын Араб улсуудын хувьд энэ үзүүлэлт өссөн бөгөөд Хятадын батлан хамгаалах зардал 7.4 хувиар өсч, 215 тэрбум доллар болсон бол Саудын Арабынх 5.7 хувиар өсч 87.2 тэрбум ам.долларт хүрчээ. Батлан хамгаалах зардлаар жагсаалтын эхний тавд 55.5 тэрбум ам.доллар зарцуулсан Их Британи орсон байна. Батлан хамгаалах хамгийн их хэмжээний төсөвтэй 15 орнуудаас Австралийн зардал хамгийн их буюу 7.8 хувиар өссөн бол Итали улсынх хамгийн их буюу 9.9 хувиар буурчээ.

Өнгөрсөн 10 жилийн хугацаанд нефтийн үнэ өндөр байсныг дагаад дэлхийн олон орны батлан хамгаалах зардал огцом өсчээ. Гэвч 2014 онд нефтийн үнэ огцом унаснаар нефть олборлогч олон оронд энэ хандлага эсрэгээр өөрчлөгдсөн бөгөөд 2016 онд ч байдал хэвээр үргэлжилсэн байна. Энэ бүлэгт багтаж байгаа улсуудаас батлан хамгаалахын зардал нь хамгийн их хэмжээгээр буурсан орнууд бол Венесуэл /64 хувь/ болон Ангол улс /42 хувь/ юм. Тус хоёр улсаас гадна, Бахрейн, Бруней, Чад, Эквадор, Казахстан, Оман болон Өмнөд Суданы батлан хамгаалахын зардал буурчээ. Гэхдээ нефть олборлогч орнуудын дотор цэргийн зардлаа нэмэгдүүлсэн улсууд байна. Тухайлбал, Алжир, Азербайжан, ОХУ, Саудын Араб болон Вьетнамыг дурдаж болно. СИПРИ хүрээлэнгийн шинжээчдийн онцлон дурдсанаар, эдгээр орны ихэнх нь бусад оронтой цэргийн мөргөлдөөн хийж магадгүй байдалтай байгаа юм.

Саудын Арабын зардал 2015 оны төсөвт нь тусгаснаар бага байх ёстой байсан боловч Йеменд цэргийн ажиллагаа явуулснаар 5.3 тэрбум долларын нэмэлт зардал гарчээ. 2016 онд ОХУ болон Саудын Араб цэргийн зардлаа бууруулна гэж СИПРИ-гийн шинжээчид үзэж байлаа.

Хойд Америк, Баруун болон Төв Европын орнуудын хувьд 2009 оноос хойш батлан хамгаалах зардал нь тогтмол буурч байгаа бөгөөд энэ нь юуны өмнө дэлхийн эдийн засгийн хямрал, түүнчлэн Афганистан болон Иракаас АНУ болон тус улсын холбоотон орнуудын цэргийн үндсэн хэсгийг гаргасантай холбоотой. Өнгөрсөн онд АНУ-ын цэргийн зардал 2.4 хувиар буурсан нь өмнөх жилийнхтэй харьцуулахад харьцангуй удаан хурдцаар буурсан үзүүлэлт аж. Энэ нь өмнө нь баталсан төсвийн алдагдлыг бууруулах хөтөлбөр баталсантай холбоотойгоор тус улсын Конгресс цэргийн зардлыг хэсэгчлэн бууруулах арга хэмжээ авсны үр дүн юм.

Баруун болон Төв Европын орнуудын нийт зардал 2015 онд ерөнхийдөө 0.2 хувиар буурчээ. Гэхдээ Төв Европт цэргийн хэрэгцээнд зориулсан зардал 13

хувиар өссөн байна. Тус тивийн ОХУ, Украинтай хил залгаа орших Эстони, Латви, Литва, Польш, Румын, Словак зэрэг улсын цэргийн зардал илүү их хэмжээгээр өсчээ. Баруун Европт батлан хамгаалах зардал 1.3 хувиар буурсан нь 2010 оноос хойш буурч байгаа уг үзүүлэлтийн хамгийн доод түвшин ажээ.

СИПРИ-гийн тайланд онцлон тэмдэглэж буйгаар, “Лалын улс” бүлэглэлийн зүгээс учирч буй аюул занал, мөн “ОХУ-ын сэтгэл түгшээсэн үйлдэлтэй” холбоотойгоор батлан хамгаалахын зардлаа аажмаар нэмэгдүүлэхээр төлөвлөж байгаагаа Их Британи, Франц болон Герман улс мэдэгджээ.

### **Ази болон Номхон далайн бүсийн орнуудын батлан хамгаалахын зардлын өнөөгийн байдал**

Дээрх тайланд мөн дэлхийн бусад бүс нутгийн талаар анхаарал татахуйц баримтыг дурдсан байна. Тухайлбал, Ази болон Номхон далайн бүс нутгийн орнуудын батлан хамгаалах зардал 5.4 хувиар өсчээ. Тус бүс нутгийн нийт зардлын ихэнх хэсэг нь Хятадад ногдсон байна. Бүс нутгийн хэд хэдэн улс болон Хятад улс хооронд сөргөлдөх байдал үүссэн нь Индонез, Филиппин болон Вьетнам улсыг батлан хамгаалах зардлаа ихээхэн нэмэгдүүлэхэд хүргэж, түүнчлэн Японы батлан хамгаалах зардал буурах хандлагатай байсныг өөрчлөгдөхөд нөлөөлжээ.

Ойрх Дорнодын бүс нутгийн зарим орны өнгөрсөн оны батлан хамгаалах зардлын талаарх мэдээлэл байхгүй учраас СИПРИ-гийн тайлан мэдээнд энэ талаарх тус бүс нутгийн ерөнхий дүр зургийг гаргах боломжгүй болжээ. Статистикийн мэдээллээ танилцуулсан орнуудын батлан хамгаалах зардал дунджаар 4.1 хувиар өсчээ.

Иракийн батлан хамгаалах зардал 2006-2015 онд 536 хувиар өссөн байна. Латин Америк болон Карибын тэнгисийн орнуудын батлан хамгаалах зардал 2.9 хувиар буурчээ. Африкийн орнуудын хувьд 11 жилийн турш өсөлттэй байсан батлан хамгаалах зардал өнгөрсөн онд 5.3 хувиар буурчээ.

БНХАУ-ын батлан хамгаалах гадаад бодлого нь Азийн орнуудын энх тайван, аюулгүй байдалд анхаарлаа хандуулж, тэдэнд чиглэсэн үйлчилгээг үзүүлэх болно хэмээн тунхагласан байдаг. Тиймээс ч сүүлийн жилүүдэд АНУ-ын батлан хамгаалах төсвийн 1/3-тэй тэнцэхүйц хэмжээний төсвийн санхүүжилтийг хийж байгаа болно. Өнөөдөр БНХАУ батлан хамгаалах зэвсэглэл техникийн шинчлэлийн бодлогыг амжилттай хэрэгжүүлэх алхамыг хийгээд байгаа юм. Хятадын армийн удирдлага 2010-2015 онуудад 35 оронтой үүнээс Африкийн 18 улс болон Пакистан, Бангладеш, Мьянмар зэрэг улсуудтай Батлан хамгаалах

салбарт экспорт хийж байгаа ба дэлхийн хэмжээнд хамгийн том экспортлогч орон болох эдийн засгийн зорилт тавьжээ.

ОХУ нь батлан хамгаалах зардлаа тодорхойлохдоо Батлан хамгаалах зорилтыг үндэс болгон армийн нөөцөө тогтоон бусад төсвийн аргууд болох улсын санхүүгийн нөөцтэй уялдуулан тооцож төлөвлөдөг. Батлан хамгаалах төсөв нь үргэлж аюул заналын мөн чанарыг магадлан ухамсарлаж аливаа түрэмгийлэл халдлагын тооцоог эргэцүүлэн тунгаадаг болно. Энэ нь ч ирэх жилүүдийн санхүүгийн хуваарилалтыг хэрхэн төлөвлөх вэ? гэдгээр илэрхийлэгддэг юм.

Батлан хамгаалах төсвийн хэмжээ цэргийн үйл ажиллагаануудын үр дүнд бий болох хөрөнгө мөнгөний хэмжээнээс хамаарч өөрийн төлбөрийн чадварын мөн чанараа хадгалдаг. Батлан хамгаалах төсөвт эдийн засгийн боломж, санхүүгийн боломжит түвшний эрэлт хэрэгцээ, цэргийн үйл ажиллагааны болон Засгийн газрын бэлэн байдал гэх мэт хүчин зүйлүүд багтана. Өөрөөр хэлбэл ОХУ нь “зорилгот-хөтөлбөр-төлөвлөлт” гэсэн хандлагаар төсвийн бүтцийн үндэслэлийг бодитой гаргадаг байна.

ОХУ-ын цэргийн төсөв армийн нөөцөн дээрээ тулгуурлан зохиогддог. Энэхүү төсвийн санхүүжилт нь Батлан хамгаалах салбарын ажиллагсдын цалин, бэлтгэл сургалтын зардлууд, тоног төхөөрөмж, ачаа тээврийн хэрэгсэл ба тоног төхөөрөмжийн хүчин чадал болон түүний үйлчилгээний зардал, шинэ зэр зэвсгийн бэлтгэн нийлүүлэлт, шинээр болон үргэлжлүүлэн явуулж байгаа үйл ажиллагааны дэмжлэгийн зардал, хөгжил зэрэгт зарцуулагдана.

ОХУ 2014 онд 2,49 их наяд рубль буюу 69,3 тэрбум ам.доллар Батлан хамгаалах төсөвт зарцуулсан нь Европын бусад орнуудаасаа өндөр ч АНУ-ын төсвийн 1/7 буюу 14%-тай тэнцэнэ (2013 онд 68,2 тэрбум ам.доллар, 2012 онд 90,749 тэрбум ам.доллар, 2011 онд 71,9 тэрбум ам.доллар). Хэдийгээр 2015 онд 33% буюу 3,3 ихнаяд рублийн төсвийн төсөл төлөвлөсөн ч рублийн ханшийн үнэлгээнээс болоод 25,6% ба 3,1 ихнаяд рубль, 2016 онд 3,36 ихнаяд рубль төлөвлөсөн нь 3,145 ихнаяд рубль буюу өмнөх оноос 0,8%-аар өссөн дүнтэй байна. 1988 онд 2,1 тэрбум рубль буюу тэр үеийн үнээр илэрхийлбэл 68,6 тэрбум ам.доллар байсан нь тухайн үедээ өндөр үзүүлэлт байлаа. Хэдий тийм ч 1991-1997 онуудад бодит үнэ дэх олон хүчин зүйлийн улмаас 1988-1993 оны үе дэх зэвсгийн үйлдвэрлэл дээр суурилж байсан Батлан хамгаалах салбарын 50 орчим хувьд хүрч байсан төсөв эрс буурсан байна. Чех улсын дайнд ОХУ-ын армийн нөөц ашиглагдсан бөгөөд 2008 оноос эргэн энэ салбар сэргэв. 2012 онд үнийн бодлогын арга хэмжээ авч төсөв-санхүүгийн асуудалд нэлээдгүй анхаарсан

байна. Эдийн засгийн асуудлын нэг болох газрын тосны үнийн асуудлаас улбаатайгаар 2016 онд ДНБ-ний 5,3%-ийн өсөлт бүхий Батлан хамгаалах төсвийн санхүүжилтийг гүйцэтгэж байна.

НАТО-гийн орнуудын цэргийн төсөв хангалтгүй байна. Харин Оросын батлан хамгаалахын үйлдвэрлэл улсынхаа хамгийн амжилттай яваа салбарын нэг болсон бол Хятадын цэргийн техникийн зохион бүтээх үйл ажиллагаа, үйлдвэрлэлд зарцуулах төсөв нэмэгдсээр байна. Ийм дүгнэлтийг Британийн Стратегийн судалгааны олон улсын хүрээлэн (International Institute for Strategic Studies)-ээс жил бүр гаргадаг “Цэргийн баланс-2017” (The Military Balance 2017) судалгаандаа дурджээ.

1959 оноос эхлэн Британийн Стратегийн судалгааны хүрээлэн энэ төрлийн судалгааг гаргаж байгаа бөгөөд 2017 оны илтгэлд 171 орны цэрэг, техникийн чадамжийн талаар дурджээ. Энэ илтгэл нь дотроо 10 өгүүлэл багтаасны 7 нь дэлхийн аль нэгэн бүс, газар зүйн байрлалаар нь ялган дүн шинжилгээ хийсэн байна. 2016 онд дэлхийн олон оронд үндэсний аюулгүй байдлын асуудал хурцаар хөндөгдсөн ч Батлан хамгаалах үйлдвэрлэлийн салбарт компаниудын нэгдэж нийлэх хандлага газар авсан талаар, тэдний хамтарсан шалтгаан зэргийг энэ илтгэлд авч үзсэн байна. Мөн дэлхийн улс орнуудын батлан хамгаалах төсвүүдийг судалж, Батлан хамгаалах зардлын чансааг тогтоосон байна. Энэ судалгаанаас үзэхэд, ОХУ-ын цэргийн хүчин чадал, чансааг “Стратегийн судалгааны олон улсын хүрээлэн” дүгнэхдээ *нэгдүгээрт*, Батлан хамгаалах үйлдвэрлэлийн хөгжил, *хоёрдугаарт*, Америк болон НАТО-гийн тоон систем бүхий орчин үеийн техникүүдийн эсрэг бүтээгдэж буй зэвсэглэлийг авч үзсэн байна. Мөн 2014, 2015 онд ОХУ-ын цэргийн аж үйлдвэрлэл нь 20 хувиар өссөн байна.

БНХАУ-ын батлан хамгаалах зардал 2015 онд 145 тэрбум ам.доллар байсан бол 2016 онд Өмнөд Солонгос болон Японы батлан хамгаалах зардлыг нийлүүлснээс 1,8 дахин их болж өссөн гэж илтгэлд дурдажээ.

АНУ-ын "We are the Mighty" сэтгүүлийн редактор Блейк Стилуелл дэлхийн хамгийн сул армитай улсуудын жагсаалтад Монгол Улсын арми багтсан байна<sup>21</sup>.

---

<sup>21</sup>Эх сурвалж: [www.dsnews.ua](http://www.dsnews.ua)



## ДҮГНЭЛТ

Эдийн засгийн аюулгүй байдал нь үндэсний эрх ашгийн салшгүй хэсэг, үндэсний аюулгүй байдлын гол тулгуур, оршин тогтнохуйн үндэс суурь мөн.

Эдийн засгийн аюулгүй байдал алдагдвал улсын тусгаар тогтнол, язгуур ашиг сонирхол хохирч, гадаад хүчин зүйлсээс шууд шалтгаалан эдийн засаг хараат байдалд орох аюултай гэж үзлээ.

Монгол Улсын санхүүгийн тогтолцоонд Батлан хамгаалах ба аюулгүй байдлыг хангах зорилгоор санхүү төсвийн асуудал нэн чухал байранд байсаар ирсэн бөгөөд Батлан хамгаалах салбар нь өөрөө улс орныг батлан хамгаалах, аюулгүй байдлыг хангах ерөнхий чиг үүрэгтэй байсаар байна.

Үйлдвэрлэлийн хэмжээ, эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлснээр БХ-ын төсвийг ДНБ-д эзлэх хувийг үе шаттайгаар нэмэгдүүлж, цэргийн зэвсэглэл, техникийн хөрөнгө оруулалт нэмэгдэх боломжтой гэж үзлээ.

Улс орны аюулгүй байдал, Батлан хамгаалах асуудал нь БХЭЗ-ийн чадавх төсөв дээр тулгуурлаж, түүнээс хамаарна.

Орчин үед дайны аюул занал арилаагүй үед улс орны Батлан хамгаалах асуудал тэргүүн зэрэгт тавигдана.

Дэлхийн ихэнх улс орны хувьд Батлан хамгаалах төсөв нь улсын төсвийн зарлагын 6 хүртэл хувь, ДНБ-ийхээ 2-3%-ийг эзэлж байвал *эрүүл төсөв гэж үзэх хандлагатай* байна. Монгол орны хувьд 2010 онд ДНБ-ний 1,3% хувьтай тэнцэх хэмжээгээр батлагдаж байсан төсөв 2016 оны байдлаар 0,79% хүртлээ буурсан байна. Харин өндөр хөгжилтэй орнуудын цэргийн төсөв жигд өсөлттэй байна.

Дэлхийн 131 улсын ДНБ-д эзлэх батлан хамгаалах зардлын хувийг шинжилж үзэхэд 34 улсад 1 хүртэл хувь, 55 улсад 1-2 хүртэл хувь, 19 улсад 2-3 хүртэл хувь, 9 улсад 3-4 хүртэл хувь, 14 улсад 4-өөс их хувийн өсөлттэй байна. Хөрш орнуудын хувьд ОХУ 3 орчим хувь, БНХАУ 2 орчим хувьтай байхад манай улсынх 1 орчим хувьтай байгаа дүн ажиглагдлаа.

Манай улсын Батлан хамгаалах төсөв нь үндсэндээ бие бүрэлдэхүүний цалин, хүнс, хувцас, шатахуун зэрэг хангалтын зардал болдог нь судалгаанаас харагдаж байна. Монгол орныг Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний тухай хуулиар хүлээсэн олон талт үүргийг гүйцэтгэх чадавхыг хангахуйц санхүү-эдийн засгийн нөөц байх хэмээн заасан төрийн бодлого *батлагдсан хэдий ч төсвийн хэмжээ нь тавигдаж буй өнөөгийн шаардлагыг хангахуйц биш байна гэж үзлээ.*

## ХОЁРДУГААР БҮЛЭГ. МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, БАТЛАН ХАМГААЛАХ ЧАДАВХЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ

### 2.1. Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдлын гадаад, дотоод хүчин зүйлсэд хийсэн шинжилгээ

Манай Улсын эдийн засгийн хэвийн үйл ажиллагааг хангахын тулд олон тооны хувьсагч хүчин зүйлсийг судлан шинжилж үзэх шаардлагатай юм.


Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдлын гадаад, дотоод хүчин зүйлсийг тодорхойлохын өмнө эдийн засгийн хөгжлийн ерөнхий хандлагын талаар авч үзье.



2.1 дүгээр зураг. Монгол Улсын эдийн засгийн хөгжлийн ерөнхий хандлага

Дээрх графикаас үзэхэд хөдөө аж ахуй, ойн аж ахуй 16.3%, уул уурхайн олборлолт 17.0%, боловсруулах үйлдвэрлэл 9.7%, бөөний болон жижиглэн худалдаа 17.0%, мэдээлэл холбоо 2.5%, үл хөдлөх хөрөнгийн арилжаа 6.8%, төрийн удирдлага болон батлан хамгаалах 4.3%, боловсрол 6.7%, барилга 4.7%, тээвэр агуулах 4.8%, зочид буудал 1%, санхүү даатгал 5%, эрүүл мэнд, нийгмийн халамж 1.9%, урлаг, үзвэр 0.4%, цахилгаан хий агааржуулалт 1.8%, бусад салбар 0.1% эзэлж байна.

## Дотоодын нийт бүтээгдэхүүний бүтэц, хувиар, 2015 он<sup>22</sup>



2.2 дугаар зураг. Дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт, хувиар<sup>23</sup>

Манай Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний 2009 онд -1.3 хувь буурч, 2011 онд 17.5 хувь, 2014 онд 7.9 хувь, 2015 онд 2.3 хувиар тус тус өсжээ.

Судалгаанаас харахад 2008-2009 онд дэлхийн эдийн засаг, санхүүгийн хямрал болон Манай улсын эдийн засгийн дотоод нөхцөл байдал, цас зудын улмаас эдийн засгийн уналтад орж, 2010-2012 онд эдийн засаг өсч, харин 2013, 2014 онд эдийн засгийн өсөлт саарсан дүр зураг ажиглагдаж байна.

Харин манай орны эдийн засгийн үзүүлэлтүүд сүүлийн жил гаруй хугацааны байдлаар ялимгүй сэргэх хандлага ажиглагдаж байгааг эдийн засагч, судлаач, төр засгийн удирдах албаны хүмүүс тэмдэглэж байна.

Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, тусламжийн нийт хэмжээ 2017 оны эхний 9 сард 5.0 их наяд төгрөг, зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 5.8 их наяд төгрөг болж, улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 737.9 тэрбум төгрөгийн алдагдалтай гарчээ.

Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, зарлага, тэнцэл, жил бүрийн эхний 9 сарын байдлаар, тэрбум төгрөг 2.1. дүгээр хүснэгтэд үзүүлэв.

<sup>22</sup>Улсын бүртгэл, статистикийн газар, 19001212, 2015он

<sup>23</sup>Монгол Улсын статистикийн эмхэтгэл, 2011 он, 132 дахь тал, 2013 он, 207 дахь тал, Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдал, 2015 оны 1 сар, 26 дахь тал

## 2.1. дүгээр хүснэгт

Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, зарлага, тэнцэл, жил бүрийн эхний 9 сарын байдлаар, тэрбум төгрөг

Төсвийн тэнцвэржүүлсэн орлого	↓	4311.7	4045.9	4012.7	5035.1
Нэгдсэн төсвийн зарлага	↑	4504.2	4913.2	6064.4	5773.0
Төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл	↓↑	-192.5	-867.3	-2051.7	-737.9
Харьцуулсан онууд		2014 I-IX	2015 I-IX	2016 I-IX	2017 I-IX

Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийн алдагдал өмнөх оны мөн үеэс 1.3 их наяд төгрөгөөр буурахад орлого 1.0 (25.5%) их наяд төгрөгөөр өсч, харин зарлага 291.4 (4.8%) тэрбум төгрөгөөр буурсан нь нөлөөлжээ. Татварын нийт орлого 4.4 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 876.5 (24.9%) тэрбум төгрөгөөр өсөхөд орлогын албан татвар 367.9 (51.3%) тэрбум төгрөг, нэмэгдсэн өртгийн албан татвар 378.9 (48.8%) тэрбум төгрөг, гадаад үйл ажиллагааны орлого 118.0 (50.6%) тэрбум төгрөг, нийгмийн даатгалын орлого 84.0 (10.0%) тэрбум төгрөг, бусад татвар, төлбөр хураамжийн орлого 45.9 (12.5%) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн байна.<sup>24</sup>

2017 оны намрын УИХ-ын ээлжит бус чуулганд Монгол Улсын Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат хэлэхдээ, “Манай Засгийн газрыг байгуулагдахад эдийн засгийн өсөлт жил дараалан буурсаар 1.2 хувьтай болсон байлаа. Өнөөдөр 2017 оны эхний хагас жилийн дүнгээр 5.3 хувьтай байгаа. Цаашид төр засаг, бодлого тогтвортой байвал баялаг бүтээгчид маань энэ өсөлтийг илүү өндөр хувьд хүргэх баттай суурь, эхлэл тавигдсан. Гадаад худалдааны эргэлт 2012-2016 онд жил дараалан буурсан. Одоо 2017 он гарснаас хойш Монгол Улсын экспорт сар тутам 30-40 орчим хувиар өсөн нэмэгдэж байна. 2016 оны ээлжит сонгуулиас хойш гадаад худалдааны тэнцлийн үлдэгдэл 475.0 сая ам.доллараар нэмэгдэж, аж үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 43.5 хувиар өслөө. Гадаад валютын нөөц нэг тэрбум ам.доллар байсан бол өнөөдөр 1.3 тэрбум ам.доллар болж нэмэгдлээ. Сүүлийн дөрвөн жилийн турш тогтмол тасарч байсан улсын төсвийн орлого энэ оны хагас жилийн байдлаар 330 тэрбум төгрөгөөр давж биелэлээ<sup>25</sup> гэсэн нь эдийн засгийн байдал сэргэх хандлагын нэгэн илрэл болно.

<sup>24</sup> Монгол Улсын нийгэм, эдийн засгийн 2017 оны 9 дүгээр сарын байдлаарх мэдээлэл

<sup>25</sup> УИХ-ын ээлжит бус чуулганд Монгол Улсын Ерөнхий сайд Ж.Эрдэнэбатын хэлсэн үгнээс

Манай улсын эдийн засгийн аюулгүй байдалд нөлөөлж буй гадаад, дотоод хүчин зүйлсийн талаар шинжилгээ хийж үзье.

### Гадаад хүчин зүйлс:

**а. Стратегийн ач холбогдол бүхий экспортын барааны үнэ унах, зах зээлээ алдах эрсдэл:**

2.2 дугаар хүснэгт.


Ашигт малтмалын дэлхийн зах зээл дээрх үнэ<sup>26</sup>

Д/д	Ашигт малтмалын төрөл	Хэмжих нэгж	2013	2014	2015	2016.III	2016.III / 2015 %
1	Алт	\$/унци	1411.0	1271.2	1160.1	<b>1243.96</b>	107.2%
2	Мөнгө	\$/унци	23.8	19.1	15.7	15.4	98.1%
3	Зэс	\$/тн	7325.8	6859.5	5501.0	<b>4947.04</b>	89.9%
4	Цайр	\$/тн	1910.1	2161.0	1928.8	1804.3	93.5%
5	Молибдени	\$/тн	22583.3	25203.0	14618.2	<b>11950.0</b>	81.7%
6	Төмрийн хүдэр, 58%	\$/тн	125.0	93.1	49.82	45.03	90.4%
7	Эрчим хүчний нүүрс	\$/тн	60.0	56.6	49.1	48.0	97.7%
8	Коксжих нүүрс	\$/тн	150.0	150.0	106.2	88.0	82.9%

Энэхүү хүснэгтээс үзэхэд стратегийн ач холбогдол бүхий экспортын барааны үнэ сүүлийн жилүүдэд дараалан буурч байгаа нь манай улсын хувьд зах зээлээ алдаж буйн илрэл болж байна.

**б. Гадаад орны түүхий эдийн нийлүүлэгч, хавсарга болох, экспортод байгалийн баялаг, түүхий эд зонхилох байр суурь эзлэх эрсдэл:**

2015 оны экспортын бүтцийг 2.3 дугаар зургаар үзүүлээ.




2.3. дугаар зураг. 2015 оны экспортын бүтэц, улсаар, хувиар<sup>27</sup>

<sup>26</sup>Статистик мэдээ, Ашигт малтмалын газар, 2016.03, 18 дахь тал

2015 оны эцсийн байдлаар манай улсын нийт экспортын 83.5 хувийг БНХАУ, 7.2 хувийг Их Британи, ОХУ 1.6 хувь, бусад улс 8 хувийг тус тус бүрдүүлж байна. Харин (2011 онд БНХАУ-д 92.1 хувь) байна.

2015 оны экспортын барааны бүтцийн байдлыг 2.4 дүгээр зургаар үзүүллээ.

2.3 дүгээр зураг



2.4 дүгээр зураг. 2015 оны экспортын барааны бүтэц<sup>28</sup>

- 1 Зэсийн баяжмал – 48,8%
- 2 Чулуун нүүрс– 11,9%
- 3 Боловсруулаагүй буюу хагас боловсруулсан алт –9,0%
- 4 Боловсруулаагүй газрын тос – 8,3%
- 5 Төмрийн хүдэр, баяжмал – 4,9%
- 6 Мал, амьтны сэмлээгүй буюу самнаагүй үс, хялгас – 4,6%
- 7 Цайрын хвдэр, баяжмал – 2,2%
- 8 Жонш, лейцит, нефелин, нефелинт сиенит – 1,4%
9. Бусад 8,9%

2015 онд чулуун нүүрсний 96.8, зэсийн баяжмалын 99.3, төмрийн хүдрийн 89.5, хайлуур жоншны 41.8 хувийг БНХАУ-д экспортолсон гэх зэргээс үзвэл манай улсын стратегийн ач холбогдол бүхий экспортын бүтээгдэхүүний 70 гаруй хувийг<sup>29</sup> урд хөрш рүү гаргаж байгаа нь БНХАУ-ын металлын зах зээлийн эрэлт, нийлүүлэлт, үнэ ханшаас манай эдийн засаг шууд хамаарч байгааг илтгэж байна.

<sup>27</sup> Монгол Улсын гадаад худалдааны барааны статистикийн мэдээлэл, 2015 он, [http://customs.gov.mn/statistics/index.php?module=users&cmd=info\\_st](http://customs.gov.mn/statistics/index.php?module=users&cmd=info_st)

<sup>28</sup> Монгол Улсын гадаад худалдааны барааны статистикийн мэдээлэл, 2015 он, [http://customs.gov.mn/statistics/index.php?module=users&cmd=info\\_st](http://customs.gov.mn/statistics/index.php?module=users&cmd=info_st)

<sup>29</sup> Монгол Улсын гадаад худалдааны барааны статистикийн мэдээлэл, 2015 он, [http://customs.gov.mn/statistics/index.php?module=users&cmd=info\\_st](http://customs.gov.mn/statistics/index.php?module=users&cmd=info_st)

БНХАУ нь дэлхийн түүхий нүүрсний хамгийн том хэрэглэгч нь бөгөөд Монгол Улсын нийт нүүрсний экспорт нь бүхэлдээ Хятад улс руу чиглэж байна.

Дээрх байдлаар манай улс гадаад орны түүхий эдийн нийлүүлэгч, хавсарга шинжтэй эдийн засгийн бүтэцтэй болсон байна.

Эдийн засгийн төрөлжилтийн асуудалтай зүйл нь байгалийн баялагаа төрөлжүүлээгүй байсан нь нэлээд асуудал дагуулдаг байна. Түүхий эдийн үнэ савлахад буюу гадаад орчин таатай биш нөхцөлд их эрсдэлтэй юм байна гэдгийг манай улс маш сайн ойлгох боллоо. Тэр цаг үеэ ч туулж байна. Тиймээс ч хөдөө аж ахуйн салбартаа илүү анхаарч эхэлж байгаа юм.

Хөгжлийг боймлоод байгаа гол хүчин зүйлс нь юу юм бэ гэдгийг олж тогтоох талаар илүү дорвитой зүйл хийгдэж байна. Экспортод чиглэсэн илүү хүртээмжтэй салбар бий болгохын тулд юу хийх ёстой гэдгийг илүү бодитойгоор харж эхэлж байгаа. Ер нь эдийн засгийг төрөлжүүлэх нь нэг өдөр шийдвэр гаргаад дараа өдөр нь хэрэгжээд явдаг зүйл биш юм. Бодлогын шийдвэрээ зөв гаргаад, дүрэм журмаа боловсруулах, хэрэгжүүлэх байгууллагууд нь бий болгох зэрэг урт удаан хугацаанд хэрэгжих зүйл. Тиймээс ч Засгийн газрын зүгээс эдийн засгаа төрөлжүүлэх үүднээс малын гаралтай түүхий эд, махны экспортыг өөрийн хөрш орон ОХУ, БНХАУ руу хийх зэрэг ажил өрнүүлж байгаа боловч идэвхтэй өрнөхгүй байна.

**в. Стратегийн ач холбогдолтой бүтээгдэхүүн, хүнсний бүтээгдэхүүний импортоос дотоодын эдийн засаг хамааралтай болох эрсдэл:**

Монгол Улсын 2016 оны 12 сарын гүйцэтгэлээр гадаад худалдааны нийт бараа эргэлтийн хэмжээ өнгөрсөн оны мөн үеэс 2.3 хувиар буюу 191.5 сая ам.доллараар буурч 8275.3 сая ам.долларт хүрчээ. Үүнд, экспорт 5.3 хувиар буюу 248.1 сая ам.доллараар өссөн хэдий ч импорт 11.6 хувиар буюу 439.6 сая ам.доллараар буурсан нь нөлөөлжээ. Энэ хугацаанд экспортын дүн импортын дүнгээс 1559.4 сая ам.доллараар давж гадаад худалдааны тэнцэл ашигтай гарсан нь өнгөрсөн оны мөн үеэс 687.6 сая ам.доллараар өссөн үзүүлэлттэй байна.

2016 оны 12 сарын гүйцэтгэлээр импорт тоо хэмжээний өөрчлөлтөөс шалтгаалж 236 сая ам.доллараар, үнийн өөрчлөлтөөс шалтгаалж 204 сая ам.доллараар тус тус буурчээ. Тухайлбал, хэрэглээний бүтээгдэхүүний импортын тоо хэмжээ, үнэ нэмэгдсэнээс шалтгаалан уг бүлгийн импорт 57.7 сая ам.доллараар өсчээ. Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний импорт 20 хувиар буурсан нь уг бүлгийн импортын тоо хэмжээний өөрчлөлтөөс шалтгаалсан байна. Харин нефтийн бүтээгдэхүүний импорт 25 хувиар буурчээ. Нефтийн

бүтээгдэхүүний импортын хилийн үнэ 2013 оноос эхлэн үргэлжлэн буурч байсан хэдий ч 2016 оны 11 дүгээр сарын байдлаар тонн тутамд 546.1 ам.долларт хүрч 3 сар дараалан өсөөд байна.

Гадаад худалдааны экспорт, импортыг бүрдүүлж буй улсуудын хэмжээ нэг улсынх хэт их байх нь хараат байдлыг бий болгодог бөгөөд гадаад худалдааны бодлогын үр ашгийг дээшлүүлэхийн тулд хараат байдлын зэргэмжийг тодорхойлж байх шаардлагатай. Үүнийг тодорхойлохын тулд Херфиндаль-Хершманы индексийг ашигладаг бөгөөд энэ индекс нь зах зээлийн оролцогч тус бүрийн эзлэх жингийн квадратуудын нийлбэрээр тодорхойлогддог.

$$HHI = \sum X_i^2 - \text{Херфиндаль-Хершманы индекс}$$

$X_i$  – оролцогч улс бүрийн эзлэх хувийн жин

Херфиндаль-Хершманы индексээр эдийн засгийн хараат байдлыг тодорхойлохын тулд тухайн бараа, бүтээгдэхүүний хэрэгцээг дотоод эх үүсвэрийн хэдэн хувиар хангаж байгааг харгалзаж гурван ангилалд авч үздэг. Дотоод эх үүсвэрээр нийт хэрэгцээнийхээ 0-33 хувь, 33-66 хувь, 66-гаас дээш хувийг хангаж байгаа нөхцөлд HHI индексийг харгалзуулан хараат байдлыг үнэлнэ.

2.3 дугаар хүснэгт.

### Херфиндаль-Хершманы индекс

Д/д	Бүтээгдэхүүний төрөл	Херфиндаль-Хершманы индекс ХХИ	Хараат байдал
<b>Дотоод эх үүсвэрээр нийт хэрэгцээний 0-33 хүртэлх хувийг хангах</b>			
1	Цемент	0.9999	Бүрэн хараат
2	Бульдозер	0.7334	Бүрэн хараат
3	Цагаан будаа	0.6486	Бүрэн хараат
<b>Дотоод эх үүсвэрээр нийт хэрэгцээний 33-66 хүртэлх хувийг хангах</b>			
<b>Дотоод эх үүсвэрээр нийт хэрэгцээний 66-аас дээш хувийг хангах</b>			
4	Төмс	0.8752	Хараат бус

Манай улсын импортын зарим бүтээгдэхүүний хараат байдлын зэргэмжийг 2015 оны байдлаар Херфиндаль-Хершманы индексээр тодорхойлж үзэхэд цагаан будаа, элсэн чихэр, ургамлын тос, нефть бүтээгдэхүүн, цемент, бульдозер, авто хусуур, машин техник, гурилын тоног төхөөрөмж зэрэг бүтээгдэхүүний хувьд гадаад улсаас бүрэн хараат байдалтай байна.

**г. Гадаад улс орон, олон улсын байгууллагаас хэт их өрийн дарамтад орох эрсдэл:**

2.4 дүгээр хүснэгт.



Монгол Улсын нийт гадаад өрийн статистик<sup>30</sup>

Үзүүлэлт	12/31/2011	12/31/2012	12/31/2013	12/31/2014	12/31/2015
Нийт гадаад өр	9,627,518.7	15,386,476.8	19,022,099.1	20,942,296.6	21,602,907.5
I. Засгийн газар	1,950,867.7	3,684,123.2	3,684,321.7	3,609,623.8	3,648,904.5
1. Богино хугацаат	0.0	0.0	0.0	0.0	0.0
2. Урт хугацаат	1,950,867.7	3,684,123.2	3,684,321.7	3,609,623.8	3,648,904.5
II. Төв Банк	267,689.0	414,647.9	1,065,313.8	1,567,579.3	1,839,642.7
III. Хадгаламжийн байгууллага (Төв банкнаас бусад)	709,896.7	1,074,358.4	1,298,139.0	1,628,533.3	2,043,692.6
IV. Бусад салбарууд	948,713.3	1,855,964.8	2,633,374.3	3,521,887.7	3,381,116.4
V. Шууд хөрөнгө оруулалт: Компани хоорондын зээллэг	5,750,351.9	8,357,382.5	10,340,950.2	10,614,672.5	10,689,551.3

Монгол Улсын Засгийн газрын гадаад өр 2015 оны эцсийн байдлаар 3,648 тэрбум ам.доллар, Монгол Улсын нийт өр 21,602 тэрбум ам.долларт хүрсэн. Монгол Улсын хүн ам 2015 оны эцэст урьдчилсан дүнгээр 3061.6 мянга болж, өмнөх оныхоос 65.6 мянган хүн буюу 2.2 хувиар өслөө. Нэг хүн 7055.09 ам.долларын өртэй гэж судлаачид үздэг.

Улсын Их Хурлын 2012 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 52 дугаар тогтоолын дагуу Монгол Улсын Засгийн газар 1.500,0 сая ам.долларын бондыг Олон Улсын Санхүүгийн зах зээлд гарган арилжаалсан. 2013 онд 63,3 сая ам.доллар буюу 98,9 тэрбум төгрөгийг хүүгийн төлбөрт төлсөн. Чингис бондын хүүг жил бүр төлөх графиктай бөгөөд 2018 онд 500 сая ам.доллар, 2022 онд 1 тэрбум ам.долларын үндсэн өрийг төлнө. Мөн Хөгжлийн Банкаар дамжуулан 2014 онд 290 сая ам.доллартай тэнцэх 30 тэрбум иенийн бондыг гаргасан. 2014 онд авсан зээлийг нэмж тооцвол гадаад өр ДНБ-ний 50 гаруй хувьтай тэнцэнэ. Дээрх байдлаар манай улсын гадаад өрийн дарамт өсөж, гадаад улс орноос хамааралтай байдалд орж байна.

Өр бол төсвийн бодлогын үр дагавар юм. Тиймээс ч өр нь цэвэр төсвийн бодлогын чанараас хамаардаг. Монгол Улсын хувьд төсвийн сахилга батыг хангуулах, хууль эрхзүйн орчин нь бүрэн төлөвшиж чадаагүй байна. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиа дагаж мөрдөх, асуудал нь сул байна. Цаашид өр нэмэх эсэх асуудалд нэлээд хянамгай хандах шаардлагатай. Аливаа улс гадаадын зах зээлээс их хамааралтай болох нь эдийн засгийг маш эмзэг болгодог.

<sup>30</sup> [www.mongolbank.mn](http://www.mongolbank.mn), Гадаад секторын статистик Өрийн тойм 5 дахь тал

Өр, зээлийн хүү, ханшийн нөлөөлөл хамтдаа яригддаг гэдгийг анхаарах нь хэрэгтэй. Эхний эргэн төлөлтийг 2017-2018 онд орлогоосоо төлнө гэвэл төсөв тэр чигээрээ зарцуулагдахаар байна. Энэ нь нэлээд хүндрэлтэй байдалд орох нь ойлгомжтой юм. Засгийн газар эргэн төлөлтөд ихээхэн анхаарч, хуулийн дагуу зүй ёсоор нь төлнө л гэж байгаа бол хөрөнгө санхүүгээ одооноос бэлтгэх зүйтэй юм. Гэхдээ өр төлөх хугацаа хойшлуулж, дахин санхүүжилт хийх буюу тохиролцоо хийгээд явах боломж байна. Тиймээс хэдийг нь төлөх, хэдийг нь дахин санхүүжилтийн асуудлаар шийдэх нь Засгийн газрын шийдэх асуудал юм. Ер нь энэ бүх асуудлыг хөрөнгө оруулагчид ихээхэн анхаарч хардаг. Өөрөөр хэлбэл, тухайн улс орон хэр хянамгай бодлого явуулж байгаа эсэх, эдийн засаг нь хэр чадвартай байна вэ гэдгийг анхаардаг. Төсвийн бодлого нь зөв байж чадвал эргэн төлөлт болоод бусад асуудалд эерэг юм. Өнөөгийн байдлаар өрийг өрөөр төлөхөөс өөр боломж харагдахгүй байна.

**д. Стратегийн ач холбогдолтой салбарт гадаадын хөрөнгө оруулагчийн нөлөө өсөх эрсдэл:**

Манай улс гадаадын хөрөнгө оруулалтын орчин, боломжийг тодорхой түвшинд бүрдүүлэн ажилласны үр дүнд гадаадын хөрөнгө оруулалтын нийт хэмжээ 2015 онд өссөн дүнгээр 16.752 сая ам.долларт хүрчээ. 2010 оноос хойш гадаадын шууд хөрөнгө оруулалт огцом өсч 2011 онд оргил цэгтээ хүрч байлаа. Харин 2012 оноос дэлхийн эдийн засгийн хямрал, зах зээл дээрх түүхий эдийн үнийн уналт болон бусад сөрөг хүчин зүйлээс шалтгаалан гадаадын хөрөнгө оруулалт буурчээ. Гадаадын шууд хөрөнгө оруулалт /ГШХО/ 2012-2013 онд 43.52 хувь, 2013-2015 онд 78,7 хувиар<sup>31</sup> тус тус буурсан байна.



2.5 дугаар зураг. Монгол Улсад орсон гадаадын шууд хөрөнгө оруулалт, салбараар 2009-2014<sup>32</sup>

<sup>31</sup>www.Монголбанк.mn.

<sup>32</sup>Монгол Банк, “Судалгааны ажил” товхимол, №10, УБ., 2015 он.

Монгол Улсад хийсэн гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээг салбараар нь ангилан үзвэл 2009-2014 оны хооронд дунджаар 70 хувь нь уул уурхайн салбарт, 23 хувь нь худалдаа үйлчилгээний салбарт, 7 хувь нь бусад салбарт хийгдсэн байна. Манай улсын эдийн засагт гадаадын шууд хөрөнгө оруулалтын үзүүлэх нөлөөг тодорхойлсон судалгаанаас гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээний 1 хувийн өсөлтийн нөлөө нь тээвэр, дэд бүтцийн салбарыг 2011 онд 0,19 хувиар, 2012 онд 0,066 хувиар, 2013 онд 0,041 хувиар тус тус өсгөдөг болох нь тодорхойлогдсон<sup>33</sup>. Энэ нөлөө нь 2011 ондоо бусад салбаруудтай харьцуулахад өндөрт тооцогдож байсан хэдий ч хугацаа өнгөрөхийн хэрээр буурч байна. Иймд дэд бүтцийг сайжруулахын тулд гадаадын хөрөнгө оруулалтыг татахаас гадна дотоодын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлбэл илүү оновчтой үр өгөөжтэй сонголт болох юм. Учир нь гадаад өр нэмэгдэх нь ҮАБ-д сөрөг нөлөөтэй билээ. Дээр дурьдсан бүхнийг дүгнэж үзвэл манай улсын ЭЗАБ-ын гадаад хүчин зүйлсийн сөрөг нөлөөлөл илүү хүчтэй, зарим талаар аюултай гэж үзэх үзүүлэлтийн хязгаарыг давсан байдалтай байна.

#### **Дотоод хүчин зүйлс:**

#### **а. Үндэсний үйлдвэрлэл, боловсруулах үйлдвэрлэл уналтад орох эрсдэл:**

Манай улсын уул уурхай, олборлох үйлдвэр 2011 онд 7.3 хувь, 2014 онд 22.5 хувь өссөн бол 2015 онд 2.9 хувиар өсжээ. Боловсруулах үйлдвэр 2011 онд 8.3 хувь, 2014 онд 19.4 хувь өсөж байсан бол 2015 онд 0.1 хувиар өссөн байна.

2.5 дугаар хүснэгт.

#### **Аж үйлдвэрийн салбарын өсөлт, хувиар<sup>34</sup>**

<b>Салбар</b>	<b>2011 он</b>	<b>2012 он</b>	<b>2013 он</b>	<b>2014 он</b>	<b>2015 он</b>
ДНБ	17,5	12,4	11,7	7,8	2,3
Уул уурхай, олборлох үйлдвэр	7,3	8,0	20,7	19,4	13,0
Боловсруулах үйлдвэр	8,3	9,4	6,8	12,7	8,8

Дээрх байдлаар үндэсний үйлдвэрлэл, ялангуяа боловсруулах үйлдвэрлэлийн салбар дорвитой өсөхгүй байна.

<sup>33</sup>Судлаачдын тооцоолол: "Гадаадын хөрөнгө оруулалтын талаар баримтлах зохистой бодлого" /Судалгааны тайлан/, 2015 он, х.718.

<sup>34</sup>Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдал, 2015 оны 12 сар, х.28.




2.6 дугаар зураг. Аж үйлдвэрийн салбарын бүтэц, хувиар<sup>35</sup>

Аж үйлдвэрийн салбарын бүтцэд 2013 онд уул уурхай, олборлох үйлдвэр 60.5 хувийг эзэлж байсан бол 2015 онд 71.2 хувь, харин 2013 онд боловсруулах үйлдвэр 31.6 хувийг эзэлж байсан бол 2015 онд 21.2 хувь болж буурчээ. Эндээс боловсруулах үйлдвэрлэлийн салбарыг сэргээн хөгжүүлэх шаардлагатай байна гэсэн дүгнэлтийг хийж болно.

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2017 оны эхний 9 сард урьдчилсан гүйцэтгэлээр 9.4 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 2.6 (37.4%) их наяд төгрөгөөр өслөө. Үүнд уул уурхай, олборлох аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэл өмнөх оны мөн үеэс 2.1 (43.5%) их наяд төгрөгөөр, үүнээс нүүрс олборлолт 1.1 (2.5 дахин) их наяд, металлын хүдэр олборлолт 0.8 (23.0%) их наяд төгрөгөөр тус тус өссөн нь голлон нөлөөлөв.

Аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэлийг 2.7 дугаар зургаар 2014 оны эхний 9 сараас 2017 оны эхний 9 саруудыг харьцуулан үзүүлэв.




\* Урьдчилсан гүйцэтгэл

2.7 дугаар зураг. Аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэл, салбараар, сараар, тэрбум төгрөг

<sup>35</sup>Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдал, 2015 оны 12 сар, х.28.

## **б. Монгол малын удмын сан, сүргийн бүтцийн тэнцвэртэй харьцаа алдагдах эрсдэл.**

Манай улс 2010 онд 32,73 сая толгой малтай байсан бол 2016 онд 61,5 сая толгой малтай болжээ. Сүргийн бүтцийг 2.8 дугаар зургаар үзүүлэв.



### **2.8. дугаар зураг. Мал сүргийн бүтэц 2015 он, 2016 оны харьцаа <sup>36</sup>**

2016 оны жилийн эцсийн байдлаар манай улсын мал сүрэг 2015 оныхоосоо 9.9 хувь буюу 5,562,630-аар өсчээ. Сүргийн бүтцийг үзвэл манай улсын ямааны тоо толгой хурдтай өсөж, бусад сүргийн эзлэх жин буурч, ямаан сүрэг нийт мал сүргийн 41.6 хувийг эзлэх болсныг харж болно. Тэмээ, адуу, үхрийн эзлэх хувь бууралттай байна.

## **в. Газар тариалангийн салбар уналтад орох, хүнсний аюулгүй байдал алдагдах эрсдэл.**

ХАА-н салбарын хөгжилд манай улсын газар тариалангийн үйлдвэрлэл тодорхой байр суурийг эзэлсээр ирсэн. Газар тариалангийн салбарын хөгжил нь хүн амын нийгэм, эрүүл ахуйн хангамж, амьжиргааны түвшин, хүнсний аюулгүй байдалд нөлөөлөх гол хүчин зүйл болно.

Манай улс үр тариа 2012 онд 479.3 мянган тонн, 2014 онд 518.8 мянган тонн, 2015 онд 216.3 мянган тоныг хураан авчээ. Төмс 2012 онд 245.9 мянган тонн, 2014 онд 161.5 мянган тонн, 2015 онд 163.8 мянган тонн төмс хураан авчээ. Газар тариалангийн салбарын үзүүлэлтүүд 2010-2012 онд ерөнхийдөө өссөн боловч 2014, 2015 онд тус салбарын менежмент, хөрөнгө мөнгөний дутагдал, байгалийн хүчин зүйлээс шалтгаалан буурсан байна.

<sup>36</sup>Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдал, 2015 оны 1 сар, х23.

2017 оны 10 дугаар сарын 1-ний байдлаар 166.1 мянган тонн үр тариа, 87.3 мянган тонн төмс, 63.1 мянган тонн хүнсний ногоо хурааж, 646.6 мянган тонн өвс хадлан, 15.6 мянган тонн гар тэжээл бэлтгэсэн байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс үр тариа 126.0 (43.1%) мянган тонн, өвс хадлан 255.4 (28.3%) мянган тонн, хүнсний ногоо 6.6 (9.5%) мянган тонн, гар тэжээл 3.5 (18.2%) мянган тонн, дарш 0.4 (69.7%) мянган тонн, төмс 34.7(28.5%) мянган тонноор буурсан байна<sup>37</sup>.

**г. Уул уурхайн салбарын хөгжил хоцрогдох, зөвхөн олборлох, тээвэрлэх технологи нэвтрэх эрсдэл.**

Манай улсын уул уурхайн салбарт олборлох, тээвэрлэх технологи зонхилж байна. Уул уурхайн салбарт гадаадын хөрөнгө оруулалт түлхүү чиглэж байгаа боловч зөвхөн анхан шатны боловсруулалттай холбоотой техник, технологи нэвтэрч байна. Тухайлбал, манай улс нийт олборлосон 35 хувийн агуулгатай зэсийн баяжмалын 10 хүрэхгүй хувийг боловсруулж, 99 хувийн агуулгатай катодын зэс үйлдвэрлэдэг байна. Мөн газрын тос олборлож байгаа боловч дотооддоо газрын тос боловсруулах үйлдвэр байхгүй байгаагаас БНХАУ руу гаргаж, боловсруулсны дараа буцаан авч байна.

**д. Дэд бүтцийн хөгжил хоцрогдох эрсдэл.**

Засгийн газраас эрчим хүч, зам тээвэр, төмөр зам, холбоо харилцааны салбарыг хөгжүүлэхэд анхаарч, дэд бүтцийн салбарт гадаадын зээл, тусламжийг чиглүүлж байгаа нь салбарын санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэж, өсөлт, хөгжлийг хангахад эерэг нөлөө үзүүлж байна. Тухайлбал, улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй хөгжлийн банкаар дамжуулан зам тээврийн салбарт 1949,30 тэрбум төгрөг, эрчим хүчний салбарт 427,9 сая төгрөг, барилга хот байгуулалтын салбарт 1146,6 тэрбум төгрөгийн санхүүжилт 2011-2015 онуудад хийгджээ.

Нөгөө талаар төмөр зам барих компанийг сонгон шалгаруулах, зохион байгуулалтын ажил удаашралтай явагдаж байна.

**е. Төрийн санхүүгийн бодлогын үр ашиг буурах, төсвийн алдагдал өсөх эрсдэл.**

Улсын төсвийн орлого, татварын орлогоос урсгал зардал илүү хурдан өсч, тэлж байгаа нь санхүүгийн бодлогын үр ашигт сөргөөр нөлөөлнө. Санхүүгийн бодлого эдийн засгийн өсөлтийг хангах, стратегийн ач холбогдолтой салбарыг

---

<sup>37</sup> Монгол Улсын нийгэм, эдийн засгийн 2017 оны 9 дүгээр сарын байдлаарх мэдээлэл

санхүүжүүлэх үндсэн зорилготой боловч манай улсын урсгал зардал хэт өсч, нийгмийн халамжийн шинжтэй төсөв бүрэлдсэн байна.

Улсын төсвийн орлого, зарлагын судалгаанаас үзвэл нийт, орлого, зарлага нь эдийн засгийн тэлэлт, үнийн өсөлттэй уялдаатайгаар өсч байна. 2010 онд төсвийн тэнцэл эерэг 41,8 сая төгрөг гарч байсан бол сүүлийн жилүүдэд алдагдалтай болж, 2011 онд 769,9 сая төгрөг, 2015 онд 1156,9 сая төгрөгт хүрч өсчээ.

#### **ё. Банкны салбар хямралд орох, инфляци үсрэнгүй нэмэгдэх эрсдэл.**

Манай улсын банк санхүүгийн салбар харьцангуй тогтворжиж, эрүүл орчин бүрдэж байсан боловч Монгол Банк инфляцийг 2015 оноос өмнө нэг оронтой тоонд барьж чадаагүй байна. Тухайлбал, инфляци 2010 онд 13 хувь, 2011 онд 10,2 хувь, 2013 онд 12,5 хувь, 2014 онд 11 хувьд хүрсэн бол 2015 онд 1,9 хувь болж буурчээ.

Энд өнгөрсөн цаг хугацаанд банкны систем улс төртэй холбогдож Засгийн газар хямдхан мөнгө буюу Засгийн газрын бондууд, аливаа хөтөлбөрүүдийн санхүүжилтүүд зэргийг өөртөө татан төвлөрүүлж үйл ажиллагаа явуулж ирсэн нь өнөөдрийн банкны системийн хямралыг бий болгоод байгаа юм. Өөрөөр хэлбэл банкны салбарт өрсөлдөөн жинхэнэ утгаараа хэрэгжээгүй, арилжааны банкуудын менежмент тааруухан, төгрөгийн ханш 60 орчим хувиар унасан, инфляци нь дефляци болох зэрэг нь банк санхүүгийн хямралыг бий болгох шалтгаан нь болж байна.

#### **ж. Ядуурлын гүнзгийрэлт**

Ядуурлын түвшин 2012 онд 27,4 хувь байсан бол 2015 онд 29,3 хувьд хүрч өссөн.<sup>38</sup> Энэ нь хүн амын дөрөвний нэг орчим хувь нь амьжиргааны баталгаажих түвшингээс бага орлоготой амьдарч байгааг илтгэж байна. Хүн амын сарын дундаж орлого өсөж байгаа боловч үнийн өсөлтөөс шалтгаалан бодит цалин, хүнсний бүтээгдэхүүний дундаж хэрэглээ төдийлөн өсөж чадахгүй, зарим талаар буурах хандлагатай байна. Дээр дурдсан бүхнийг дүгнэж үзвэл манай улсын ЭЗАБ-д гадаад орчноос үүсэх аюул занал илүү хүчтэй, түүнийг даван туулахад хүндрэлтэй, харин дотоод нөөц бололцоогоо дайчлан, ажиллаж, оновчтой хуваарилалт хийж, эдийн засгийн үр ашигтай тогтолцоо бүрдүүлснээр аюулгүй байдлаа баталгаажуулах боломжтой байна. ЭЗАБ-д сөрөг нөлөөтэй гадаад, дотоод хүчин зүйлс бүрийн чиглэлд цогцолбор судалгаа, шинжилгээ хийж,

---

<sup>38</sup> [www.nso.mn](http://www.nso.mn).

аюулгүй байдлыг хангах, өрсөлдөх чадвар, дархлааг бий болгох бодлого боловсруулж хэрэгжүүлэх шаардлагатай юм.

ҮЭЗАБ-ын түвшинг үнэлж, цаашдын хандлага, аюулгүй байдлыг хангах арга замыг тодорхойлохын тулд ЭЗАБ-ын шалгуур үзүүлэлтийн тогтолцоог боловсруулах шаардлагатай байна. Эдийн засаг хямралтай байгаа үед бүхий л хүчин зүйл нь хямралын шинжийг агуулах тул эдийн засгийн тогтвортой байдал нь хамгийн бага түвшинд байна. ЭЗАБ-ын шалгуур үзүүлэлтийн тогтолцоо нь ЭЗАБ-ын мөн чанарыг харуулдаг. ЭЗАБ-ын шалгуур нь түүний мөн чанарыг тусгасан байдгийн хувьд улсын ЭЗАБ-д өгөх үнэлгээ болно. Аюулгүй байдлын шалгуур нь босготой байх ба босго нь янз бүрийн салбар дахь аюулгүй ба аюултай үзэгдлийн хоорондын заагийг тодорхойлох эдийн засгийн тоон шинж чанартай хэрэгсэл буюу эдийн засгийн салбарт үндэсний ашиг сонирхол ямар түвшинд хангагдаж байгааг илэрхийлэгч эдийн засгийн тоон шинжтэй хэрэгсэл юм.

Олон улсын байгууллагаас боловсруулсан шалгуур үзүүлэлт болон манай улсын ЭЗАБ-ын хүчин зүйлсийг үндэслэн Монгол Улсын ЭЗАБ-ын шалгуур үзүүлэлтийг 2.4. дүгээр хүснэгтээр тодорхойлж, үнэлсэн болно.

2.6 дугаар хүснэгт.

### Монгол Улсын ЭЗАБ-ын шалгуур үзүүлэлт, хувиар

Д/д	Шалгуур үзүүлэлт	Босго утга	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	Эх сурвалж
1	ДНБ-ий жилийн өсөлтийн хувь хувиар	5	8,9	-1,3	6,4	17,3	12,3	11,6	7,9	2,3	ҮСХ
2	ДНБ-д эзлэх улсын нэгдсэн төсвийн ашиг/алдагдал	-2	-4,5	-5,2	0,4	-4,8	-6,8	-1,2	-3,9	-5,0	ҮСХ
3	Хөрөнгө оруулалтын ГШХО-ын үлдэгдэлд эзлэх жин, хувиар	33		0,6	15,8	13,9	56,7	52,9	51,8	51,2	ОУВС
4	ДНБ-д эзлэх ЗГ-ын өрийн үлдэгдэл, хувиар	40	31,0	39,3	23,0	20,7	30,7	31,9	30,7	31,4	СЯ, ҮСХ
5	Жилийн инфляцын түвшин, хувиар	20	0,2	1,9	14,3	9,4	14,2	11,2	10,7	1,9	М.Б
6	Улсын нэгдсэн төсөвт эзлэх ЗГ-ын өр төлбөрийн хэмжээ, хувиар	20	3,0	5,4	3,5	2,5	7,4	6,5	9,5		
7	Гадаад валютын										



	нөөцийн импортын хэрэгцээг хангах түвшин /сараар/	<b>3 сар</b>	2,3	8,0	8,2	6,3	9,9	5,1	4,9	5,5	М.Б
<b>8</b>	Эрчим хүчний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр хангах түвшин хувиар	<b>100</b>	94,4	95,6	93,3	93,4	91,8	78,3	77,4	77,5	ГЕГ, ҮСХ
<b>9</b>	Газрын тосны бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр хангах түвшин	<b>100</b>	0,0	0,0	0,0	0,0	0,0	0,0	0,0	0,0	ҮСХ
<b>10</b>	Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хөрөнгө оруулалтын хэмжээ хувиар	<b>30</b>	16,3	13,7	21,8	50,0	37,1	18,5	3,2	1,7	
<b>11</b>	Гадаад иргэн харьяалалгүй хүн, цагаачдын тооны зохистой түвшин, хувиар	<b>3,5</b>	0,9	0,9	0,9	1,3	1,0	1,5	1,7		
<b>12</b>	Ажилгүйдлийн түвшин хувиар	<b>8</b>	2,8	11,6	9,9	7,7	8,2	7,9	7,9	8,3	ҮСХ
<b>13</b>	Орлого хуваарилалтын харьцаа (хүн амын бүлгийн хамгийн баян 10% ба хамгийн ядуу 10%-ийн дундаж орлогын харьцаа )	<b>8-10 дахин</b>	9,2	7,7	8,0	8,2	8,3	8,0	7,7		ҮСХ
<b>14</b>	Хүний хөгжлийн индекс	<b>1,0</b>	0,75	0,75	0,76	0,72	0,73	0,74	0,75		ҮСХ
<b>15</b>	Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх шинжлэх ухаан инновацийн зардал, хувиар	<b>2</b>	0,1	0,1	0,1	0,2	0,3	0,3	0,3	0,1	
<b>16</b>	ДНБ-д эзлэх улсын төсвийн нийт зардал, хувиар	<b>40</b>	37,6	35,5	31,6	37,9	35,9	32,2	31,6	30,8	ҮСХ


Судлаачийн тооцоолол.

Ядуурлын түвшин 2015 онд нийт хүн амын 29,3% нь нэн ядуу байгаа нь ихээхэн анхаарал хандуулах шаардлагатайг илэрхийлж буй хэрэг мөн. ЭЗ-ийн хямралтай холбоотой ажилгүйдлийн түвшин ч шалгуур үзүүлэлтээс өндөр байгаа юм. Хүнсний хэрэгцээний дийлэнх хувийг импортоор хангаж байгаа, хэрэглээний

бараа бүтээгдэхүүний 55% нь импортын бараа байгаагаас харвал гадаад улсад инфляци өссөн тохиолдолд энэ нь манай улсын ХҮИ-д шууд нөлөөлөхүйц байна. Өөрөөр хэлбэл инфляцийг гадаад улсаас импортолж буй хэрэг гэхдээ 2017 оны 9 дүгээр сарын байдлаар 5,3% хувьтай байна. Дээрхээс үзэхэд нийт үзүүлэлтийн гуравны хоёр нь аюултай нөхцөл байдал үүсэн бүрэлдэж байгааг илэрхийлж байна. Аюултай гэж үзэх хязгаар үзүүлэлт эдийн засгийн аль нэг хүрээний уналт, үл оршин тогтнохыг тэр болгон харуулдаггүй ч тухайн салбарын аюулгүй байдал алдагдсан, тус салбарт гадны нөлөө өндөр байгаа тул тухайн чиглэлд илүү анхаарал хандуулж, шуурхай ажиллах шаардлагатай байгааг илтгэнэ. Энэхүү байдал урт хугацаанд үргэлжилбэл манай улсын ЭЗАБ алдагдаж, гадаад улс орон, бүлэглэлүүдээс хараат байдалд орж, ард түмний язгуур ашиг сонирхолд хохирол учрах магадлал ойрхон байна гэж үзэж болох юм.

Дээр дурдсан бүхнийг дүгнэж үзвэл манай улсын эдийн засгийн аюулгүй байдлын гадаад, дотоод хүчин зүйлсийн сөрөг нөлөөлөл илүү хүчтэй, зарим талаар аюултай гэж үзэх үзүүлэлтийн хязгаарыг давсан байдалтай байна. Иймд эдийн засгийн аюулгүй байдлыг хангахын тулд олон хүчин зүйлсийн нөлөөллийг анхааран судлах, нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх, үүссэн асуудлыг шийдвэрлэх арга замыг тодорхойлох шаардлагатай байна.

Монгол Улсын нэг хүнд ногдох гадаад дотоодын өр дунджаар 3000 гаруй ам.доллар хүрч байгаа талаар Азийн хөгжлийн банкнаас нийтэлсэн эдийн засгийн тайланд дурджээ. Олон улсын валютын сангаас өрийн хямралд орох эрсдэл өндөр гэж үзжээ. Өр ДНБ-ний 77,4 хувьд хүрээд байна. Энэ талаар Азийн хөгжлийн банкны Монгол Улс дахь суурин төлөөлөгчийн газрын эдийн засагч Л.Амар “2010 онд 31 хувь байсан бөгөөд үүнээс хойш хоёр дахин нэмэгджээ гэсэн дүгнэлт хийсэн байна. Үүнийг 2.9 дүгээр зургаар үзүүлээ.



2.9 дүгээр зураг. Өр дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь

Манай орны нийт гадаад өр болох 21 тэрбум ам.долларын ихэнх нь хувийн хэвшлийн өр байна. Монгол Улсын нийт гадаад өрийн 17 хувь болох 3.6 тэрбум ам.доллар нь Засгийн газрын гадаад өр. Нийт 21 тэрбум ам.доллар гээд байгаа гадаад өрийн тал нь болох 10.7 тэрбум ам.доллар нь шууд хөрөнгө оруулалт буюу компани хоорондын зээллэгэ байна. Арилжааны банкуудын гадаад өглөг нийлээд 2 тэрбум ам.доллар. Олон улсын аргачлалын дагуу бусад сектор гэсэн ангилал байдаг. Энд бид иргэн, аж ахуйн нэгж, хувийн сектор, мөн Хөгжлийн банкийг оруулдаг. Энэ дүн нийлээд 3.4 тэрбум ам.доллар. Жишээ нь, гадаадад байгаа толгой компани нь Монголд үйл ажиллагаа явуулж байгаа охин компанидаа шууд хөрөнгө оруулалт хийлээ гэж үзье. Хөрөнгө оруулалтын урсгал нь шууд хөрөнгө оруулалт гэж төлбөрийн тэнцэлд бичигдэнэ. Харин охин компанийн хэрэгжүүлж байгаа төслийн орлогоос, тухайлбал экспортын орлогоос нь уг хөрөнгө оруулалт урт хугацаандаа эргэж төлөгдөнө. Ийм учраас шууд хөрөнгө оруулалтын үлдэгдэл өссөн дүнгээрээ компани хоорондын зээллэгээ буюу хувийн секторын гадаад өр гэж бүртгэгддэг. Энэ нь зөвхөн тухайн охин компанид л хамаарна. Эдийн засгийн бусад агентуудад хамаарахгүй.

Олон улсын аргачлалаар Төв банкны гадаад өглөг гэсэн ангилалд бүртгэдэг байна. Үндэсний мөнгөн тэмдэгт харилцах солилцох своп хэлцлийг улс орнууд дэлхийн эдийн засаг дахь бүсчилсэн шинжтэй хямралын үед түгээмэл ашигладаг. Яагаад гэхээр гадаад худалдаагаа аль болох тогтвортой байлгахыг зорьдог. Төлбөрийн тэнцэл хүндрэлтэй үед своп хэлцлийн ашиглалт нэмэгдэж болно. Төлбөрийн тэнцэл хүндрэлгүй үед хэлцлийг ашиглах шаардлага гарахгүй. Хоёр орны хооронд гадаад худалдаа хийгдэж байгаа бол гадаад худалдааг тогтвортой байлгах ийм хэрэгсэл өөрөө байнгын шинжтэй байна. Тэр ч агуулгаараа төв банкууд своп хэлцлийн хугацааг нь сунгаж, хэмжээг нь тухай бүр нэмээд явдаг байна.

Монгол Улсын эдийн засгийн өсөлтийн байдлыг шинжлэн үзэхэд, манай орны эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд өнгөрсөн 4 жилийн хугацаанд тасралтгүй унаж, 2012 онд 17,3 хувийн өсөлттэй байсан эдийн засаг 2016 оны эцэст 1.3 хувьтай байв. Эдийн засаг ийнхүү уналтад ороход нэг талаас дэлхийн зах зээл дээрх түүхий эдийн үнэ буурч, манай улсын экспортын орлого, төсвийн бүрдэлт, валютын орох урсгалд сөрөг нөлөөлөл үзүүлсэн гэж үзэж болно. Нөгөө талаас өнгөрсөн 4 жил явуулсан төсөв, мөнгөний алдаатай бодлого, тооцоо судалгаагүй, уялдаа холбоогүй шийдвэрүүдийн уршгаар улс орны эдийн засаг, төсөв, санхүүгийн байдал туйлын хүнд байдалд орсныг харуулж байна.

Манай орны нэгдсэн төсвийн орлого сүүлийн 3 жил дараалан 1 их наяд гаруй төгрөгөөр тасарч, жил бүр 2-3 удаа тодотгол хийж ирсэн байна.

Монгол Улсын нэгдсэн төсөв 4 жил дараалан их хэмжээний алдагдалтай гарч байгаа нь нэг талаас манай улсын эдийн засаг хямарсантай, нөгөө талаас татвар төлөгчдийн мөнгийг үр ашиггүй, үрэлгэн зарлагадаж ирсэнтэй шууд холбоотой гэж үзэх үндэслэлтэй юм.

Монгол Улсын Төсвийн тогтвортой байдлын тухай хуулинд зааснаар нэгдсэн төсвийн алдагдал энэ онд ДНБ-ний 4 хувиас буюу 974,9 тэрбум төгрөгөөс хэтэрхгүй байх ёстой. Гэтэл 2016 оны эхний 7 сарын байдлаар нэгдсэн төсвийн алдагдал 2 их наяд төгрөгт байсан бол 2017 байдлаар 2.7 их наяд төгрөгт хүрээд байна. Тиймээс нэн даруй төсвийн тодотгол хийж, төсвийн зарлагыг бууруулахгүй бол төсвийн зарлага оны эцэст 10,3 их наяд төгрөгт хүрч, алдагдал нь 5,1 их наяд төгрөг буюу энэ оны хүлээгдэж буй ДНБ-ий 21,1 хувийг давахаар байна. Өөрөөр хэлбэл, энэ жилийн төсвийн алдагдал төсвийн орлоготойгоо дүйцэхүйц хэмжээнд хүрэхээр байна.

Манай орны 2016 оны баталсан төсвийн орлого 7,013 их наяд төгрөг 1.8 их наяд төгрөгөөр тасарч, өнгөрсөн оныхоос 760,3 тэрбум төгрөгөөр бага төвлөрөхөөр байна. Үндсэн шалтгааныг судлан үзэхэд, эрдэс бүтээгдэхүүний үнэ, экспортын бууралт 362.8 тэрбум төг, импортын бууралт 515.9 тэрбум төг, эдийн засгийн нөхцөл байдал 397.3 тэрбум төг, бусад шалтгаан 524.5 тэрбум төг болж нийт 1800.5 тэрбум төг болсон байна. Хууль бусаар санхүүжүүлсэн, төсөвт тусгагдаагүй хөрөнгийн байдлыг авч үзвэл, нэгдсэн төсвийн орлого 1.8 их наяд төгрөгөөр тасарч байхад, төсвийн тухай хууль болон бусад хууль тогтоомжийг ноцтой зөрчин зарлагаа өсгөн ард түмний өрийг нэмэгдүүлсэн байна.

Улсын хэмжээнд 2016 оны эхний хагас жилийн байдлаар 134,813 аж ахуйн нэгжүүд бүртгэлтэй байгаагаас 66,388 нь аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаагаа зогсоосон буюу ажил эрхлээгүй байна. Өөрөөр хэлбэл үндэсний 2 компани тутмын 1 нь үйл ажиллагаагаа зогсоожээ. Энэ нь манай улсын эдийн засгийн нөхцөл байдал хэрхэн дордсоныг, мөн бизнес эрхлэх орчин хэр муудсаныг харуулж буй хамгийн тод жишээ юм. Олон мянган аж ахуйн нэгжүүд хаалгаа барьсны уршгаар ажилгүйдэл газар авч, иргэдийн орлого буурч, амьжиргааны түвшин эрс доройтоод байна. Өнөөгийн энэхүү хямралаас манай улс хувийн хэвшилдээ тулгуурлаж гарна. Энэ утгаараа юуны өмнө эдгээр компаниудыг үйл ажиллагаагаа дахин эхлүүлэх боломжийг олгоход төрийн бодлого чиглэгдэх ёстой гэж үзэж байна.

### **Засгийн Газрын өрийн өнөөгийн байдлыг шинжлэн үзсэн нь**

2011 онд нэгдсэн төсвийн урьдчилсан гүйцэтгэлээр нийт 37,2 тэрбум төгрөгийг зээлийн хүүний төлбөрт төлж байсан нь 2016 онд 1 их наяд 85 тэрбум болж, өнгөрсөн 4 жилд 29 дахин нэмэгдсэн байна. Өмнөх Засгийн газар төсөвт тусгагдаагүй хөтөлбөрүүдийг ер тавин санхүүжүүлсэн, төсөвт ирэх ачаалал, өрийн дарамтыг нэмэгдүүлсэн зэргээс үүдэн зээлийн хүүгийн төлбөр цаашид ч хурдацтай нэмэгдэхээр байна. Мөн ирэх оноос эхлэн бондын төлбөрийг төлж эхлэх ба валютын нөөц хангалтгүй, дэлхийн зах зээл дээрх эрдэс баялагийн түүхий эдийн үнэ унасан, манай улсын зээлжих зэрэглэл –B2 болж буурсан, 2016 оны төсвийн алдагдал 1 их наяд орчим төгрөг байхаар төсөвлөгдсөн зэрэг нь дээрх бондуудыг эргэн төлөхөд их хүнд болохыг анхааруулж байна.

Засгийн газрын өр 2016 онд 17 их наяд 311 тэрбум төгрөг байхаар батлагдсан ч, оны эцэст 21,3 их наяд төгрөгт хүрч, энэ оны хүлээгдэж буй ДНБ-ний 78 хувьтай тэнцэхээр байгааг 2.5 дугаар хүснэгтээр үзүүлээ.

2.7 дугаар хүснэгт.

#### **2016 оны Засгийн газрын өрийн байдал**

<b>ҮЗҮҮЛЭЛТ</b>	<b>2016 БАТЛАГДСАН</b>	<b>2016 ХҮЛЭЭГДЭЖ БУЙ</b>
Засгийн газрын өр (нэрлэсэн)	17,310.8	21,284.4
Засгийн газрын өр (өнөөгийн үнэ цэнэ)	15,174.4	18,913.6
Засгийн газрын өр / ДНБ	55%	<b>78%</b>

### **Монгол Улсын нэгдсэн төсвийн зардлын санхүүжилтэд үүссэн хүндрэлийн байдлыг шинжлэн үзвэл:**

Энэ онд нэгдсэн төсвөөс гадаад, дотоод зээлийн өрийн төлбөрөө графикийн дагуу, шинээр зээл авахгүйгээр эргэн төлвөл, Монголын төрд бүхий л үйл ажиллагаагаа санхүүжүүлэхэд дөнгөж 1 их наяд 130 тэрбум төгрөг үлдэж байна. Энэ мөнгө нь төрийн албан хаагчдын цалинг тавихад ч хүрэлцэхгүй юм.

Засгийн газарт үйл ажиллагаа явуулахад дахин 5.8 их наяд төгрөг шаардлагатай болно. 2017, 2018 онуудад Монгол Улсын нэгдсэн төсвийн орлого нь Засгийн газрын өр, зээлийн эргэн төлөлт, хүүний төлбөрийг төлөхөд ч хүрэлцэхгүй байна. Монгол Улсын нэгдсэн төсвийн зардлын санхүүжилтэд үүссэн нөхцөл байдлыг 2.8 дугаар хүснэгтээр үзүүлээ.

## 2.8 дугаар хүснэгт.

Монгол Улсын нэгдсэн төсвийн зардлын санхүүжилтэд үүссэн хүндрэл /тэрбум төгрөгөөр/

Үзүүлэлтүүд	2016 год	2017	2018	2019
Төсвийн орлого (Тусламжийн орлогыг цэвэрлэсэн дүн)	5103.6	5803.4	6098.2	6543.5
Зээлийн үйлчилгээний төлбөр	3973	6197.4	6236.4	5337.4
Хүүний төлбөр	1085	1548.6	1975	2456.9
Үндсэн төлбөр	2888	4648.8	4261.4	2880.5
Үлдэх эх үүсвэр	1130.6	-394	-138.2	1206.1
Төсвийн бусад зардлыг санхүүжүүлэхэд шаардлагатай эх үүсвэр	<b>-5811.4</b>	<b>-7938.7</b>	<b>-6612.6</b>	<b>-5202.7</b>

Төсвийн бусад зардлыг санхүүжүүлэхэд шаардлагатай эх үүсвэр 2016, 2017, 2018, 2019 оны нийлбэр дүнгээр 25.565.4 тэрбум төгрөг болно.

Тодруулж үзвэл, улс олсон 5 төгрөг тутмын 4-ийг өрөндөө төлж, үлдсэн 1 төгрөгөөр нь бусад бүх зардлаа санхүүжүүлэхээр байна. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын дархан хил, аюулгүй байдлыг хамгаалдаг цэрэг эрсээс эхлээд, хүн ардынхаа эрүүл мэнд, боловсрол, соёл урлаг спортыг хөгжүүлж байдаг нийгмийн салбарт ажиллагсдын цалин хөлс, үйлчилгээний урсгал зардлуудыг ч санхүүжүүлэх боломжгүй болох нөхцөл байдалтай болжээ.

Улсын төсөв, эдийн засаг, санхүүгийн байдал ийнхүү гүн хямралд ороод байгаа үнэн мөнийг олон түмэндээ бодитоор мэдээлэн ойлгуулах нь зүйтэй юм. Эдийн засгийн нөхцөл байдал амаргүй хүнд байгаа ч, Засгийн Газар ирээдүйгээ өөдрөгөөр харж энэхүү хямралаас гарах цогц төлөвлөгөөг боловсруулж байна. Өнөөгийн энэ хүнд хэцүү цаг үеийг Монгол Улсын Их хурлаар хэлэлцэж хамгийн оновчтой шийдвэр гаргаж даван туулах шаардлага гарч байна.

## 2.2. Монгол Улсын Батлан хамгаалахын төсвийн санхүүжилтийн өнөөгийн байдалд хийсэн шинжилгээ


Монгол Улс зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжиж салбарын төсвийг эдийн засгийн өсөлт, нийгмийн хэрэгцээтэй уялдуулан төсвийг хэмнэх, аж ахуйн зардлыг хязгаарлах, төсвийг урьд оны түвшингээс хэт өсгөхгүй байх бодлогоор зайлшгүй шаардагдах зардлын түвшинд төсөв батлагдахгүй, салбарын хөгжил, хэтийн бодлогыг хэрэгжүүлэх хөрөнгө бага байдгаас төсөв хэрэглээний шинж чанартай байна.

*Батлан хамгаалахын төсөв нь:*

- Цалин хөлс болон нэмэгдэл урамшил;
- Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл;
- Бараа, үйлчилгээний болон бусад зардал;
- Татаас ба урсгал шилжүүлэг;
- Хөрөнгийн зардал гэсэн үндсэн бүлэг зардлын зүйл, ангиллаар батлагдан мөрдөгдөж байна.

Дэлхийн ихэнх улс орны хувьд батлан хамгаалах төсөв нь улсын төсвийн зарлагын 6 хүртэл хувь, ДНБ-ний 2-3%-ийг эзэлж байвал эрүүл төсөв гэж үзэх хандлага байна. Монгол орны хувьд 2010 онд ДНБ-ний 1,3% хувьтай тэнцэх хэмжээгээр батлагдаж байсан төсөв 2016 оны байдлаар 0,79% хүртлээ буурчээ.

Батлан хамгаалах төсөв ДНБ-д эзлэх хувь хэмжээ дугаар 2.10 дугаар зурагт үзүүлээ.



Эх сурвалж: [www.sipri.org](http://www.sipri.org)

### 2.10 дугаар зураг. Батлан хамгаалах төсөв ДНБ-д эзлэх хувь хэмжээ

Улс орны Батлан хамгаалах ба аюулгүй байдлыг хангахад материалын болон хүний нөөцийн зардал ихээхэн шаардагддаг. Батлан хамгаалах зардлын санхүүжилтийн эх үүсвэр болон үндэсний аюулгүй байдлын санхүүгийн хангалтын

ашигтай хувилбарыг эрж хайх нь батлан хамгаалах санхүүгийн бодлогыг хэрэгжүүлэх чухал асуудлын нэг хэвээр байна.

Зэвсэгт хүчинд тавигдаж буй өнөөгийн шаардлагад “Монгол орныг батлан хамгаалах, Зэвсэгт хүчний тухай хуулиар хүлээсэн олон талт үүргийг гүйцэтгэх чадавхыг хангахуйц санхүү-эдийн засгийн нөөц байх” хэмээн заасан боловч батлагдсан төсвийн хэмжээ нь тавигдаж буй өнөөгийн шаардлагыг хангахуйц биш байна.

“Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс” шинэ баримт бичгийн нэг онцлог нь батлан хамгаалах бодлогын эдийн засаг, нийгмийн чиглэлийг илүү өргөн хүрээнд, тодорхой болгож томъёолсон явдал юм.

“Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс” баримт бичигт эдийн засгийн бодлогын хүрээнд дараах арга хэмжээнүүдийг авахаар тусгасан болно:

- Батлан хамгаалах хэрэгцээг хангах эдийн засгийн чадавх бүрдүүлнэ.
- Улсын эдийн засгийн бодлого, төлөвлөлт, уул уурхай, үйлдвэрлэл, дэд бүтцийг хөгжүүлэх, гадны хөрөнгө оруулалт, ажиллах хүчийг ашиглах үйл ажиллагааг үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах эрх ашигт нийцүүлнэ.
- Батлан хамгаалах төсвийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хэмжээг нэмэгдүүлэх бодлого баримтална.
- Батлан хамгаалахын хэрэгцээт бүтээгдэхүүн үйлдвэрлэн нийлүүлж байгаа аж ахуйн нэгжид төрөөс дэмжлэг үзүүлнэ. Цэргийн зарим нэр төрлийн эд хэрэгслийг дотооддоо үйлдвэрлэх, засвар үйлчилгээ хийх, худалдан авах бодлого баримтална.
- Цэргийн зэвсэг, техник худалдан авах, шинэчлэх зардлыг жил бүрийн улсын төсөвт тусгаж байна.
- Цэргийн дайчилгааны нөөцийг бүрдүүлэх зардлыг жил бүрийн улсын төсөвт тусгаж хэрэгжүүлнэ.

Батлан хамгаалах бодлогын эдийн засгийн чиглэл нь Монгол Улсын тогтвортой хөгжлийг хангаж, батлан хамгаалах чадавхыг бэхжүүлэхэд анхаарч байна.

Батлан хамгаалахын сайдын төсвийн багц 2016 онд 218,6 тэрбум төгрөгөөр батлагдсан нь 2015 оны төсвөөс 7,7 хувиар буюу 16.9 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн үзүүлэлттэй байна. УИХ-аас төмөр замын бүтээн байгуулалтад зориулан 24,0 тэрбум төгрөгийг төсөвт суулгасан нь төсвийг урд оноос өсгөсөн юм.



Батлан хамгаалахын 2016 оны төсөвт нэмэлт тодотголоор тусгах нэн шаардлагатай 17,3 тэрбум төгрөгийг шийдвэрлүүлж, улмаар 2017 оны төсвийн тодотголоор Зэвсэгт хүчний анги, салбаруудад хуримтлагдсан өр болох 10,8 тэрбум, Цэргийн Төв Эмнэлэг болон Үндэсний Батлан Хамгаалах Их Сургуульд 3,3 тэрбум, "UBM" төслийг хэрэгжүүлэхэд 25 тэрбум, нийт 39,2 тэрбум төгрөгийг нэмэгдүүлж чадлаа. Түүнчлэн 2015 оноос хойш "Зэвсэгт хүчний хөгжлийн сан"-аас санхүүжүүлж байсан цэргийн алба хаагчдын нормын хувцас, хэрэглэл болон сургалт, үйлдвэрлэлийн зардалд 2018 оны улсын төсөвт 5 орчим тэрбум төгрөгийн санхүүжилтийг суулгах зохицуулалтыг хийж, УИХ-д өргөн барьж, шийдвэрлүүлэхээр ажиллаж байна<sup>39</sup>.

Улсын төсвийн зарлага, дотоодын нийт бүтээгдэхүүнд Батлан хамгаалахын сайдын төсвийн багцын эзэлж байгаа хувийг 2.8 дугаар хүснэгтээр үзүүллээ.

#### 2.9 дүгээр хүснэгт.

Он	Төсвийн зарлага /сая төг/	БХЯ-ны төсөв /сая төг/	Төсвийн зарлагад эзлэх хувь	ДНБ-д эзлэх хувь
2010	2465204.2	74442.5	3	1.3
2011	4084100.0	110314.4	2.7	1
2012	6309400.0	160193.2	2.4	1
2013	7444600.0	163095.0	2.3	1
2014	5631357.1	208509.8	3.7	1
2015	7253300.0	201738.9	2.7	0.85
2016	7954400.0	218671.1	2.7	0.79

Эх сурвалж: Судлаачийн тооцоолол.

Энэхүү хүснэгт болон графикаас харахад 2011-2014 онд хөрөнгө оруулалт нэмэгдэж байгаад эргээд буурч байгаа нь ДНБ-д эзлэх цэргийн зардлын хувь буурч байгаагаар давхар нотлогдож байна.

Батлан хамгаалах салбарын төсвийн санхүүжилтийн байдалд хийсэн судалгааг 2.11 дүгээр зургаар үзүүллээ.

<sup>39</sup> Зэвсэгт хүчний удирдах бүрэлдэхүүний 2017 оны заах арга зүйн цугларалтад УИХ-ын гишүүн, Батлан хамгаалахын сайдын үүрэг гүйцэтгэгч Б.Бат-Эрдэний хэлсэн үгнээс



2.11дүгээр зураг. Батлан хамгаалахын төсвийн судалгаа (тэрбум төг).

Дээрх графикаас үзэхэд, ДНБ-д эзлэх хувь батлан хамгаалахын төсвийн хэмжээ 2017 оны байдлаар 0,76 хувь хүртэл буурч, хөрөнгө оруулалт 2014 онд 30.11 тэрбум төгрөгөөс 2017 онд 10.0 тэрбум төгрөг хүртэл бууралттай байна. Энэ байдал нь батлан хамгаалах хүч чадавхын өсөлтөд муугаар нөлөөлж байна гэж үзэх үндэстэй юм.

Улс орны нийгэм, эдийн засгийн хөгжлийн хүрээнд гаднаас орж ирж байгаа зээл тусламж, хөрөнгө оруулалт, төсөлд хамрагдах нь батлан хамгаалах салбарын оролцоог ихэсгэж, түүгээрээ дамжуулан цэргийн алба хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, ардчилсан нийгэм дэх цэргийн албаны үнэлэмжийг дээшлүүлэхэд чухал ач холбогдолтой. Иймд Зэвсэгт хүчний хөгжлийн сангийн санхүүжилт хэдийгээр нэмэгдсэн дүнтэй харагдаж байгаа ч бодит байдалд тэр болгон үр дүнтэй байж чадахгүй байгаад асуудал оршиж байгаа юм.

Хөгжингүй орнуудын цэргийн зардал эдийн засгийн өсөлттэйгээ уялдан хувьсан өөрчлөгдөж байдаг нь эмпирик судалгаануудаар нотлогдсон байдаг. Зарим улс орны батлан хамгаалах арга хэмжээний төсвийн зардалд хязгаарлалт тавьдаггүй практик ч байдаг байна. Тухайлбал, АНУ-ын батлан хамгаалах арга хэмжээний төсөв, зардлын төлөвлөлтөд 1960-аад оны эхэн үеэс эхлэн хязгаарлалт тавих явдлыг зогсоож, хэрэгцээтэй бүхнээр хангах бодлогыг баримталж эхэлсэн байдаг. Мөн түүнчлэн Ерөнхийлөгчийн төсвийн удирдлага, зохицуулалтын албанаас ч батлан хамгаалах арга хэмжээний төсөв, хөтөлбөр, төсөлд хориг тавих нь бусад төрийн байгууллагуудын төсвийн хэлэлцүүлэгтэй харьцуулахад бага байх болсон зэрэг нь АНУ-ын өнөөгийн цэргийн хүчин чадал, цэргийн эдийн засгийг тэргүүлэх байранд аваачихад хүргэсэн гэж тооцогддог.

Монгол Улсын батлан хамгаалах салбарын төсвийн зардалд хязгаарлалт тавих нь энэхүү салбарын хөгжлийг саармагжуулахад түлхэц болж байгаа тал байж болох юм. Батлан хамгаалахын төсвийн зарлагын бүтцийг 2.10 дугаар хүснэгтээр үзүүлээ.

2.10 дугаар хүснэгт.

**Батлан хамгаалахын төсвийн зарлагын бүтэц (сая төг)**

Д/д	Зардлын ангилал	2010	2011	2012	2013	2014	2015
1	Урсгал зардал	63450.8	83340.6	128952.6	132977.4	143400.4	154702.3
2	Улсын төсвийн хөрөнгө оруулалт	3283.8	17973.8	15866.3	17739.1	30109.4	4534.6
3	Гадаадын зээлээр санхүүжих тоног төхөөрөмж	-	-	-	-	-	7541.2
4	Зэвсэгт хүчний хөгжлийн сан	7707.9	9000.0	15374.3	12378.5	35000.0	34960.8
	<b>Нийт дүн</b>	<b>74442.5</b>	<b>110314.4</b>	<b>160193.2</b>	<b>163095.1</b>	<b>208509.8</b>	<b>201738.9</b>

Сүүлийн 3 жилийн төсвийн зардлын бүтцээс харахад цалин, тогтмол зардал, бараа үйлчилгээний урсгал зардлыг зах зээл дээрх барааны үнийн өсөлт, тогтмол зардлын үнийн өсөлттэй уялдуулан бага хэмжээгээр нэмэгдүүлсэн боловч салбарын техник тоног төхөөрөмж, барилга байгууламжийг шинээр барих төсөв батлагдахгүй, сүүлийн 3 жил дараалан он дамжсан барилгын санхүүжилт улсын хөрөнгө оруулалтын төсөвт батлагдсан боловч хугацаандаа олгогдоогүй байна. Батлан хамгаалах салбарт батлагдсан төсвийн зөвхөн 2 хувийг салбарын улсын төсвийн хөрөнгө оруулалтын зардал эзэлж байна.

Батлан хамгаалахын төсөв зөвхөн хэрэглээний шинжтэй байгаагаас Зэвсэгт хүчнийг хөгжүүлэх, зэвсэглэл техникийг үе шаттайгаар шинэчлэх, чадавхыг нэмэгдүүлэх боломжгүй байна. Зэвсэгт хүчний хөрөнгө оруулалтын төсвийг эдийн засгийн өсөлттэй шууд хамааруулан төлөвлөх шаардлагатай. Үүний хүрээнд хөрөнгө оруулалттай холбоотой төсөл хөтөлбөрүүд бодит өртгөөрөө төсөвт суугдаж өгөх юм. Цаашилбал аюулгүй байдлын орчны өөрчлөлтийг төсөөлөх, эдгээрт үндэслэсэн үндэсний аюулгүй байдлыг хангах батлан хамгаалах бодлого, төлөвлөлтөд хийж болох шинэчлэл өөрчлөлтийг бий болгох, хөгжүүлэх, тэдгээрт шаардлагатай санхүүжилтийн асуудлыг цаг тухайд нь шийдвэрлэх нь чухал асуудал болоод байгаа билээ. Тухайлбал, 2013-2016 оны төсвийн хүндрэлүүд:

- Цалингийн санд багтаан цалинжуулах асуудал үүсдэг.

- Батлан хамгаалахын гадаад харилцаа өргөжихийн хэрээр түүнд шаардагдах хөрөнгийг нэмэгдүүлэх шаардлага гарч байна.
- Ном хэвлэлийн зардал, хичээл үйлдвэрлэлийн дадлагын зардлыг өмнөх онуудаас бууруулан баталсан нь салбарын байнгын бие бүрэлдэхүүний бэлэн байдлыг хангахад шаардагдах хичээл сургуулилтыг явуулах, шуурхай мэдээллээр хангах үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж байна.
- Батлан хамгаалахын чиглэлээр гадаадын их дээд сургуульд цэргийн мэргэжлээр нийт 510 орчим оюутнууд суралцаж байна. 2014 оноос эхэлсэн төсөв санхүүгийн хүндрэлээс шалтгаалан байр, ахуй, оюутны тэтгэлгийг бүрэн олгоогүйгээс шалтгаалан 2014, 2015 онд оюутнуудтай холбоотой нөхөн олговрын өр нийт 3,4 тэрбум төгрөгт хүрээд байна. 2016 онд төсвийн хүндрэлээс шалтгаалан оюутны тэтгэлгийг төсөвт суулган батлаагүй. Батлан хамгаалах салбарт бэлтгэгдэж буй зарим төрөл мэргэжлийн боловсон хүчин нь тусгай мэргэжлээр улс орны захиалгаар гадаадын цэргийн их дээд сургуульд суралцуулах зайлшгүй шаардлагатай байдаг. Иймээс боловсон хүчин бэлтгэхтэй холбоотой зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэх шаардлага гарч байна.
- Нэг удаагийн тэтгэмжийн зардлыг төсөвлөсөн хэмжээнд хүргэж батлаагүйгээс шалтгаалан он дамжсан төсвийн өр үүсэх, ажлын байрыг чөлөөлж шинээр төгссөн алба хаагчдыг ажлын байраар хангах боловсон хүчний бодлого алдагдахад хүрч байна.

Дунд хугацаанд (2009-2016 он) батлан хамгаалах зардалд нөлөөлсөн хүчин зүйлсийн нөлөөллийг ХБКА (Хамгийн бага квадратын арга)-аар үнэлж тэгшитгэлийн хэлбэрийг бичвэл:

$$\text{Defcost} = 7338487186 + 1.1277\text{Urszar} - 1.6446\text{Budinv} - 2.0846\text{tataac}$$

$$r = 0.9 \quad \text{standart aldaa} = 11474984972 \quad F = 237.7551$$

Зардлуудыг 2010 оны зэрэгцүүлэх үнээр авч үзэн тооцоход стандарт алдаа, Фишерийн коэффициентүүд нь эерэг бөгөөд тэгшитгэлийн үнэлгээ (value) нэг хувийн түвшинд ач холбогдолтой гэвэл value 0.2-0.6 гарч байгаа тул үнэмшилтэй тэгшитгэл гэж үзлээ.

Тэгшитгэлийн эдийн засгийн утга агуулга нь дунд хугацаанд батлан хамгаалахын урсгал зардал 1 сая төгрөгөөр өсөхөд нийт батлан хамгаалах зардал 1.13 сая төгрөгөөр нэмэгдэж байна. Харин хөрөнгө оруулалтын болон татаас урсгал шилжүүлэг нийт батлан хамгаалах зардлыг бууруулж байгаа нь Зэвсэгт

хүчний техник технологийн шинэчлэл, нийгмийн хамгааллын асуудлуудад зарцуулах санхүүжилт хангалтгүйг илэрхийлж байна.

Батлан хамгаалах яамнаас 2015 онд гадаадын нийт 6 улс, орны Засгийн газар, Батлан хамгаалах яамтай идэвхтэй хамтран ажиллаж 21 удаагийн тээвэрлэлтээр нийт 67,9 тэрбум төгрөгийн буцалтгүй тусламж, хөнгөлттэй зээлийн бараа, бүтээгдэхүүнийг хүлээн авч Зэвсэгт хүчний зэвсэглэл, техник, тоног төхөөрөмж, эд материалын шинэчлэлтийг хийсэн нь өмнөх онд хүлээн авсан тусламжтай харьцуулбал гадаадын тусламжийн хэмжээг 20 гаруй хувиар нэмэгдүүлсэн байна. Үүнийг дараах байдлаар авч үзлээ.

Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хооронд 2004 онд байгуулсан “Монгол Улсад цэрэг-техникийн буцалтгүй тусламж үзүүлэх тухай” хэлэлцээрийн хүрээнд ОХУ-ын талаас нийт 41,302,866,928 төгрөгийн үнэ бүхий Т-72А танк, дагалдах зэвсэглэлийг хүлээн авч Батлан хамгаалахын сайдын тушаалаар Зэвсэгт хүчний Жанжин штабт хүлээлгэн өгчээ.

ОХУ-ын “Рособорон экспорт” компаниас Батлан Хамгаалах Аж Үйлдвэрийн Нэгдэлтэй хамтран нийт 205,755,840.00 төгрөгийн үнэ бүхий 7,62 мм-ийн автомат бууны сумыг татвараас чөлөөлүүлэн гаалийн бүрдүүлэлт хийж, ЗХЖШ-т олгосон байна.

БНТУ-ын буцалтгүй тусламжаар нийт 2,709,073,810.00 төгрөгийн цэргийн хүн нэг бүрийн хамгаалах хэрэгсэл буюу дуулга малгай, өвдгөвч, тохойвч, агсамж, үүргэвч, дижитал эрээн даавуун материал, цөлийн шар гутал зэрэг хувцас хэрэгсэл хүлээн авч, ЗХЖШ-т хүлээлгэн өгч Энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэх бие бүрэлдэхүүнээ хангасан байна.

АНУ-ын буцалтгүй тусламжаар нийт 207,167,033.00 төгрөгийн 20 хүний суудалтай англи хэлний иж бүрэн лингафони танхим, тоног төхөөрөмж, ном сурах бичиг хүлээн авч, Гадаад хэлний сургалтын төвд ашиглаж байна.

АНУ-ын буцалтгүй тусламжаар нийт 4,037,813,295.00 төгрөгийн Jeep-J8 Вранглер цэргийн зориулалттай жийп автомашин 35 нэгжийг хүлээн авч, ЗХЖШ-т хүлээлгэн өгч Энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэх анги салбаруудад ашиглаж байна.

АНУ-ын ЭСЯ-наас шалгаруулсан МонСон констракшн ХХК-тай хамтран барилгын засварын ажлуудыг эхлүүлсэн, Сангийн сайдын 2015 оны №52 дугаар тушаалаар нийт 3,418,807.36 ам.долларын барилга засварын ажлын санхүүжилтийг НӨАТ-аас чөлөөлүүлсэн байна.

ИБУИНВУ-ын буцалтгүй тусламжаар нийт 18,369,755.00 төгрөгийн англи хэлний 243 ширхэг ном сурах бичиг, 26 ширхэг програм хангамж диск, 10 иж DELL зөөврийн компьютер хүлээн авч, ЗХЖШ-т хүлээлгэн өгчээ.

ХБНГУ-аас буцалтгүй тусламжаар 4,0 тэрбум төгрөгийн үнэ бүхий цэргийн зориулалттай Юнимог автомашин 27 нэгж, эмнэлгийн мэс заслын багаж хэрэгслийг тус тус татан авч, Батлан хамгаалахын сайдын тушаалаар хуваарилсан байна. Афганистан Улсаас татан авах Герман улсын буцалтгүй тусламжаар нийлүүлэгдэх 60 нэгж Вольф бенз загварын суудлын автомашиныг хүлээн авах, 46 ширхэг чингэлгийн тээвэрлэлт, татан авах ажиллагаа үргэлжилж байна.

Монгол Улсын Батлан хамгаалах яам, БНХАУ-ын Батлан хамгаалах яам хооронд байгуулсан 2013А-014-ЈУ112 дугаар хэлэлцээрийн хүрээнд нийлүүлэгдсэн нийт 4,054,440,000.00 төгрөгийн 22 нэгж барилга зам инженерийн техник, хэрэгслийг хүлээн авч Зэвсэгт хүчний барилга инженерийн ангиудын хэрэгцээнд ашиглахаар төлөвлөөд байна.

2015 онд Батлан хамгаалах салбарын зэвсэглэл, техникийн шинэчлэлийн бодлогыг эрчимжүүлэх гадаад таатай орчныг бүрдүүлэх, гадаадын цэргийн буцалтгүй тусламжийн нэр төрөл, үр өгөөжийг дээшлүүлэх чиглэлээр бодлогын түвшинд дэмжин ажиллах талаар амжилт гаргаснаар өмнөх онд хүлээн авсан тусламжтай харьцуулбал гадаадын тусламжийн хэмжээг 20 гаруй хувиар нэмэгдүүлсэн байна. 2016 онд Зэвсэгт хүчний шинэчлэлийг гүнзгийрүүлэх, зэвсэглэл, техникийн шинэчлэлийн бодлогыг хэрэгжүүлэх, гадаадын тусламжийн үр өгөөжийг дээшлүүлэх талаар тодорхой ажлуудыг зохион байгуулсан байна.

Монгол Улсын Засгийн газар, Батлан хамгаалах яамнаас 2016 онд байгуулсан гэрээ, хэлэлцээрийн дагуу цэрэг-техникийн хамтын ажиллагаатай 2 улс /БНХАУ, БНТУ/-аас, цэргийн хамтын ажиллагаатай 2 улс /АНУ, ХБНГУ/-аас нийт 29,5 тэрбум төгрөгийн буцалтгүй тусламж хүлээн авсан байна.

Манай оронтой байгуулсан гэрээ, хэлэлцээрийн дагуу цэрэг-техникийн хамтын ажиллагаатай орнуудаас үзүүлсэн тусламжийн байдлыг 2.10 дугаар хүснэгтээр үзүүллээ.

2.11 дүгээр хүснэгт.

Манай оронтой байгуулсан гэрээ, хэлэлцээрийн дагуу цэрэг-техникийн хамтын ажиллагаатай орнуудаас үзүүлсэн тусламжийн байдал.

№	Цэргийн хамтын ажиллагаатай улс орнууд	Үзүүлсэн тусламж, хөрөнгийн хэмжээ	Эзлэх хувь
1	БНТУ	2.3 тэрбум төг	7,8%
2	БНХАУ	13.8 тэрбум төг	46.7 %
3	ХБНГУ	1.5 тэрбум төг	5.0%
4	БНФУ	4 сая төг	1.5%
5	АНУ	11.5 тэрбум төг	39.0%
	Нийт	29.5 тэрбум төг	100.0

Хүснэгтээс үзэхэд БНХАУ, АНУ хоёр нь 85.7%-ийг эзэлж байна. 2016 онд АНУ-аас буцалтгүй тусламжаар нийт 11,005,237,733.76 төгрөгийн Ланд Крузер 76 маркийн автомашин /35 нэгж/, эмнэлгийн тоног төхөөрөмж, тавилга, хэрэгсэл болон эмнэлгийн зөөврийн оношилгооны аппарат /2 ЭХО аппарат, 1 Ходоодны дуран/, Холбооны Харрис радио станц, дагалдах хэрэгсэл, сэлбэг, хүн нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, Англи хэлний иж бүрэн танхим зэргийг хүлээн авчээ.

*Зэвсэглэл, техникийн хангалт, гадаадын зээл тусламжийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах чиглэлээр шинжлэн үзвэл;*

Зэвсэгт хүчний зэвсэглэл, техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах чиглэлээр 2016 онд Зэвсэгт хүчний хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хүрээнд Зэвсэглэл, техникийн шинэчлэл, сэргээн сайжруулах засвар үйлчилгээнд зориулж нийт 11,5 тэрбум төгрөгийг тусгуулан /2 иж Лира-М радиолокацийн станцын засвар, сэлбэг, 1 иж П-18 РЛС-ын шинэчлэл, Ми-171Е загварын 2 нэгж нисдэг тэрэгний их засварын зардал/ худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулж, хэрэгжилтийг ханган Батлан хамгаалах чадавхыг нэмэгдүүлэхэд анхааран ажилласан нь судалгаанаас харагдаж байна. Эдгээр гэрээ, хэлэлцээрийн хүрээнд 2012 оноос 2016 оны хооронд Монгол Улсын Батлан хамгаалах чадавхыг нэмэгдүүлэхэд зориулагдсан зээл, тусламжийг нэгтгэн авч үзвэл:

**а.Цэрэг-техникийн хамтын ажиллагаатай орнуудаас (4 улс)**

1. Оросын Холбооны улс- 130,9 тэрбум төгрөг
2. БНХАУ - 20,5 тэрбум төгрөг
3. АНУ - 29,1 тэрбум төгрөг
4. БНТУ - 6,2 тэрбум төгрөг

**б. Цэргийн хамтын ажиллагаатай орнуудаас (4 улс)**

1. ХБНГУ - 2,9 тэрбум төгрөг
2. БНСУ - 4,6 тэрбум төгрөг

3. Израиль - 48,6 тэрбум төгрөг

4. ИБУИВУ - 18,3 тэрбум төгрөг

2015 онд Бүгд Найрамдах Австри Улсаас 15,7 тэрбум (7 сая Евро) төгрөгийн үнэ бүхий эмнэлгийн техник, тоног төхөөрөмжийг Засгийн газрын зээлээр олгосон байна. Нийт 209 969 940 758.42 (хоёр зуун есөн тэрбум есөн зуун жаран есөн сая есөн зуун дөчин мянга долоон зуун тавин найман төгрөг дөчин хоёр мөнгө) төгрөгийн хөнгөлттэй зээл, буцалтгүй тусламж авсан байна.

Батлан хамгаалах салбар дахь төсвийн санхүүжилтийн төлөвлөлтийн ойрын 5 жилийн тооцооллыг 2.12 дугаар хүснэгтээр үзүүллээ.

		Үзүүлэлт	2017	2018	2019	2020	2021	2022
1	ХУВЬ	ДНБ-д цэргийн зардлын эзлэх хувь	0,72 0,79	0,71 0,78	0,83 0,88	0,89 0,94	0,95 1,15	0,94 1,30
2		Төсвийн зарлагад батлан хамгаалах зардлын эзлэх хувь	2,75	2,70	2,80	2,83	3,0	3,4
3	Зардлын ангилал ( тэрбум төгрөг)	Урсгал зардал	265,80	269,70	270,85	273,45	280,95	295,91
4		Хөрөнгө оруулалтын зардал	158,75	160,05	165,13	169,40	181,30	185,45
5		Урсгал төсвийн хөрөнгөөр дайчилгааны нөөц бүрдүүлэх төсөөлөл	20,04	21,34	25,34	28,54	30,41	35,45
6		Хөрөнгө оруулалтын төсвөөр батлан хамгаалах нэгжүүдийн зэвсэглэл, техникийн шинэчлэлийн зардлын төсөөлөл	54,80	54,10	60,05	65,15	66,50	69,45
7		Цэргийн анги байгууллагуудын барилга байгууламжийг шинэчлэх зардлын төсөөлөл	24,95	25,80	29,50	30,05	32,50	34,50
8		Байнгын бүрэлдэхүүн, хугацаат болон гэрээт ЦАХ-ын алба хаах таатай орчныг бүрдүүлэх зардлын төсөөлөл	21,50	23,60	24,55	26,51	29,55	30,10
9		Салбарын ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх зардлын төсөөлөл	14,50	15,45	16,24	18,50	20,01	24,65

Батлан хамгаалах эдийн засгийн хэрэгцээ, Зэвсэгт хүчний тайван цагийн бэлэн байдал, эсвэл дайны цагт санхүүжүүлэх асуудал нь БХЭЗЧ-аас хамаарна.



Дэлхийн цэргийн хүчний зарцуулалт нэмэгдэж буй өнөөгийн нөхцөлд Монгол Улсын батлан хамгаалах салбарын төсвийн зарцуулалтыг нэмэгдүүлэх зайлшгүй хэрэгцээ шаардлага байна. Тухайлбал, ДНБ-д батлан хамгаалахын зардлын эзлэх хувь хэмжээг 2%-3%-д, төсвийн зарлагад батлан хамгаалах зардлын эзлэх хувь хэмжээг 3%-5%-д тус тус хүргэх нь чухал болоод байгааг судалгааны ажлаараа харуулж байгаа юм.

Улс орны хүчин чадавхыг судлаач Рэй Клайны<sup>40</sup> томъёолол дахь үзүүлэлтүүдээр үнэлэн тухайн улс орон олон улсын болон бүс нутгийн хэмжээнд ямар үзүүлэлттэй байгаа харж болдог байна.

Клайны томъёолол:

$$\text{Perceived power} = C+E+M \times (S+W)$$

*Pp* – *perceived power*. Хүлээн зөвшөөрөгдсөн хүчин чадал;

*C* – *critical mass= population + territory*. Энэ нь газар нутаг болон хүн амыг хамарсан ойлголт;

*E* – *economic capability*. Эдийн засгийн чадавх;

*M* – *military capability*. Цэргийн хүчин чадавх;

*S* – *strategic purpose*. Стратегийн зорилт;

*W* – *will to pursue national strategy*. Үндэсний стратегийн хангах зорилт гэж авч үзсэн байна<sup>41</sup>.

Клайны энэ томъёолол олон улсын тавцан дээрх тухайн улсын нөлөөг олон талаас нь харуулж байна.

Монгол Улсын хүч чадлыг дээрх томъёоллоос гадна үндэсний хүчин чадлын индексжүүлэлт /Index of National power/-ийн гаргасан судалгаанаас харахад дэлхийн 187 орноос газар нутаг болон хүн амыг хамарсан ойлголт /C/ -ын үзүүлэлтүүдээрээ 109-д, эдийн засгийн хүчин чадал /E/, цэргийн хүчин чадал /M/-ын гэсэн үзүүлэлтээрээ 135-д байна<sup>42</sup>. Монгол Улсын улс орноо батлан хамгаалахад зарцуулж байгаа зардлаараа өнөөдрийн байдлаар дэлхийн 153 оноос 121-рт орж байна. Иймд батлан хамгаалах хүчин чадавх хангалтгүй байгаа нь харагдаж байна.

<sup>40</sup> Ray S.Cline Ph.D executive director of the [Center for Strategic and International Studies at Georgetown University](#).

<sup>41</sup> Chin-Lung Chang. "Geopolitics and the Measurement of National Power".

<sup>42</sup> <http://www.nationalpower.info/national-power-rankings-2/>

Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдал, батлан хамгаалах чадавхын өнөөгийн байдалд хийсэн дүн шинжилгээнээс үзэхэд манай орны эдийн засгийг зайлшгүй нэмэгдүүлэх, батлан хамгаалах хүчин чадавхыг өсгөх шаардлагатайг харуулж байна.

### **ХОЕРДУГААР БҮЛГИЙН ДҮГНЭЛТ**

1. ЭЗАБ-д сөргөөр нөлөөлж буй гадаад, дотоод хүчин зүйлийг тодорхойлж, чиглэл бүрээр судалгаа хийж, нөхцөл байдлыг үнэлэв. ЭЗАБ-ын шалгуур үзүүлэлтийн тогтолцоог өргөтгөж, нийт 35 үзүүлэлтээр үнэлж үзэхэд 26 үзүүлэлт буюу 74% нь аюултай гэж үзэх босго үзүүлэлтийг давсан байна. Эдгээрээс 14 үзүүлэлт буюу 40% нь маш өндөр эрсдэлтэй, 12 үзүүлэлт буюу 34% нь өндөр эрсдэлтэй, 3 үзүүлэлт 9% буюу дундаж эрсдэлтэй, 6 үзүүлэлт буюу 17% нь бага эрсдэлтэй байна. Аюултай гэж үзэх босго утга, түүнээс давсан байдал нь эдийн засгийн аль нэг хүрээний уналт, үл оршин тогтнохыг тэр болгон харуулдаггүй ч тухайн салбарын аюулгүй байдал алдагдсан, тус салбарт гадны нөлөө өндөр байгааг илтгэж, аль чиглэлд илүү анхаарал хандуулж, шуурхай ажиллах шаардлагатай байгааг үзүүлдэг. Энэ байдал урт хугацаанд үргэлжилбэл манай улсын ЭЗАБ алдагдаж, гадаад улс орон, бүлэглэлүүдээс хараат байдалд орж, ард түмний язгуур ашиг сонирхолд хохирол учрах магадлал ойрхон байна гэж үзэв.
2. Дэлхийн улс орнуудын батлан хамгаалах төсөв нь ДНБ-ий 2-3 хувийг, төсвийн зарлагын 6 хүртэлх хувийг эзэлж байвал зохистой төсөв хэмээн үзнэ. Батлан хамгаалах салбарын батлагдсан төсвийн 40.0 хувийг ЦАХ-ын нийгмийн хамгаалалд, 20-30 хувийг зэвсэг техникийг шинэчилэхэд бусад хувииг судалгаа шинжилгээ, зохион бүтээлт зэрэгт зориулагдсан байхыг зохистой төсөв гэж үзэх хандлага байна. 2016 оны байдлаар Монгол Улсын төсвийн нийт зарлагад батлан хамгаалах салбарын төсөв 2,7 хувийг, ДНБ-д 0,79 хувийг эзэлж байна. Батлан хамгаалах салбарын төсөв болон салбарын үзүүлэлтүүд судалгаа шинжилгээний ажил гүйцэтгэхэд хаалттай сэдэв хэвээр байсаар байна.
3. Монгол Улсын мөнхийн хөрш орнууд болох ОХУ, БНХАУ нь дэлхийд хүчирхэг батлан хамгаалах салбартай байна. ОХУ нь батлан хамгаалах салбарын төсөвтөө зарцуулах хэмжээгээрээ дэлхийд 3 дугаарт, БНХАУ нь ЗХ-дээ зарцуулах төсвийн хэмжээгээрээ дэлхийд 2 дугаарт байна. Иймд Монгол Улсын хувьд хүчирхэг 2 гүрний дунд хэрхэн Улсаа батлан хамгаалах, Аюулгүй байдлаа яаж хангах вэ гэсэн асуудал тулгарч байна.
4. Батлан хамгаалахын 2016 оны төсөвт нэмэлт тодотголоор тусгах нэн шаардлагатай 17,3 тэрбум төгрөгийг шийдвэрлүүлж, улмаар 2017 оны төсвийн

тодотголоор Зэвсэгт хүчний анги, салбаруудад хуримтлагдсан өр болох 10,8 тэрбум, Цэргийн Төв Эмнэлэг болон Үндэсний Батлан Хамгаалах Их Сургуульд 3,3 тэрбум, "UBM" төслийг хэрэгжүүлэхэд 25 тэрбум, нийт 39,2 тэрбум төгрөгийг нэмэгдүүлж чадлаа. Түүнчлэн 2015 оноос хойш "Зэвсэгт хүчний хөгжлийн сан"-аас санхүүжүүлж байсан цэргийн алба хаагчдын нормын хувцас, хэрэглэл болон сургалт, үйлдвэрлэлийн зардалд 2018 оны улсын төсөвт 5 орчим тэрбум төгрөгийн санхүүжилтийг суулгах зохицуулалтыг хийж, УИХ-д өргөн барьж, шийдвэрлүүлэхээр ажиллаж байгаа нь ач холбогдолтой юм.

5. Батлан хамгаалах салбарыг хөгжүүлэх, зэвсэг техникээ шинэчлэх, цэргийн сургалтыг чанартай зохион байгуулах, эрдэм шинжилгээ судалгаа, туршилтыг явуулах, ЦАХ-ын нийгмийн хамгааллыг сайжруулах, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх зэрэг асуудлыг шийдвэрлэхэд Монгол Улсын батлан хамгаалах салбарын батлагдсан төсөв нь өнөөгийн шаардлагыг хангаж чадахгүй байна гэж үзлээ.

## **ГУРАВДУГААР БҮЛЭГ. МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛТАЙ УЯЛДУУЛЖ, БАТЛАН ХАМГААЛАХ ЭДИЙН ЗАСГИЙН ЧАДАВХЫГ НЭМЭГДҮҮЛЭХ АРГА ЗАМ**

Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдал, батлан хамгаалах чадавхын өнөөгийн байдалд хийсэн судалгаа, шинжилгээн дээр тулгуурлан БХ эдийн засгийн чадавхыг нэмэгдүүлэх дараах арга замыг санал болгож байна.

Монгол Улсын төсөв тэлж, санхүүгийн үйл ажиллагаанд тавигдах шаардлага өндөрсөхийн хэрээр төсвийн ил тод, хариуцлагатай байдал, үр ашгийн асуудлууд чухлаар тавигдах болсон бөгөөд төсвийн мэдээллийг ил тод болгох, төсөв боловсруулах үйл явцад олон нийтийн оролцоог хангах алхмууд хийгдэж байна. Түүнчлэн 2016 оноос хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн Монгол Улсын “Төсвийн тухай” хууль, “Төсвийн тогтвортой байдлын тухай” хуульд энэ үйл ажиллагааг идэвхжүүлэх нөхцөлүүдийг тусгажээ.

Батлан хамгаалах эдийн засгийн чадавхыг нэмэгдүүлэх нэг чухал нөхцөл нь төсвийн хуваарилалт түүний ил тод байдал, хариуцлагатай байдлыг дээшлүүлэх явдал юм. Төсвийн мэдээллийг ил тод болгож, төсвийн зарлагыг тайлагнадаг болсноор нийгэмд итгэлцэл бүрдэж, зах зээлийн эрсдэл ба мэдээллийн тэнцвэртэй бус байдал буурч, зах зээлтэй илүү үр дүнтэй харьцах боломж бүрддэг. Гэхдээ амьдрал дээр төсвийн ил тод байдал хангалтгүй, иргэдийн оролцоо бага, үр дүн хангалтгүй хэвээр байна. Иймээс Батлан хамгаалах эдийн засгийн чадавхыг нэмэгдүүлэх боломж, нөхцөлийг шинжлэх ухааны үндэслэлтэй судалж, асуудлыг шийдвэрлэх арга замыг тодруулах шаардлагатай байна.

### **3.1. Монгол Улсын эдийн засаг болон батлан хамгаалах чадавхын уялдаа холбоог сайжруулах арга зам**

Өнөөгийн байдлаар Монгол Улсад үүсээд байгаа эдийн засгийн хүндрэлтэй байдал нь, батлан хамгаалах чадавхад ихээхэн нөлөө үзүүлж байна.

Манай улсын үйлдвэрлэлийн хэмжээ, эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлсний үндсэн дээр, БХ-ын төсвийг үе шаттайгаар нэмэгдүүлж улс орны батлан хамгаалах хүч чадлыг өсгөх боломж бүрдэнэ. Өөрөөр хэлбэл, батлан хамгаалах салбарын төсвийг нэмэгдүүлэх хүчин зүйлүүдийг судалж үзсэнээр батлан хамгаалах салбарын төсөв нэмэгдэх боломжийг харж болно. Ийм нөхцөлд эдийн засгаа хөгжүүлэх БХЭЗЧ-аа бүрдүүлэн бэхжүүлэх бодлого, стратегиа боловсруулан хэрэгжүүлэхэд тэдгээрийн хоорондын уялдаа холбоог

харгалзан үзэх нь гол хүчин зүйл байх болно. Өөрөөр хэлбэл эдийн засгийн хямрал Монгол Улсад ойрын 5 жилдээ үргэлжлэн эдийн засгийн нөхцөл байдал сайжрах хандлага судалгааны ажлын үр дүнгээс харагдахгүй байна.

Дэлхийн банк болон эрдэмтэн судлаач нарын гаргасан дүгнэлтээс харахад улс орны эдийн засгийн нөхцөл байдал сайжран батлан хамгаалах салбарт хийх хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх боломж бага гэсэн дүгнэлт хийж болохоор байна. Бидний хийж буй энэхүү судалгааны ажлын нэгдүгээр бүлэгт эдийн засгийн аюулгүй байдал, түүний орчин, хүчин зүйлс нь батлан хамгаалах чадавхад нөлөөлөх зүй тогтол, сургамжийг судалж тодорхой санал дүгнэлт хийсэн билээ. Тэгвэл орчин үед үндэсний аюулгүй байдалд заналхийлэх аюул нь дээд эрэмбийн технологийн хөгжил, дэлхийн геополитикийн тогтолцоо, геостратегийн ашиг сонирхлоос хамаарч шинэ өгөгдөхүүн, шинэ арга тактик, шинэ хэрэгсэлтэй болжээ.

Монгол Улсын эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдал, БХ болон аюулгүй байдлын шинэ орчин, сорилт сургамж нь төсвийн илүү үр ашигтай тогтолцоог бий болгохыг шаардаж байна. Техник технологийн хөгжлийн энэ эрин үед аль нэгэн улс орон өөрийн БХ асуудлыг дангаараа буюу бие даан хангах боломжгүй болж байгаа бөгөөд БХ асуудал нь тухайн улс орны нийгэм, улс төр, эдийн засгийн байдал болон гадаад орчинд бий болж байгаа өөрчлөлтөөс хамаарах болсон.

БХЭЗЧ гэдэг аливаа улс орны улс төр, БХ зорилтыг шийдвэрлэх зорилгоор улсын эрх ашигт ашиглагддаг, ашиглаж болох эдийн засгийн чадавхын бүрэлдэхүүн хэсэг юм. БХЭЗЧ нь улс орны тайван цагийн болон дайны үеийн эдийн засгийн хангалтад түүний дотор ЗХ-ний хэрэгцээнд хүрэлцэхүйц материал баялагийн цогц ойлголт юм.<sup>43</sup>

Нийгмийн амьдралын бүхий л салбарт түүний дотор аюулгүй байдал, БХ салбарт ч нэгэн адил эвсэн нэгдэх ойлголт, хандлага давамгайлах боллоо. БХ зорилтыг хангахад дэлхийн улс орнуудын харилцан ойлголцол, зөвшилцөл, итгэлцэл бие биеэ хүндэтгэсэн харилцан ашигтай хамтын хүчин чармайлт түншлэл чухал бөгөөд одоо үед ийм хандлага давамгайлж байна. Ийм нөхцөл байдал гадаадын геополитикт уягдсан гео-стратеги, гео-эзлэн түрэмгийлэл, хязгааргүй дайны хэрэгсэл, хязгааргүй нөлөөллийн технологи гэх мэт. Аливаа улс орныг (ялангуяа эрчим хүчний стратегийн түүхий эд баялаг ихтэй) хүрээгээ тэлж байгаа өнөөгийн нөхцөл байдал үндэсний аюулгүй байдлын бодлого, хууль эрх зүйн орчин, сөрөг нөхцөл байдал үүсэхэд шуурхай арга хэмжээ авах үндэсний аюулгүй

<sup>43</sup>Батлан хамгаалах эдийн засгийн зарим асуудал

байдлын бүтэц, зохион байгуулалтыг сайтар хангах зайлшгүй шаардлага тулгараад байгааг анхааралдаа авах нь зөв болов уу.

Батлан хамгаалах салбар нь төсвөө Үндэсний аюулгүй байдлын бодлогоор тодорхойлогдсон Зэвсэгт хүчний үүрэг зориулалтад нийцсэн мэргэжлийн сургалт, бие бүрэлдэхүүний нийгмийн асуудал, зэвсэглэл техник болон бусад шаардлагатай зүйлд хуваарилан зарцуулдаг. Энэ “хэтэвчний эрх мэдэл” нь Үндэсний Аюулгүй байдлыг хангах субъектүүдийн бодлого, үйл ажиллагааг хянах гол хөшүүрэг болдог. Ийнхүү гүйцэтгэх болон хууль тогтоох засаглал нь нөөцийг хуваарилах эрх мэдлийг эдэлснээр дээрх хяналтыг улам бэхжүүлнэ.

Тухайн жилийн төсөв батлагдсаны дараа ирэх жилийн төсвийг боловсруулж эхлэх бөгөөд төсвийг батлан, хуваарилах процесс нь цэргийн байгууллагыг хянах, үр ашигтай шийдвэр гаргахад чухал ач холбогдолтой. Батлан хамгаалах стратеги, бодлогыг Засгийн газар жил бүр хэлэлцэн, зөвхөн онцгой ач холбогдолтой хөтөлбөр, төслийг сонгох асуудалтай тулгардаг. Эдгээр хөтөлбөр, төслийн санхүүжилтийг батлах эрх мэдлийг хууль тогтоогчид эдэлдэг бөгөөд үүнийг иргэний хяналтын нэг үндсэн хөшүүрэг хэмээн ойлгож болно.

Улс орны эдийн засгийн чадавхын түвшингээс БХЭЗЧ хамаарч шалтгаалдаг нь аль ч улсад үйлчлэх бодит зүй тогтолт үзэгдэл юм.

БХЭЗЧ-ын бүрэлдэхүүн хэсгийг газар зүйн байршил, байгалийн баялаг боловсрол, шинжлэх ухааны хөгжил, үйлдвэрлэлийн чадавх, техник технологийн түвшин, хүн ам, ажиллах хүчин, батлан хамгаалах хүчин, үндэсний уламжлалт онцлог, дипломат харилцаа, нэг хүнд оногдох ДНБ, санхүүгийн орчин, төр, засгийн тогтвортой үйл ажиллагаа зэргээр тодорхойлж болох юм.

Улсын эдийн засаг болон батлан хамгаалах чадавхын уялдаа холбоог сайжруулах шалгуур үзүүлэлтийг дараах байдлаар тодорхойлж байна.

- ДНБ-ний хэмжээ;
- эдийн засгийн өсөлт;
- өрсөлдөх чадвар;
- төсвийн алдагдал;
- улсын өр;
- шинжлэх ухаан, шинэ технологийн ололт;
- инфляцийн түвшин;
- ажилгүйдлийн хэмжээ гэсэн үзүүлэлтийг хэрэглэнэ.

БХЭЗЧ-ыг дан ганц дотоод хүчин зүйлээр гүйцэлдүүлэх боломжгүй юм. Ийм учраас гадаад хүчин зүйлийн боломжийг зөв ашиглаж үр дүнд хүрэх бодит шаардлага байна.

БХ салбарын гадаад харилцаа, хамтын ажиллагааг эдийн засгийн агуулгаар баяжуулан хөгжүүлж тэлэх замаар БХЭЗЧ-ыг бүрдүүлэн бэхжүүлэх үр дүнд хүрэх боломж байна гэж үздэг. Харамсалтай нь ардчиллын замаар хөгжиж буй зарим улсын хувьд Үндэсний аюулгүй байдлын асуудалд төр, засгийн удирдлага төдийлөн ач холбогдол өгөлгүй, харин нийгмийн бусад тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд ихээхэн цаг хугацаа, нөөц боломжийг зарцуулдаг.

Монгол Улсын эдийн засаг болон батлан хамгаалах чадавхын уялдаа холбоог сайжруулах, бэхжүүлэх арга замын талаар БХЭШХ-ийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, шинжлэх ухааны доктор, профессор Ш.Паламдорж, доктор, профессор Ж.Энхбаяр нарын 2010 хийсэн “Батлан хамгаалах эдийн засгийн зарим асуудал сэдэвт” судалгаагаар “БХЭЗЧ-ыг бүрдүүлэн бэхжүүлэхэд зохимжтой үндэсний эдийн засгийн салбарын бүтцийн загвар нь “ISA” загвар” хэмээн тодорхойлсон байна.

Энэ загвар нь: Аж үйлдвэр (I) +үйлчилгээ (S) +хөдөө аж ахуй (A),= зөв төлөвлөлт гэсэн утгаар илэрхийлэгдэж байна. Энэ загвараар эхлээд улс орны аж үйлдвэрийн хөгжлийг шинэчлэн хурдасгахын зэрэгцээгээр үйлчилгээний (аялал жуулчлал гэх мэт) салбаруудыг ахиу хөгжүүлэн, уламжлалт ХАА–н салбарыг нэмэгдүүлэн хөгжүүлэх нь тулгамдсан асуудал гэж үзлээ. Өөрөөр хэлбэл дотоодын нийт бүтээгдэхүүнд эдийн засгийн тухайн салбарын эзлэх хувийн жингээр Монголын үндэсний эдийн засгийн салбарын бүтцийг ямар байдал, харьцаагаар хөгжүүлэх нь чухал болохыг тодорхойлсон байна.

Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” –д “Эдийн засгийн тогтвортой хөгжлийн зорилтыг хангахын тулд макро эдийн засгийн зохистой бодлогыг хэрэгжүүлж, эдийн засгийн бүтцийг төрөлжүүлнэ. Хөдөө аж ахуй, аж үйлдвэр, түүний дотор хөнгөн, хүнс, барилгын материал, зэс боловсруулах, нүүрс, нефть-хими, хар төмөрлөгийн үйлдвэрлэл, аялал жуулчлал, уул уурхайн олборлох салбарын хөгжилд тэргүүлэх ач холбогдол өгч, эрчим хүч, дэд бүтцийн салбарыг түрүүлж хөгжүүлнэ<sup>44</sup> гэж заасан нь БХЭЗЧ-ыг нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой болно.

Мөн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон бэлчээрийн малын удмын сан, тэсвэрт чанарыг хадгалж, ашиг шимийг нь нэмэгдүүлэх ... олон улсын зах

<sup>44</sup> Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, 2016.

зээлд өрсөлдөх чадвартай мал аж ахуйн салбарыг хөгжүүлнэ<sup>45</sup> гэсэн нь үндэсний эдийн засгийн салбарын бүтцийн загвартай дүйцэж байна.

Манай Улсын малын толгой 2016 оны жилийн эцсийн байдлаар 61.5 саяд хүрч өмнөх оныхоосоо 9,9% өсч, түүхэндээ хамгийн олон мал тоолуулсан байна. Мөн ургацын урьдчилсан балансаар нийтдээ 482.1 мянган тонн буудай үтрэм дээр бууж, цэвэр жингээр 462.1 мянган тонн буудай зарцуулагдаж байна. Үүнээс 2017 оны тариалалтад зориулан 45.6 мянган тонн үр, улсын үрийн нөөцөд 7.5 мянган тонн, тэжээлд 22.8 мянган тонн, спиртийн үйлдвэрт 10.3 мянган тонныг тус тус зарцуулснаар гурил үйлдвэрлэлд нийтдээ 375.7 мянган тонн буюу дотоодын хэрэгцээгээ хангах хэмжээний буудай нийлүүлэгдсэн байна.

Өндөр хөгжилтэй орнуудын хөгжилт нь газар, газрын доорх баялаг улсын мэдэлд байж түүн дээр хувийн компаниуд ажиллуулж хөгжлийн тусгай санг бий болгодог байна. Тухайлбал Норвегийн Улсын баялагийн сан нь 900 тэрбум орчим доллар болсон байна. Энэ нь Саудын Араб, Мексик зэрэг орны хөрөнгөөс ч илүү хэмжээнд хүрнэ. Хөгжлийн сангийн 2 хувийг л Улсын ерөнхий сайд нь мэдэж зарцуулдаг байна. Онцгой нөхцөл бий болсон үед хууль тогтоомжоор 4 хувийг хүртэл зарцуулах эрхтэй юм байна.

Манай орон ХАА, газар тариалангаа хөгжүүлж, улс орныхоо үзэсгэлэнт байгаль орчин, уламжлалт хөдөө аж ахуйнхаа байдлыг түшиглэн аялал жуулчлалыг хөгжүүлэх, орчин үеийн шинэ технологийг ашиглан үйлдвэржүүлэлт (хөнгөн болон хүнсний, хими, уул уурхай АҮ хөгжүүлэх) хийхийг шаардлагатай гэж үзлээ. Зөвхөн уул уурхайгаас Монгол Улсын хөгжлийн тусгай санг бий болгож, ард түмний хатуу хяналтад байлгах нь зүйтэй юм.

Манай орны аялал жуулчлалын салбарыг уул уурхайн дараа орох стратегийн ач холбогдолтой хэмээн судлаачид тодорхойлсон байдаг. Учир нь аялал жуулчлалын салбар бол байгаль дэлхийд ээлтэй, хог хаягдал багатай, ард түмний соёл, ёс заншилтай харшилдаггүй, эдийн засгийн хувьд үр өгөөжтэй зэрэг давуу талтай. Харин манай аялал жуулчлалын салбар бүрэн хүчин чадлаараа ажиллаж чадахгүй байна. Сүүлийн үед манай орны аль ч аймаг, орон нутаг ялангуяа Хөвсгөл, Өвөрхангай, Архангай зэрэг чиглэлд аялах дотоодын болоод гадаадын жуулчдын тоо нэмэгдсэн бөгөөд бусад бүс нутгуудад ч аялал жуулчлал хөгжих боломжтой болжээ. Иймээс цаашид Монгол орны нутгийг жигд хамарсан, тухайн нутгийн онцлогт тулгуурласан арга хэмжээ авах шаардлагатай байна. Дээрх шаардлагын үүднээс нийт нутгийг баруун, зүүн, төв, говийн, Улаанбаатарын

---

<sup>45</sup> Мөн тэнд



гэсэн бүсчлэлд хуваан, тухайн бүсийн онцлогт тулгуурласан аялал, жуулчлалын бодлого хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байдаг.

Манай орны үйлдвэрийн өрсөлдөх чадвар 133 орны 109 дүгээрт эрэмбэлэгдэж байна. Нийт боловсруулах үйлдвэрлэлд дунд, өндөр технологи дөнгөж 5.3 хувийг эзэлж байна. Энэ нь манай хоёр хөрш ОХУ-аас дөрөв дахин, БНХАУ-аас найм дахин доогуур үзүүлэлт юм. Дэлхийн эдийн засгийн эерэг шалгуур үзүүлэлтээр боловсруулах үйлдвэрлэлийн ДНБ-д эзлэх хувь 20 хувь байдаг бол манай улсынх 8-9 хувьтай байгаа нь цаашид боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд анхаарал хандуулах шаардлагатай байгаагийн илэрхийлэл юм.

Манай улсын хэмжээнд 50 гаруй мянган аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулдаг. Нийт аж ахуйн нэгжийн 98 хувь нь жижиг дунд үйлдвэр байдаг. Мөн 400 орчим хувьцаат компани байдаг нь нийт аж ахуйн нэгжүүдийн 2 орчим хувийг эзэлдэг хэдий ч дотоодын нийт бүтээгдэхүүнд эзэлж байгаа хувийн жин нь харьцангуй өндөр юм. Тухайлбал, уулын баяжуулах “Эрдэнэт үйлдвэр, Цахилгаан станцууд нь улсын төсвийн талаас илүү хувийг бүрдүүлдэг. Жижиг дунд үйлдвэрт манай улсын нийт ажил эрхлэгчдийн 80 гаруй хувь нь ажилладаг.

Аж үйлдвэржилтийн процессийг явуулахад үйлдвэржилтийг цогцолбороор нь хөгжүүлэх шаардлага зүй ёсоор тавигддаг. Монголд үйлдвэрлэж байгаа нийт бүтээгдэхүүний 10-аас доош хувь нь өндөр технологи шингэсэн дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүн байгаа нь энэ чиглэлээр амжилт олох нэгэн үндэс болно. Иймд “ISA” загварыг ашиглах нь зүйтэй хувилбар мөн.

Доктор Д.Энхчимэгийн 2016 онд хийсэн “Монгол улсын эдийн засгийн аюулгүй байдлыг төсвийн бодлогоор дэмжих арга зам” судалгааны ажлаараа дэвшүүлсэн Батлан хамгаалах эдийн засгийг хангах гурван хувилбарыг өнөөгийн нөхцөлд тодорхой судалгаан дээр суурилсан үндэслэлтэй санал гэж үзэж байна.

**Хэвийн нөхцөл:** Эдийн засаг тогтвортой байж, тодорхой хурдацтай хөгжиж, улс орны дотоод болон дэлхийн бусад улс орнуудын практикт байгаа нийтээр хүлээн зөвшөөрөхүйц хязгаарлалтын хэм хэмжээний хүрээнд Зэвсэгт хүчнээ тогтвортой санхүүжүүлэх байдал.

**Тогтвортой хязгаарлалтын нөхцөл:** Гүнзгий хямралын дараах эдийн засгийн өсөлтийн үе шатанд ажиглагддаг онцлог нөхцөл байдал бөгөөд ерөнхийдөө уг хязгаарлалтыг урьдчилан төсөөлж, цэргийн байгуулалтын зохих хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх боломжтой.

**Хатуу хязгаарлалтын нөхцөл:** Цэргийн байгуулалтыг хөгжүүлэх төлөвлөгөөт арга хэмжээг хэрэгжүүлэх боломж хүндрэлтэй.<sup>46</sup>

Эдийн засаг тогтворгүй байх нөхцөлд батлан хамгаалах төсвийг бууруулах хандлага байдагтай уялдан батлан хамгаалах төсвийн доторх санхүүгийн хөрөнгийг анхдагч хувилбарын хувьд зориулалтаар нь дахин хуваарилах шаардлага гарна.

Монгол Улсын эдийн засагт үүссэн нөхцөл байдлаас үүдэн Батлан хамгаалах төсвийг зохиох, батлах, бүх үе шатанд зорилт, тэргүүлэх чиглэлүүдээр хязгаарласан санхүүжилтийг хамгийн оновчтой хуваарилах хувилбарыг бий болгох хэрэгтэй болж байна. Тиймээс дээрх нөхцөл байдлаас үүдэн батлан хамгаалах төсвийг боловсруулах аргазүйн санал зөвлөмжийг дэвшүүлж байна. Үүнд:

**>Тэргүүлэх чиглэлийг тодорхойлох зарчим:** Эдийн засгийн хатуу хязгаарлалтыг баримталж байгаа энэ нөхцөлд БХ салбар, Зэвсэгт хүчний ангиудын гүйцэтгэх үүрэг, тэргүүлэх чиглэлүүдийг төлөвлөх.

*Тодруулга: Өөрөөр хэлбэл тухайн анги байгууллагын захирагч нарт ЗХЖШ-ын даргаас өгсөн оперативийн удирдамж нь тэргүүлэх чиглэл болно гэсэн үг.*

**>Хувилбарын зарчим:** Монгол Улсын эдийн засагт үүссэн хүндрэлтэй нөхцөл байдлаас Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчнийг хөгжүүлэх төсвийн захиалгын хувилбаруудыг боловсруулж, төр засгийн удирдлагад танилцуулах зөв таниулан ойлгуулах зарчим юм.

*Тодруулга: Батлан хамгаалах салбар, Зэвсэгт хүчнийг хөгжүүлэх арга хэмжээг цар хүрээ, төсвийн хувьд тогтоосон байхад зардлыг аль болох зөв хуваарилахад хувилбарын зарчим нэн ач холбогдолтой байдаг бөгөөд зэвсэглэл болон бие бүрэлдэхүүний тоо, чанар, санхүүгийн зардлын чиглэл, хүрээг тодотгон зохицуулах замаар энэ зорилтод хүрнэ.*

**>Тэнцвэрт байдлын зарчим:** Батлан хамгаалах- удирдлагын, Зэвсэгт хүчин-байлдааны, Хөгжлийн-хангалтын гэсэн гурвалжин пирамид хүч хэрэгслийг зохицолт байдлаар хөгжүүлэх явдлыг өөртөө багтаадаг байна.

<sup>46</sup> Д.Энхчимэг “Монгол улсын эдийн засгийн аюулгүй байдлыг төсвийн бодлогоор дэмжих арга зам” докторын диссертаци. УБ., 2016.

**>Зорилгот-хөтөлбөр-төлөвлөлтийн зарчим:** Улс орны хөрөнгө нөөц болон цэргийн байгуулалтын зорилго, зорилтуудыг нягт уялдаатай шийдвэрлэх боломж олгодог.

**>Зохицох зарчим:** Өмнөх жилүүдийн Батлан хамгаалах бодит зардал, тэргүүлэх чиглэл, бий болсон ажлыг харгалзан үзэж шинэ санхүүжилтийг оновчтой хуваарилах явдал юм.

**>Шууд санхүүжүүлэх төлөвлөлтийн зарчим:** Зохион бүтээх үе шатанд байгаа зэвсэглэл, цэргийн техникийн "оршин байх" мөчлөгийн нийт зардлыг шинжлэх ухаан судалгааны ажилд хуваарилах асуудал юм.

Батлан хамгаалах бодлогыг шинжлэх ухааны үндэслэлтэй боловсруулах, батлан хамгаалах салбарын үйл ажиллагааг ил тод болгох нь иргэний хяналтын агуулгыг илүү үр ашигтай болгодог. Түүнчлэн иргэний хяналтын асуудлыг нийгмийн талаас нь судлах шаардлагатай байна. Иймд энэ чиглэлийн судалгааг чанаржуулахын тулд өндөр хөгжилтэй орнуудын судалгааны байгууллагуудтай хамтарсан төсөл хэрэгжүүлэх, туршлага судлах нь зүйтэй.

**>Нээлттэй байх зарчим:** УИХ Батлан хамгаалах төсвийг аль болох нарийн заалт бүрээр хэлэлцэж Зэвсэгт хүчний хэрэгцээ, шаардлагыг үндэслэлтэй боловсруулахад оролцох замаар иргэний хяналтыг хэрэгжүүлэх нь тодорхой үр дүнд хүргэж болно гэж үзэж байна. Иймд Батлан хамгаалах салбарын шинэчлэлийг идэвхжүүлэх гол хүчин зүйл болох Батлан хамгаалах төсвийг нэмэгдүүлэхийн тулд УИХ-ын гишүүдийг Батлан хамгаалах салбарын талаар цэгцтэй мэдээллээр хангах механизмыг бий болгох, албан болон албан бус харилцааг хөгжүүлэх, батлан хамгаалах төсөв боловсруулах мэргэжлийн чадварлаг баг бүрдүүлэх шаардлагатай байна. Энэ зарчим бий болсон шалтгаан нь улс орнуудын цэргийн бэлтгэл, зэвсэглэлээр хөөцөлдөхийг хязгаарлах, татвар төлөгчдөөс төвлөрүүлсэн үйлдвэрлэлийн бус зардал болох цэргийн зардлын талаарх олон нийтийн зүгээс анхаарал хандуулах болсонтой холбоотой юм.

Батлан хамгаалах салбарын шинэчлэл нь улс орны цогц өөрчлөлт шинэчлэлтийн бүрэлдэхүүн хэсэг бөгөөд эдийн засаг, улс төр, нийгэм, эрхзүй, цэргийн зэрэг өөрчлөлтийг багтаасан нийгмийн төвөгтэй үзэгдэл юм. Иймд дотоодын тогтвортой байдлыг хангах нь "нийгмийн хамгаалалтын" болон "эдийн засгийн хамгаалалтын" үүрэг болдог. Эдийн засгийн болон нийгмийн хамгааллын бүрдэл хэсэг нь хоорондоо нягт уялдаа холбоотой бөгөөд манай нийгмийн хөгжлийн онолын үндэслэл одоогоор хараахан бүрэн боловсрогдохгүй байгаа боловч ийм цогц хөгжлийн онолын бодлогын үндэслэлийг бий болгосон үед л

ЭЗАБ-ын тодорхой, урт хугацаанд мөрдөгдөх үзэл баримтлалыг боловсруулах бололцоотой юм гэж судлаачид, эдийн засагчид үздэг.

Төсвийн зардлыг ангилах нь чиг үүргээр зардлыг хуваарилах шийдвэрийн үндэслэлийг сайжруулах, зориулалтын дагуу зарцуулж байгаад хяналт тавих, түүнчлэн цэргийн зардлын хэмжээ, бүтцийн хувьд харьцуулан шинжлэх боломж олгож, төсвийн санхүүжилтийн ерөнхий тогтолцоонд ихээхэн үүрэгтэй байдаг бөгөөд цэргийн зардлын ангиллын шинжлэх ухааны үндэслэлийг сайжруулах, практик хэрэгцээнд нийцүүлэх боломж олгодог байна.

Батлан хамгаалах чадавхыг нэмэгдүүлэх, хөгжүүлэх асуудлыг зорилго, зорилтууд, хугацаа, гүйцэтгэгч, нөөц, хуваарилсан санхүүгийн хөрөнгөөр бүхэлд нь нягт уялдуулсан цогц тогтолцоог бүрдүүлэх нь төлөвлөсөн арга хэмжээг хэрэгжүүлэх, төсөвлөсөн санхүүгийн хөрөнгийг үр өгөөжтэй ашиглахад нөлөө үзүүлдэг байна. Энэхүү хөтөлбөрийн давуу тал нь цэрэгт үзүүлэх дэмжлэг, батлан хамгаалах чадавхыг зохих түвшинд бий болгож чаддаг байна.

**Батлан хамгаалах төсөв зохиох үйл явцыг боловсронгуй болгох зорилгоор :**

**Нэгд:** Батлан хамгаалах төсвийг боловсруулах, батлах, хэрэгжүүлэх олон талт төвөгтэй шинжийг агуулсан "зардал", "санхүүжилт", "үүрэг зорилт" гэсэн харилцан уялдаатай санхүүгийн үзүүлэлтийн тогтолцоог хэрэглэхэд шилжих.

**Хоёрт:** Батлан хамгаалах төсвийн зориулалтыг хуульчлан сахих.

**Гуравт:** Тайлан, бүртгэл тооцоо, зэвсэг, техникийн захиалга, цэргийн бүтээгдэхүүний үнэ, бүрдэл зэрэг асуудлыг боловсронгуй болгох.

**Дөрөвт:** Зах зээлийн нөхцөлд Батлан хамгаалах-Эдийн засгийн үйл ажиллагааг удирдах шинэ механизмыг бий болгох.

**Тавд:** Иргэний засаглал, нийгмийн зүгээс Батлан хамгаалах төсвийн зарцуулалтад байнга хяналт тавих шаардлага зүй ёсоор тавигддаг нь ойлгомжтой.

Төсвийн төлөвлөлтийн зорилгот хөтөлбөрийн хандлага нь **нэгд**, Зэвсэгт хүчний байгуулалтыг хөгжүүлэх хэтийн төлөвийг тодорхойлох, **хоёрт**, тавигдсан зорилгод хүрэх арга хэмжээг цогц байдлаар авч үзсэн дунд хугацааны хөтөлбөрийг боловсруулах, **гуравт**, батлан хамгаалах төсвийг боловсруулах гэсэн хоорондоо нягт уялдаатай дараалсан гурван үе шатыг багтааж байна.

Батлан хамгаалах салбар (Зэвсэгт хүчин) –ыг хөгжүүлэх **төлөвлөлтөд зорилгот-хөтөлбөр-төлөвлөлтийн** аргыг хэрэглэснээр олон давуу боломжийг олгоно. Үүнд:

1. Зэвсэгт хүчний байгуулалтын уламжлалт төлөвлөлт болон жил бүрийн батлан хамгаалах төсвийн боловсруулалт хоорондын нягт уялдаагүй байдал арилж, батлан хамгаалах төсвийн төлөвлөлт, хөтөлбөржүүлэлт болон боловсруулалтын явц нэгдмэл тогтолцоотой болох.
2. Улс орны санхүүгийн болон эдийн засгийн боломжийг харгалзан тооцсон нөөцийн хүрэлцээтэй, бодитоор биелэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх.
3. Зэвсэгт хүчний урсгал болон хэтийн хэрэгцээг үнэн зөв үндэслэлтэй тодорхойлж, хөтөлбөр бүрийн хүрээнд өртөг зардлыг үнэлэх, бүхэлд нь өртөг зардлыг хүлээгдэж буй үр дүнтэй нь харьцуулан жиших.
4. Зэвсэгт хүчинд тавигдсан зорилгод хүрэх олон хувилбарыг боловсруулан харьцуулан жишиж, батлан хамгаалахын төсвийн хязгаарлагдмал санхүүжилтийг хуваарилах асуудлыг хөтөлбөр тус бүрээр оновчтой шийдвэрлэх боломжтой хувилбарыг сонгох.
5. Батлан хамгаалахын төсвийг цэргийн хөтөлбөрүүдтэй, хөтөлбөрүүдийг батлан хамгаалахын төлөвлөлт болон Зэвсэгт хүчний бүтэц, бүрэлдэхүүний хэмжээ, түүнийг цэргийн номлолтой, цэргийн номлолыг улсын үндэсний сонирхол, улс төрийн зорилго, төлөвлөгөөтэй уялдуулах.
6. Жил бүрийн батлан хамгаалах төсвийн хэмжээ, бүтцийн үндэслэлийг бодитоор гаргах зэрэг болно.

Ийнхүү зорилгот хөтөлбөр төлөвлөлтийн хандлагын үед зөвхөн дараах оны төсвөөр хязгаарлахгүй, боловсруулсан урт хугацааны хөтөлбөрт тулгуурлан цэргийн болон Зэвсэгт хүчнийг хөгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийн хэтийн төлөвлөгөөг шинжлэх ухааны үндэслэлтэй зохиох боломж олгоно.

Батлан хамгаалах төсвийн санхүүжилтийн тогтолцоог боловсронгуй болгоход батлан хамаалах зардлыг үнэлэхэд шинэ хандлагаар хандах хэрэгцээ шаардлага урган гарч байна. Тухайлбал, цэрэг-эдийн засгийн шинжилгээний үр дүнд тулгуурлан гаргаж буй шийдвэрийн үндэслэлийг олон хувилбараар авч үзэх, санал болгож буй хувилбаруудыг "үр дүн-өртөг-хэрэгжилт" шалгуураар үнэлж материалын болон санхүүгийн нөөцийг цэргийн ажиллагааны чадавхыг хамгийн өндөр түвшинд дээшлүүлэх чиглэлд төвлөрүүлэх, хөрөнгө оруулалтын бодит хязгаарыг тогтоох, цэргийн техникийн ажиллагааны нөөц болон сайжруулалтын боломжийг дээд зэргээр ашиглах, үнэ бүрдэлтийн системийг боловсронгуй болгох, материалын болон санхүүгийн нөөцийн зарцуулалтыг ил тод болгох зэрэг болно.

Батлан хамгаалах төсвийн болон төсвийн гадуурх санхүүжилтийг оновчтой хослуулах зарчим баримтлахыг санал болгож байна.

БХЭЗЧ-ыг санхүүгийн механизмаар сайжруулах арга замын тухайд боломж хязгаарлагдмал байгаа нь судалгаанаас илэрхий байна. БХЭЗЧ –ыг эдийн засгийн бус арга замаар сайжруулах хэрэгтэй болж байна. Тухайлбал, гадаад улс орнуудын хамтын ажиллагааны хүрээнд техник технологи, тоног төхөөрөмжийн зээл тусламж, хандив, аялал жуулчлалын хүрээг батлан хамгаалах салбартай холбож зохион байгуулах гэх мэт арга замууд байж болох юм.

### **3.2. Монгол Улсын батлан хамгаалахын чадавхыг нэмэгдүүлэх эдийн засгийн бусад арга замууд**

Монгол Улсын Батлан хамгаалах бодлогын үндэс баримт бичигт “Монгол Улсын хууль тогтоомж, олон улсын гэрээнд нийцүүлэн бусад орон, олон улсын байгууллагаас цэрэг-техникийн дэмжлэг, туслалцаа авч байх чиглэлийг баримтална”<sup>47</sup> хэмээн заасан нь улсын Батлан хамгаалах чадавхыг нэмэгдүүлэх арга замуудын нэг болж байна. Батлан Хамгаалах чадавхыг нэмэгдүүлэх арга замыг эдийн засгийн болон эдийн засгийн бусад арга зам гэж хоёр ангилан авч үзэж болно. Энд эдийн засгийн бусад арга замын талаар авч үзье. Эдийн засгийн бусад арга замыг 3.1 дүгээр зургаар үзүүлээ.



3.1 дүгээр зураг. Эдийн засгийн бусад арга зам.

Батлан хамгаалах салбарын гадаад харилцаа, хамтын ажиллагааг эдийн засгийн агуулгаар баяжуулан хөгжүүлэх, тэлэх замаар Батлан хамгаалахын эдийн засгийн чадавхыг бүрдүүлэн бэхжүүлэх, үр дүнд хүрэх боломж, шаардлага байна.

<sup>47</sup>Төрийн мэдээлэл сэтгүүл. УБ., 2010.

Учир нь Батлан хамгаалах эдийн засгийн чадавхыг хязгаарлагдмал төсөв, санхүү, эдийн засгаар хангана гэдэг ойлголтоос гадна тулгамдсан асуудлыг шийдвэрлэх эдийн засгийн бусад арга замууд нь менежментийн өвөрмөц урлаг гэж ойлгож болох юм. Энэхүү менежментийн арга замыг улс төр-дипломатын аргаар гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх, НҮБ-ын Энхийг Дэмжих Ажиллагаанд оролцох замаар мөн хандив тусламж авах зэрэг арга хэлбэрээр нэмэгдүүлэх боломжийг тодорхойлох нь зүйтэй юм.

Монгол Улсын батлан хамгаалах бодлогын үндэс баримт бичгийн 3.1 –д “Монгол Улсын аюулгүй байдлыг хангах, батлан хамгаалах зорилтыг хэрэгжүүлэхэд Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын болон гадаад бодлогын үзэл баримтлалыг үндэс болгон улс төр, дипломатын аргыг урьтал болгох...”<sup>48</sup> хэмээн заасан билээ. Улс төр, дипломатын бодлогодоо эвсэлд үл нэгдэх, олон тулгууртай байх, хөрш орнуудтай тэнцвэртэй харилцах зарчмыг баримтлан ажиллаж байна. Батлан хамгаалах дипломат үйл ажиллагаа нь хоёр хөрштэйгөө найрсаг харилцааг хөгжүүлэх, аюулгүй байдлын олон талт үйл явц болон Зүүн хойд Азид цэргийн итгэлцлийг тогтоон бэхжүүлэх арга хэмжээнд оролцох, бүс нутгийн аюулгүй байдлын асуудлаар санал, бодлоо харилцан солилцох, цэргийн төлөөлөгчдийг харилцан айлчлуулах, цэргийн алба хаагчдыг энхийг дэмжих ажиллагаанд оролцуулах чиглэлээр өрнүүлэх зэрэгт чиглүүлж байна.

Батлан хамгаалах гадаад харилцаа, хамтын ажиллагааг цэргийн хамтын ажиллагаа, цэрэг-техникийн хамтын ажиллагаа гэсэн хоёр хэлбэрээр хэрэгждэг.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Гадаад бодлогын үзэл баримтлал, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх, Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг улс төр-дипломатын аргаар хангахад дэмжлэг үзүүлэх, батлан хамгаалах гадаад таатай нөхцөлийг бүрдүүлэх, цэргийн итгэлцлийг бэхжүүлэх, олон улсын тавцанд Монгол Улсын Зэвсэгт хүчний нэр хүнд, байр суурийг өргөжүүлж, бэхжүүлэх, бүс нутгийн аюулгүй байдлыг хангахад хувь нэмрээ оруулах, цэргийн шинэчлэлийг хэрэгжүүлэхэд гадаадын тусламж, дэмжлэг авахад чиглүүлэн хөгжүүлж байна.

Үндсэн зорилгыг хангах ажлын хүрээнд гадаад хамтын ажиллагааны бодлогын баримт бичгүүд, харилцаатай орнуудтай байгуулах гэрээ хэлэлцээр, харилцан ойлголцлын санамж бичиг, зөвлөлдөх уулзалт, харилцан айлчлалын үр дүнгийн тухай асуудлыг Монгол Улсын Засгийн газрын болон Батлан хамгаалахын

---

<sup>48</sup>Монгол Улсын батлан хамгаалах бодлогын баримт бичиг.

сайдын зөвлөлийн хуралдаанаар тухай бүрд нь хэлэлцүүлж, танилцуулан, шийдвэрлэж байна.

*Салбарын хэмжээнд мөрдөгдөж буй болон байгуулсан гэрээ, хэлэлцээр*

Батлан хамгаалах салбарын хэмжээнд нийт 22 улстай байгуулсан 60 орчим Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээр болон яамд хоорондын “Харилцан ойлголцлын санамж бичиг”-ийг байгуулан ажиллаж байна.

2013-2015 онд Цэрэг-техникийн хамтын ажиллагааны тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр- 2 /БНХАУ, БНБелУ/, Батлан хамгаалах салбарт хамтран ажиллах Засгийн газар хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг - 3 /Их Британи, БНПУ, БНЭУ/, Цэргийн Санхүүгийн хамтын ажиллагааны Засгийн газар хоорондын хэлэлцээр - 4 /БНТУ/, буцалтгүй тусламж олгох тухай Засгийн газар хоорондын протокол - 1 /ОХУ/, Батлан хамгаалах салбарт хамтран ажиллах яам хоорондын харилцан ойлголцлын санамж бичиг - 7 /Япон, Чех, Канад, Унгар, Беларусь, Вьетнам, Франц/ буцалтгүй тусламж олгох тухай яамд хоорондын гэрээ - 4 /БНХАУ, БНСУ/, Цэргийн сургалтын гэрээ - 3 /БНХАУ, БНПУ, БНТУ/, Хэрэглээ, харилцан үйлчилгээний тухай гэрээ-1 /АНУ/, “Аюулгүй байдлын хамтын ажиллагааны чиг зорилгын талаарх хамтарсан мэдэгдэл”-1 /АНУ/, Хамтран ажиллах дэмжлэг үзүүлэх яамд хоорондын тохиролцоо-2 /ХБНГУ/, бусад - 3 зэрэг нийт 41 Засгийн газар хоорондын болон яамд хоорондын гэрээ, хэлэлцээр, тохиролцоо, санамж бичгийг байгуулсан нь батлан хамгаалах чадавхыг олон улсын гэрээ, хэлэлцээр хийх замаар нэмэгдүүлэх нэг хэлбэр гэж үзэж байна.

*Зөвлөлдөх уулзалт*

Дэлхийн болон бүс нутгийн аюулгүй байдал, хоёр орны Батлан хамгаалах салбарын харилцаа, түүний хэрэгжилт, түүний цаашдын төлөвийн талаар харилцан ярилцаж, санал солилцох, шийдвэр гаргах зорилгоор Батлан хамгаалах салбарт хамтын ажиллагаа бүхий нийт 12 улс /ОХУ, БНХАУ, АНУ, ХБНГУ, БНСУ, БНСУ, Япон, Их Британи, Австрали, БНПУ/, 1 олон улсын байгууллага /НАТО/-тай Батлан хамгаалах яамд хоорондын зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулж байна. Үүнд:

2013 онд 9 /Япон, Австрали, АНУ-2, ХБНГУ, БНСУ, БНЭУ, БНПУ, БНХАУ/, 2014 онд 9 /БНХАУ, ХБНГУ, БНТУ-2, АНУ-2, Япон, Их Британи, НАТО/, 2015 онд 12 /ОХУ, БНХАУ, Австрали, БНФУ, БНПУ, ХБНГУ, БНТУ, АНУ, БНЭУ, БНСУ, Катар Улс, БНАСАУ/ орны Батлан хамгаалах яамтай зөвлөлдөх болон ажлын уулзалтыг нийт 40 удаа зохион байгуулан явуулж, хоёр талын харилцааны өнөөгийн байдал,



тулгамдаад буй асуудал, шийдэх гарц, арга замыг ярилцан, цаашдын төлөвийн талаар тодорхой санал солилцсон байна.

#### *Харилцан айлчлал*

2013-2015 онд Монгол Улсад гадаадын Батлан хамгаалах салбарын дээд, дунд хэмжээний зочдын албан ёсны болон ажлын айлчлалыг 80 гаруй удаа, харин гадаад орнуудад 90 гаруй удаагийн Батлан хамгаалах салбарын дээд, дунд хэмжээний зочдын албан ёсны болон ажлын айлчлалыг зохион байгуулжээ. Нийтдээ харилцан айлчлалын тоо ойролцоогоор 180 орчим байна. Харилцаа хамтын ажиллагааг хөгжүүлж байгаа 32 улс орны зохион байгуулан явуулсан хурал, зөвлөгөөн, семинар, сургалт дамжаанд нийт 1040 орчим цэргийн алба хаагчдыг хамруулжээ.

#### *Гадаадын тусламж*

Батлан хамгаалах яамнаас 2013 оноос хойш гадаадын 10 гаруй улс, орны Засгийн газар, Батлан хамгаалах яамтай идэвхтэй хамтран ажиллаж, Зэвсэгт хүчний зэвсэглэл, техник, тоног төхөөрөмж, эд материалын шинэчлэлтийг хийхээр буцалтгүй тусламж, хөнгөлттэй зээлийн бараа, бүтээгдэхүүнийг хүлээн авсан байна. Энэ тухай дээрх бүлэгт тодорхой орсон болно.

#### **Гадаадын зээл, тусламжаар Батлан хамгаалах чадавхыг нэмэгдүүлэх байдал болон цаашдын боломж**

Өнөөгийн байдлаар Монгол Улсын Батлан Хамгаалах Яам дэлхийн 32 улстай Батлан хамгаалах салбарт харилцаа тогтоон хамтын ажиллагаатай ажиллаж байгаагаас цэрэг-техникийн хамтын ажиллагаатай 5 улс /ОХУ, БНХАУ, Украин, Беларусь, Турк/ байна.

Батлан хамгаалах салбарын 2016 оны гадаад арга хэмжээний төлөвлөгөөнд Батлан хамгаалах салбарт харилцаатай 32 улс, НҮБ, НАТО, ХЗХБ, ОУЦСХ зэрэг олон улсын байгууллагуудтай хэрэгжүүлэх хамтын ажиллагааны асуудлаар нийт 90 арга хэмжээ зохион байгуулахаар төлөвлөснөөс, 88 арга хэмжээ бүрэн биелэгджээ. Эдгээр хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнд гадаадын зээл тусламжийг зохих хэмжээнд авч Монгол Улсын батлан хамгаалахын эдийн засгийн чадавхыг дээшлүүлэхэд чиглэсэн тодорхой алхамууд хийгдсэн байна.

### **Батлан хамгаалах чадавхыг нэмэгдүүлэх боломжууд:**

Монгол Улсын Үндсэн хуулийн “өөрийгөө хамгаалах” Батлан хамгаалах үзэл баримтлал нь урьдчилан сэргийлэх, улс төр, дипломатын аргаар батлан хамгаалах зорилтоо шийдвэрлэх арга замыг нээж өгсөн билээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн энэхүү заалт нь Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд тусгалаа олж “Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг хангах үндсэн арга нь улс төр, дипломатын арга байна. Энэ хүрээнд олон тулгуурт гадаад бодлогын зарчмыг эрхэмлэж, дэлхийн улс орнууд олон улсын байгууллагатай идэвхтэй харилцан хамтын ажиллагааг хөгжүүлнэ”<sup>49</sup>, “Энхийг эрхэмлэсэн гадаад бодлогоо тууштай баримталж, энх тайван аюулгүй байдлыг бэхжүүлэхэд чиглэсэн олон улсын хамтын нийгэмлэгийн үйл ажиллагааг идэвхтэй дэмжинэ”<sup>50</sup>, “Хөрш хоёр орон, АНУ, НАТО-гийн гишүүн орнууд, Европын холбоо, Ази, Номхон далайн бүс нутгийн орнуудтай Аюулгүй байдал, Батлан хамгаалах салбарт хоёр болон олон талын харилцаа, хамтын ажиллагаагаа үргэлжлүүлэн хөгжүүлж, олон улсын энхийг дэмжих үйл ажиллагаанд идэвхтэй оролцоно”<sup>51</sup> гэж заасан. Энэ нь улс орныхоо эдийн засгийн өнөөгийн байдал болон ойрын ирээдүйн чиг хандлагад нийцэж байгаа юм.

1. Цэрэг-техникийн хамтын ажиллагаатай орнуудтай гэрээ, хэлэлцээ, хамтын ажиллагааг хөгжүүлж Батлан хамгаалах чадавхыг нэмэгдүүлэхдээ тухайн улсаас манай Зэвсэгт хүчний хэрэгцээ, шаардлагад нийцсэн зээл тусламжийг нэмэгдүүлэн авч байх бодлогыг тууштай баримтлах боломжтой юм. Тухайлбал, Батлан хамгаалахын багц хуулиудад Зэвсэгт хүчнийг хуурай замын болон агаарын цэрэгтэй болгох бодлого, Засгийн газрын 2016-2020 он хүртэл хэрэгжүүлэх мөрийн хөтөлбөр зэргийг үндэслэн:

- ОХУ-тай Монгол Улсын Зэвсэгт хүчний хуурай замын болон агаарын цэргийн зэвсэглэл, техникийн шинэчлэлт, засвар үйлчилгээ, цэргийн аж үйлдвэрийг хөгжүүлэх чиглэлээр;
- БНХАУ-тай Монгол Улсын Зэвсэгт хүчний барилга, зам, инженерийн техник, хэрэгслийг шинэчлэх, хүн тээврийн автобусны парк шинэчлэлт хийх чиглэлээр;
- АНУ-тай хамтын ажиллагааны үндсэн таван чиглэлийн хүрээнд Монгол Улсын Зэвсэгт хүчнээс НҮБ-ын ЭСА-д үүрэг гүйцэтгэх инженерийн салбарын чадавхыг нэмэгдүүлэх чиглэлээр;

<sup>49</sup> Төрийн мэдээлэл сэтгүүл. УБ., 2010.

<sup>50</sup> Мөн тэнд

<sup>51</sup> Мөн тэнд

- БНТУ-ын Батлан хамгаалах яамтай цэрэг-техникийн хамтын ажиллагааг хөгжүүлж, зэвсэглэл техникийн шинэчлэлт, материал хэрэгслийн хангалтын чиглэлээр;
- ХБНГУ-ын Холбооны Батлан хамгаалах яамтай цэрэг-техникийн хамтын ажиллагааг хөгжүүлэх, Монгол Улсын Зэвсэгт хүчний зэвсэглэл техникийн шинэчлэлтийг зохион байгуулах чиглэлээр;
- БНСУ-ын Үндэсний Батлан хамгаалах яамтай барилга, инженерийн техник хэрэгсэл, ЭДА-ны чадавхыг нэмэгдүүлэх чиглэлээр;
- ИБУИНВУ-ын Батлан хамгаалах яамтай “Энхийг сахиулахын англи хэл” төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх чиглэлээр;
- Израйлийн Батлан хамгаалах яамтай тусгай томилгоот салбарыг зэвсэг, галт хэрэгслээр хангах чиглэлээр;
- Мөн эдгээр бүх улс оронтой цэргийн боловсролыг хөгжүүлэх, хүний нөөцийг сургаж бэлтгэх чиглэлээр тус тус үйл ажиллагаагаа чиглүүлэн Монгол Улсын Батлан хамгаалах эдийн засгийн чадавхыг нэмэгдүүлэх нөхцөл боломжтой гэж үзэж байна.

Батлан хамгаалах яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрт<sup>52</sup> “батлан хамгаалах үйл ажиллагаанд орчин үеийн мэдээллийн дэвшилтэд технологийг нэвтрүүлэн ашиглах, кибер аюулгүй байдлыг хангах, цахим санг байгуулж, үйл ажиллагаанд ашиглах, мэдээллийн техник хэрэгслийн ашиглалтад хяналт тавьж, сүлжээний найдвартай ажиллагааг зохион байгуулах” зорилтыг дэвшүүлсэн билээ.

БХЭЗЧ-ыг нэмэгдүүлэх зорилтын нэг чиглэл нь цэргийн боловсрол, соёл, шинжлэх ухаан, үйлдвэрлэл, техник, технологийн хөгжлийг хангах шаардлагатай байна. Иймээс цэргийн шинжлэх ухаан, технологийг хөгжлийн шинэ шатанд гаргах, энэ хүрээнд онолын суурь, хавсарга судалгааг хөгжүүлэх, тэргүүний технологи эзэмших, цэргийн зориулалт бүхий жижиг, дунд үйлдвэрлэлийг өргөжүүлэх нь цаг үеийн тулгамдсан асуудал болж байна.

### **НҮБ-ын Энхийг Дэмжих Ажиллагаанд оролцоноор Батлан хамгаалах чадавхыг нэмэгдүүлэх боломж**

Монгол Улс олон улсын энхийг дэмжих ажиллагаанд цэрэг дайчдаа оролцуулж байгаа нь олон улсын өмнө хүлээсэн НҮБ-ын гишүүн орныхоо үүргийг биелүүлж, дэлхий дахинд энх тайван, аюулгүй байдлыг тогтоох, бүс нутгийн тогтвортой байдлыг хангах үйл явцад хувь нэмрээ оруулан, цэргийн итгэлцлийг бэхжүүлэн

<sup>52</sup> Батлан хамгаалах үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр. УБ., 2016

энхийг эрхэмлэсэн төрийн гадаад бодлогын зорилтыг хэрэгжүүлж байгаа төдийгүй Зэвсэгт хүчний үүрэг гүйцэтгэх чадавхыг нэмэгдүүлэх боломжийг бий болгож, цэргийн алба хаагчдын мэргэжлийн бэлтгэлийг өндөржүүлэх, тэдний нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд чухал ач холбогдолтой юм. Өөрөөр хэлбэл, Батлан хамгаалах чадавхыг нэмэгдүүлэх арга замын нэг гэж үзэж байна.

Монгол Улсын Зэвсэгт хүчний дайчид олон улсын энхийг дэмжих ажиллагаанд оролцож байгаагаараа эх орныхоо тусгаар тогтнолыг улс төр-дипломатын аргаар хамгаалахад тодорхой хувь нэмэр оруулж байгаагийн зэрэгцээ Зэвсэгт хүчнээ хөгжүүлэхэд улсын төсвийн гадуур тодорхой хэмжээний орлого оруулж байгаа билээ. Холбогдох байгууллагуудын мэдээгээр 2005-2011 онд гадаад улс орнуудаас манай улсад цэргийн хамтын ажиллагааны шугамаар үзүүлж байгаа тусламжаас гадна НҮБ болон олон улсын бусад ажиллагаанд монгол цэрэг оролцсон тул 28 сая ам.долларын хэмжээний хөрөнгийг “Зэвсэгт хүчнийг хөгжүүлэх сан”-д оруулаад байна. Энэ сангийн хөрөнгө нь цэргийн алба хаагчдаа цаашид хөгжүүлэх, Зэвсэгт хүчнийхээ өмнө тулгамдаад байгаа зарим асуудлыг шийдэх зэрэгт ихээхэн тус дэм болохоор байна. Энэ бүхэн бол манай Зэвсэгт хүчний офицер, ахлагч нар НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд оролцож байгаагийн эдийн засгийн шууд үр дүн юм.

Монгол Улс Энхийг дэмжих ажиллагаанд оролцсоноор олон улс, хамтын ажиллагаатай улс орнуудаас дэмжлэг тусламж авах хүрээ өргөжсөний дотор АНУ-ын Конгрессийн баталдаг “Дэлхийн энхийн ажиллагааны санаачилга”, “Эвслийн ажиллагааг дэмжих сан” зэрэг олон хөтөлбөр, сангаас санхүүгийн дэмжлэг авах боломжийг нээж өгсөн нь Зэвсэгт хүчний зэвсэглэл, техникийг шинэчлэх, цэргийн алба хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд багагүй түлхэц болж байна.

Мөн энхийг сахиулагчдын хотхоныг байгуулах, улмаар уг хотхоныг бусад улсын тусламжтайгаар НҮБ-ын энхийг сахиулах хүчний бүс нутгийн сургалтын төв болгон өргөжүүлэх ажлыг АНУ-ын Ази, Номхон далайн цэргийн командлалын тусламжтайгаар барьж зохион байгуулан, энхийг сахиулагчдын ажиллагааны өмнөх бэлтгэлийг хангах, олон улсын энхийг сахиулагчдын цэргийн хамтарсан хээрийн сургууль явуулах гол бааз болгоод байгаа нь Батлан хамгаалах чадавхыг нэмэгдүүлэхэд хөрөнгө оруулж буй нэг хэлбэр юм.

Энхийг дэмжих ажиллагаанд бие бүрэлдэхүүнээ оролцуулснаар тэдний нийгмийн хамгааллын асуудал тодорхой хэмжээгээр дээшилж байна. Офицер, ахлагч нар үүргээ гүйцэтгэхийн тулд гадаад хэл сурах, мэдээлэл, холбооны техник хэрэгслийг эзэмших, олон улсын энхийг сахиулах албаны ажлыг эрхлэн хөтлөх,

өөрийгөө хөгжүүлж өөртөө хөрөнгө оруулалт хийж байгаа нийгмийн ач холбогдолтой юм. Мөн тэдний мөнгөн орлого ч ажиллагааны хугацаанд багагүй хувиар нэмэгдэж, аж амьдрал нь мэдэгдэхүйц дээшилж байна. “Энхийг дэмжих ажиллагаанд оролцсон бие бүрэлдэхүүний 90 орчим хувь нь ажиллагаанд оролцож аж амьдралаа дээшлүүлэх давхар гол зорилгыг агуулж байсан байна”<sup>53</sup> гэсэн судалгаа байна.

Зэвсэгт хүчний байгуулалтын шинэчлэлд нэг томоохон алхам хийсний нэг нь 2007 онд “Зэвсэгт хүчний байгуулалтыг 2015 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр”-ийг батлан гаргасан явдал бөгөөд “НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаа болон олон улсын бусад ажиллагаанд оролцох чадавхыг нэмэгдүүлэх” арга хэмжээний хүрээнд “Монгол улсын Зэвсэгт хүчний энхийг дэмжих ажиллагааны чадавхыг нэмэгдүүлэх хөтөлбөр” болон “Энхийг дэмжих ажиллагаанд оролцох томилгоот анги салбаруудын зэвсэглэл, техникийг шинэчлэх, хангах”, “Зэвсэгт хүчний энхийг дэмжих ажиллагааны сургалтын төв” дэд төслүүд батлагдан тодорхой үе шаттайгаар хэрэгжиж иржээ. “Монгол Улсын Зэвсэгт хүчний энхийг дэмжих ажиллагааны чадавхыг 2016–2020 он хүртэл нэмэгдүүлэх хөтөлбөр”-ийг боловсруулан төлөвлөгөө гарган ажиллаж байна.

Энхийг дэмжих ажиллагааны чадавхыг бэхжүүлэх гол чиглэл бол энхийг дэмжих ажиллагаанд үүрэг гүйцэтгэх цэргийн багуудын техник, тоног төхөөрөмж, материал хэрэгсэл, хүн нэг бүрийн хамгаалалтын нөөцтэй болох хэрэгтэй байна. Үүний тодорхой жишээ нь 3 сарын хугацаанд II шатны эмнэлгээс үндсэн тоног төхөөрөмжөөс 137,694.27, өөрийгөө хангахад 212,195.56 нийт 350,889.83 ам.доллар, холимог батальоноос 1,225,409.68, 813,781.00 нийт 2,039,190.68 ам.долларын нөхөн төлбөр авч байна<sup>54</sup>. Харин инженерийн рот оруулсан тохиолдолд Леван улс дахь UNIFIL ажиллагаанд байгуулсан улсын жишгийг авч үзвэл зөвхөн үндсэн тоног төхөөрөмжөөс олох нөхөн төлбөрт 139,688.28 ам.доллар авч байна<sup>55</sup>. Эдгээрийг бүтэн нэг жилд олох нөхөн төлбөрөөр авч үзвэл холимог батальоноос 8 сая 16 мянган ам.доллар, II шатны эмнэлгээс 1 сая 400 мянган ам.доллар, инженерийн ротоос 1 сая 680 мянган ам.доллар авахаар харагдаж байна. Гэхдээ үүнд бэлэн байдлын үзлэгт аль хэр шалгуулснаас нөхөн төлбөрийн хэмжээ харилцан адилгүй байж болох талтай юм. Иймд цаашдаа 650

<sup>53</sup> Монгол Улсын цэргийн баг Сьерра Леон, Чадын энхийг сахиулах ажиллагаанд оролцсон туршлага, сургамж. Т. 72

<sup>54</sup> 2015 оны 9 дүгээр сарын 30-ны байдлаар НҮБ-ын нөхөн төлбөрөөс олсон мөнгө

<sup>55</sup> 2012 оны 02 дугаар сарын байдлаар

хүнтэй мотобуудлагын батальон, 250 хүнтэй барилга, инженерийн рот, II шатны эмнэлэг зэргийг илгээх нь эдийн засгийн хувьд болон тайван цагт Зэвсэгт Хүчний гүйцэтгэх олон талт үүргүүдийн чадавхыг дээшлүүлэхэд чухал юм. Дээрх байдал нь Монгол Улсын БХЭЗЧ-ыг нэмэгдүүлэх боломжтой нэгэн хувилбар гэж үзлээ.

## ДҮГНЭЛТ

Батлан Хамгаалах чадавхыг нэмэгдүүлэх арга замыг эдийн засгийн болон эдийн засгийн бусад арга зам гэж хоёр ангилан авч үзлээ. Манай улсын үйлдвэрлэлийн хэмжээ, эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлсний үндсэн дээр, БХ-ийн төсвийг үе шаттайгаар нэмэгдүүлж улс орны батлан хамгаалах хүч чадлыг өсгөх боломж бүрдэнэ.

Монгол Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-д “Эдийн засгийн жилийн дундаж өсөлт 2016-2030 онд 6.6 хувиас доошгүй байна” гэсэн заалтыг хэрэгжүүлэхэд төрөөс онцгой анхаарч ажиллах нь зүйтэй гэж үзлээ.

Өнөөгийн байдлаар Монгол Улсад үүсээд байгаа эдийн засаг, мөнгө, санхүүгийн байдал нь батлан хамгаалах чадавхад ихээхэн нөлөө үзүүлж байна.

Манай улсын үйлдвэрлэлийн хэмжээ, эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлсний үндсэн дээр, БХ-ийн төсвийг үе шаттайгаар нэмэгдүүлж улс орны батлан хамгаалах хүч чадлыг өсгөх боломж бүрдэнэ. Өөрөөр хэлбэл, батлан хамгаалах салбарын төсвийг нэмэгдүүлэх хүчин зүйлүүдийг судлах асуудал нэн тэргүүний гол зүйлүүдийг судалж үзсэнээр батлан хамгаалах салбарын төсөв нэмэгдэх боломжийг харж болно. Ийм нөхцөлд эдийн засгаа хөгжүүлэх БХЭЗЧ-аа бүрдүүлэн бэхжүүлэх бодлого, стратегиа боловсруулан хэрэгжүүлэхэд тэдгээрийн хоорондын уялдаа холбоог харгалзан үзэх нь гол хүчин зүйл байх болно. Харин эдийн засгийн хямрал Монгол Улсад ойрын 5 жилдээ үргэлжлэн нөхцөл байдал сайжрах хандлага судалгааны ажлын үр дүнгээс харагдахгүй байна.

Улс орны аюулгүй байдлын түвшнээс тухайн улсын Батлан Хамгаалах эдийн засгийн чадавх (БХЭЗЧ) хамаарч түүнд тулгуурлах уялдаа холбоог тодорхойлж байдаг. Аливаа улсын БХЭЗЧ-ын түвшинг БХ салбарт зарцуулж буй төсвийн хэмжээ харуулдаг болохыг судалгааны ажлын хоёрдугаар бүлэгт тодорхой авч үзсэн болно.

Батлан Хамгаалах төсөв Улсын төсвийн 6 хүртэл хувь, дотоодын нийт бүтээгдэхүүний 2-3 хувийг эзлэх нь олон улсын практикт хэвийн ойлголт гэж үздэг. Уг төсвийн 40 хувийг нийгмийн хамгааллын салбарт, 20-30 хувийг зэвсэг,

техникийг шинэчлэхэд бусад хувийг судалгаа шинжилгээ, зохион бүтээх зэрэг төсөвт зориулагдсан бүтэц харьцаатай байхыг зохистой эрүүл төсөв гэж үздэг нийтлэг хандлага байна.

Батлан хамгаалах салбар нь төсвөө Үндэсний аюулгүй байдлын бодлогоор тодорхойлогдсон Зэвсэгт хүчний үүрэг зориулалтад нийцсэн мэргэжлийн сургалт, бие бүрэлдэхүүний нийгмийн асуудал, зэвсэглэл техник болон бусад шаардлагатай зүйлд хуваарилан зарцуулах нь зөв юм.

Улсын эдийн засаг болон батлан хамгаалах чадавхын уялдаа холбоог сайжруулах шалгуур үзүүлэлтийг ДНБ-ий хэмжээ, эдийн засгийн өсөлт, өрсөлдөх чадвар, төсвийн алдагдал, улсын өр, шинжлэх ухаан, шинэ технологийн хэмжээ, инфляцийн түвшин, ажилгүйдлийн хэмжээ гэсэн байдлаар тодорхойлж байна.

БХЭЗЧ-ыг дан ганц дотоод хүчин зүйлээр гүйцэлдүүлэх боломжгүй юм. Тиймд гадаад хүчин зүйлийн боломжийг зөв ашиглаж үр дүнд хүрэх бодит шаардлага байна.

БХ салбарын гадаад харилцаа, хамтын ажиллагааг эдийн засгийн агуулгаар баяжуулан хөгжүүлж тэлэх замаар БХЭЗЧ-ыг бүрдүүлэн бэхжүүлэх үр дүнд хүрэх боломж шаардлага байна гэж үздэг.

Монгол Улсын хөгжлийн бодлогын өнөөгийн загвар нь Үйлдвэржүүлэлт(I) + Аялал жуулчлал, үйлчилгээ (S) + Хөдөө аж ахуй, газар тариалан(A) = Хамгийн зөв төлөвлөлт гэж үзлээ.

Батлан хамгаалах салбар (Зэвсэгт хүчнийг) хөгжүүлэх **зорилгот- хөтөлбөр- төлөвлөлтийн** аргыг хэрэглэснээр олон давуу боломжийн олгоно гэж үзлээ. Энэ зорилгот хөтөлбөрийн хандлага нь нэгд, Зэвсэгт хүчний байгуулалтыг хөгжүүлэх хэтийн төлөвийг тодорхойлох, хоёрт, тавигдсан зорилгод хүрэх арга хэмжээг цогц байдлаар авч үзсэн дунд хугацааны хөтөлбөрийг боловсруулах, гуравт, батлан хамгаалах төсвийг боловсруулах гэсэн хоорондоо нягт уялдаатай дараалсан гурван үе шатыг багтаана.

Цэрэг-техникийн хамтын ажиллагаатай орнуудтай гэрээ, хэлэлцээ, хамтын ажиллагааг хөгжүүлж Батлан хамгаалах чадавхыг нэмэгдүүлэхдээ тухайн улсаас манай Зэвсэгт хүчний хэрэгцээ, шаардлагад нийцсэн зээл тусламжийг нэмэгдүүлэн авч байх бодлогыг тууштай баримтлах боломжтой юм.

Батлан хамгаалах салбарын гадаад харилцаа, хамтын ажиллагааг эдийн засгийн агуулгаар баяжуулан хөгжүүлэх, тэлэх замаар Батлан хамгаалахын эдийн засгийн чадавхыг бүрдүүлэн бэхжүүлэх, үр дүнд хүрэх боломж, шаардлага байна. Батлан хамгаалах чадавхыг нэмэгдүүлэх арга зам нь улс төр-дипломатын аргаар

гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх, НҮБ-ын Энхийг Дэмжих Ажиллагаанд оролцох замаар мөнгө хөрөнгө олох, хоёр хөрш болон бусад орнуудтай сайн хөршийн харилцааг тогтоож, цэрэг техникийн болон мөнгөн тусламж авах зэрэг арга хэлбэрээр нэмэгдүүлэх боломжтой гэж үзлээ.

## ТӨГСГӨЛ

Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдал түүний орчин, хүчин зүйлс нь батлан хамгаалах чадавхад нөлөөлөх зүй тогтол, сургамжийг тодорхойлон, Улсын эдийн засгийн болон батлан хамгаалах чадавхын өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийх, батлан хамгаалах эдийн засгийн чадавхыг нэмэгдүүлэх арга замыг тодорхойлох зорилго тавьж шийдвэрлэлээ.

Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдал ба батлан хамгаалах чадавхын өсөлтөд хийсэн дүн шинжилгээ судалгааны үр дүнгээр дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. ЭЗАБ-д сөргөөр нөлөөлж буй гадаад, дотоод хүчин зүйлийг тодорхойлж, чиглэл бүрээр судалгаа хийж, нөхцөл байдлыг үнэлэв. ЭЗАБ-ын шалгуур үзүүлэлтийн тогтолцоог өргөтгөж, нийт 35 үзүүлэлтээр үнэлж үзэхэд 26 үзүүлэлт буюу 74 хувь нь аюултай гэж үзэх босго үзүүлэлтийг давсан байна. Эдгээрээс 14 үзүүлэлт буюу 40 хувь нь маш өндөр эрсдэлтэй, 12 үзүүлэлт буюу 34 хувь нь өндөр эрсдэлтэй, 3 үзүүлэлт 9 хувь буюу дундаж эрсдэлтэй, 6 үзүүлэлт буюу 17 хувь нь бага эрсдэлтэй байна. Аюултай гэж үзэх босго утга, түүнээс давсан байдал нь эдийн засгийн аль нэг хүрээний уналт, үл оршин тогтнохыг тэр болгон харуулдаггүй ч тухайн салбарын аюулгүй байдал алдагдсан, тус салбарт гадны нөлөө өндөр байгааг илтгэж, аль чиглэлд илүү анхаарал хандуулж, шуурхай ажиллах шаардлагатай байгааг харуулж байна. Энэ байдал урт хугацаанд үргэлжилбэл манай улсын ЭЗАБ алдагдаж, гадаад улс орон, бүлэглэлүүдээс хараат байдалд орж, ард түмний язгуур ашиг сонирхолд хохирол учрах магадлал ойрхон байна гэж үзэв. Өөрөөр хэлбэл Монгол Улсад ойрын 5 жилдээ эдийн засгийн нөхцөл байдал сайжрах хандлага судалгааны ажлын үр дүнгээс харагдахгүй байна.
2. ОУВС, Дэлхийн Банкнаас боловсруулсан ЭЗАБ-ыг хангах өрийн босго утгын харьцааны дагуу Монгол Улсын өрийн тогтвортой байдлын шинжилгээ хийв. Тухайлбал ДНБ-д Засгийн газрын өрийн үлдэгдлийн злэх жин 40 хувиас бага байхаас манай улсын Засгийн газрын эзлэх жин 2012 онд 51,3 хувьтай байсан бол 2015 онд 81,3 хувьд хүрч, 2017, 2018 онд 89-92 хувьд



хүрэх төлөвтэй байна. Засгийн газар, Хөгжлийн Банк гадаад бонд гаргах, их хэмжээний зээл авахдаа түүнийгээ юунд зарцуулах нарийн төсөл төлөвлөгөөгүйгээр УИХ-аар урьдчилан батлуулах явдал байна. Төв Банк, Сангийн Яамтайгаа хамтран хувийн хэвшлийн гадаад өрийн зохицуулалтыг хийх хууль эрхзүйн механизмыг боловсруулах шаардлагатай байна. Манайд өрийг удирдах нэгдсэн бодлого алга байна. Засгийн газрын гадаад өрийн зохистой түвшинг тодорхойлохдоо эдийн засагт шугаман бус нөлөөтэй буюу параболь хэлбэрийн тэгшитгэлээр үнэлэхэд гадаад өрийн ДНБ-ний харьцаа 40 хувь байвал эдийн засаг эерэг өсөлттэй, харин 76 хувиас давсан үед эдийн засгийн өсөлт сөрөг байхыг тогтоов.

3. Монгол Улсын хөгжлийн бодлогын өнөөгийн загвар нь Үйлдвэржүүлэлт (I) + Аялал жуулчлал үйлчилгээ (S) + Хөдөө аж ахуй, газар тариалан (A) = оновчтой төлөвлөлт гэж үзлээ. Мөн газрын доорх баялагийг төрийн мэдэлд байлгаж түүнийг ашигласнаас хөгжлийн тусгай санг бий болгон сангийн 2 хувийг Ерөнхий сайд нь мэдэж зарцуулдаг байх нөхцөл рүү орох, онцгой нөхцөл бий болсон үед хууль тогтоомжоор 4 хүртэл хувийг зарцуулдаг олон улсын туршлагыг авч хэрэгжүүлэх нь зүйтэй юм.
4. Улсын эдийн засгийн оновчтой загварыг тогтоож хэрэгжүүлснээр үйлдвэрлэлийн хэмжээ, эдийн засгийн өсөлт нэмэгдэх бөгөөд БХ-ын төсвийг ДНБ-д эзлэх хувийг үе шаттайгаар нэмэгдүүлэх, улмаар цэргийн зэвсэглэл, техник үйлдвэрлэх боломжтой болно. Батлан Хамгаалах төсөв Улсын төсвийн 6 хүртэл хувь, дотоодын нийт бүтээгдэхүүний 2-3 хувийг эзлэх нь олон улсын практикт хэвийн ойлголт юм. Уг төсвийн 40 хувийг нийгмийн хамгааллын салбарт, 20-30 хувийг зэвсэг, техникийн шинэчлэлд бусад хувийг судалгаа шинжилгээ, зохион бүтээх зэрэг ажлын төсөвт зориулагдсан бүтэц харьцаатай байх нь зүйтэй гэж үзэв.
5. Дунд хугацаанд (2017-2022 он) нийгэм эдийн засгийн нөхцөл байдал сайжрахгүй тохиолдолд ДНБ-д цэргийн зардлын эзлэх хувь хэмжээний доод хязгаар нь 0,7%-1,0%, дээд хязгаар нь 0,8%-1,3% байх шаардлагатай гэсэн тооцоолол гарч байгаа юм.
6. Батлан хамгаалах салбарыг хөгжүүлэх, зэвсэг техникээ шинэчлэх, цэргийн сургалтыг чанартай зохион байгуулах, эрдэм шинжилгээ, судалгаа, туршилтыг явуулах, ЦАХ-ын нийгмийн хамгааллыг сайжруулах, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх зэрэг асуудлыг шийдвэрлэхэд Монгол Улсын батлан хамгаалах

салбарын батлагдсан төсөв нь өнөөгийн шаардлагыг хангаж чадахгүй байна гэж үзлээ.

7. БХЭЗЧ-ыг дан ганц дотоод хүчин зүйлээр гүйцэлдүүлэх боломжгүй юм. Тиймээс гадаад хүчин зүйлийн боломжийг зөв ашиглаж үр дүнд хүрэх бодит шаардлага байна.
8. Батлан хамгаалах салбарын гадаад харилцаа, хамтын ажиллагааг эдийн засгийн агуулгаар баяжуулан хөгжүүлэх, тэлэх замаар Батлан хамгаалахын эдийн засгийн чадавхыг бүрдүүлэн бэхжүүлэх, үр дүнд хүрэх боломж, шаардлага байна. Батлан хамгаалах чадавхыг нэмэгдүүлэх арга зам нь улс төр-дипломатын аргаар гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх, НҮБ-ын Энхийг Дэмжих Ажиллагаанд оролцох замаар мөнгө хөрөнгө олох, хоёр хөрш болон бусад орнуудтай сайн хөршийн харилцааг тогтоож цэрэг техникийн болон мөнгөн тусламж авах зэрэг арга хэлбэрээр нэмэгдүүлэх боломжтой гэж үзлээ.
9. Батлан хамгаалах салбарыг (Зэвсэгт хүчнийг) хөгжүүлэх **төлөвлөлтөд зорилгот-хөтөлбөр-төлөвлөлтийн** аргыг хэрэглэснээр олон давуу боломжийн олгоно гэж үзлээ. Энэ зорилгот хөтөлбөрийн хандлага нь **нэгд**, Зэвсэгт хүчний байгуулалтыг хөгжүүлэх хэтийн төлвийг тодорхойлох, **хоёрт**, тавигдсан зорилгод хүрэх арга хэмжээг цогц байдлаар авч үзсэн дунд хугацааны хөтөлбөрийг боловсруулах, **гуравт**, батлан хамгаалах төсвийг боловсруулах гэсэн хоорондоо нягт уялдаатай дараалсан гурван үе шатыг багтаана.
10. Цэрэг-техникийн хамтын ажиллагаатай орнуудтай гэрээ, хэлэлцээ, хамтын ажиллагааг хөгжүүлж Батлан хамгаалах чадавхыг нэмэгдүүлэхдээ тухайн улсаас манай Зэвсэгт хүчний хэрэгцээ, шаардлагад нийцсэн зээл тусламжийг нэмэгдүүлэн авч байх бодлогыг тууштай баримтлах боломжтой.
11. Хөрш орнуудын батлан хамгаалах төсвийн төлөв хандлагыг шинжилж, батлан хамгаалах салбарын зардлын шинж чанар нь Зэвсэгт хүчнийг хөгжүүлэх, аюулгүй байдлыг хангахад чиглэгдэж байгааг тогтоов. Манай улсын батлан хамгаалах зардлын санхүүжилт хэдийгээр бага ч гэсэн нэмэгдсэн дүнтэй харагдаж байгаа ч батлан хамгаалах салбарын төсөв зөвхөн хэрэглээний шинжтэй байгаагаас Зэвсэгт хүчний техник технологийн шинэчлэл, нийгмийн хамгааллын асуудалд зарцуулах санхүүжилт хангалтгүй байна. Батлан хамгаалах төсвийн санхүүжилтийн өнөөгийн тогтолцооны нэг томоохон дутагдал нь цэргийн байгуулалтын төлөвлөлт болон батлан хамгаалах төсвийн боловсруулалт хооронд нягт уялдаа холбоогүй байгаад оршиж байна. Иймээс санхүүгийн хязгаарлалтаас үүдэн цэргийн байгуулалтыг хөгжүүлэх хэтийн

төлөвлөгөө, заримдаа эхэлсэн хөтөлбөр биелэгдэхгүй байх тохиолдол гардаг. Батлан хамгаалах төсвийн санхүүжилтийн хувилбарын үндэслэлийг цэргийн зардлын зүйлчилсэн ангиллын тогтолцооны талаас нь батлан хамгаалах төсвийн ангиллыг боловсруулах алгоритмоор шийдлийн хувилбарыг авч үзсэн болно. Ингэхдээ ОХУ-д хэрэглэдэг "зорилгот-хөтөлбөр-төлөвлөлт"-ийн аргаар ЭЗАБ-ыг хангахуйц батлан хамгаалах салбарын төсвийн санхүүжилтийн зохистой хувилбарын үндэслэлийг тооцох аргазүйг гаргав. Нийгэм эдийн засгийн нөхцөл байдал сайжрахгүй тохиолдолд дунд хугацаанд (2017-2022 он) ДНБ-д батлан хамгаалах зардлын эзлэх хувь хэмжээний доод хязгаар нь 0,7%-1,0%, дээд хязгаар нь 0,8%-1,3% байх тооцоолол гарав. Цаашид батлан хамгаалах салбарын эдийн засгийн чадавхыг нэмэгдүүлэхийн тулд ДНБ-д батлан хамгаалах зардлын эзлэх хэмжээг 2-3 хувьд төсвийн зарлагад батлан хамгаалах зардлын эзлэх хэмжээг 3-5 хувьд тус тус хүргэх шаардлагатайг судалгааны дүн харуулж байна.

12. Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдал ба батлан хамгаалах чадавхын өсөлтөд хийх дүн шинжилгээний үр дүнгийн талаар дэвшүүлсэн санал, дүгнэлт нь Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдлыг хангах, батлан хамгаалах чадавхыг дээшлүүлэхэд шинжлэх ухааны үндэслэлтэй, онол аргазүйн болоод практикийн чухал ач холбогдолтой байх болно.
13. Батлан хамгаалах салбарын 2017 оны батлагдсан төсвийг авч үзвэл урсгал зардал 204,173.0 сая төгрөг, хөрөнгө оруулалт 2,693.1 сая төгрөг болж байна. Судалгааны ажлын дүгнэлтээс үзэхэд ойрын 5 жилийн хугацаанд улс орны эдийн засаг сэргэлт аван сайжрах төлөв харагдахгүй байгаа үед БХ салбарт хөрөнгө оруулалтын төсвийг нэмэгдүүлэх боломжийг хязгаарлаж байна. БХ салбарын хөгжилд түлхэц авчрах үндсэн хүчин зүйл нь хөрөнгө оруулалтын төсөв бөгөөд нэгэнт улсын төсвийн хөрөнгө оруулалт хязгаарлагдмал энэ үед дараах эх үүсвэрүүдийг дайчлан хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх боломжтой гэж үзлээ.
14. Батлан хамгаалахын 2018 оны улсын төсөвт 5 орчим тэрбум төгрөгийн санхүүжилтийг суулгах зохицуулалтыг хийж, УИХ-д өргөн барьж, шийдвэрлүүлэхээр ажиллаж байгаа нь ач холбогдолтой юм.
15. Зэвсэгт хүчний хөгжлийн сангийн хөрөнгийг зөв хуваарилж, зэвсэг техникийг шинэчлэх, цэргийн алба хаагчдын нийгмийн хамгааллыг сайжруулах боломж гарц байна. Тухайлбал, өнөөгийн байдлаар 63 айлын орон сууцыг барих төсөв нь 3.5 тэрбум төгрөг болж байгаа бөгөөд "Цэргийн алба хаагчийн тэтгэвэр,

тэтгэмжийн тухай хууль"-ийн 19.6 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 9 дүгээр тогтоолоор "Цэргийн алба хаагчид орон сууцны дэмжлэг үзүүлэх тухай" журмаар нэг цэргийн алба хаагчид 15.0 сая төгрөгийн орон сууцны дэмжлэгийг үзүүлэхэд дээрх хөрөнгөөр 230 алба хаагчийн нийгмийн асуудлыг шийдвэрлэх боломж байна гэж үзлээ.

16. Цэрэг, техникийн хамтын ажиллагаатай орнуудаас авах зээл, тусламжийн хэмжээг нэмэгдүүлэн өртөг шингэсэн бүтээгдэхүүн гаргах жижиг, дунд үйлдвэрүүдийг оруулж ирснээр батлан хамгаалах чадавхыг нэмэгдүүлэх боломж байна. Урьд нь Цэрэг, техникийн хамтын ажиллагаатай орнуудаас авсан техникүүд нь хуучирсан, эдэлгээнд орсон байснаас гадна тэдгээрийг тээвэрлэн авчрах зардлыг Зэвсэгт хүчний хөгжлийн сангаас хөрөнгө гарган татан авснаар нэгж техникт гаргасан зардал өндөр, үр ашиг муутай шийдвэр байсан нь судалгаанаас харагдаж байна.
17. Зэвсэгт хүчний хөгжлийн сангийн орлого нь хараат буюу зөвхөн НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд оролцсоны нөхөн төлбөрийн орлогоос бүрдэж байгаа байдлыг халж, олон сувгаар тэжээгддэг болгох шаардлагатай байна. БНХАУ-аас тусламжаар авсан болон Зэвсэгт хүчний хөгжлийн сангийн хөрөнгөөр худалдан авч хөрөнгө оруулалт хийгдсэн барилгын болон инженерийн техник, тоног төхөөрмжийн ашиглалтыг сайжруулж түүнээс олсон орлогоор 2 дахь орлогын эх үүсвэрийг бүрдүүлэх шаардлагатай гэж үзлээ.

## ЭШЛЭЛ АВСАН ЭХ СУРВАЛЖ, СУДАЛГААНЫ БҮТЭЭЛ

1. Д.Тунгалаг. "Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдлын зарим асуудал". УБ., 2001 он.
2. "Үндэсний эдийн засгийн аюулгүй байдлын онол, практикийн зарим асуудал". 2015 .
3. Л.Отгонтуяа. "Төсвийн зарлагын төлөвлөлтийг боловсронгуй болгох нь". 2007 он.
4. Ж.Энхбаяр. "Монгол Улсын Батлан хамгаалах эдийн засгийн чадавхыг бэхжүүлэх асуудалд". УБ., 2009 он.
5. Ж.Энхбаяр. "Батлан хамгаалахын эдийн засгийн зарим асуудал". УБ., 2010 он.
6. А.Энхбат. "Монгол Улсын санхүүгийн хөтөлбөр боловсруулах арга зүйн суудал". УБ., 2010 он.
7. А.Батпүрэв. "Төсвийн бодлогын макро эдийн засгийн үзүүлэлтүүдэд нөлөөлөх нөлөөллийн шинжилгээ". УБ., 2013 он.
8. Д.Оюунцэцэг. "Төсвийн бодлогын үр дүнгийн үнэлгээ". УБ., 2014 он.
9. Т.Намсрай, Д.Нанжид. "Батлан хамгаалах төсөв боловсруулах арга зүйн асуудал". УБ., 2016 он.
10. А.Заяадэлгэр. "Боловсролын эдийн засаг". УБ., 2011 он.
11. Д.Энхчимэг "Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдлыг төсвийн бодлогоор дэмжих арга зам" дессертаци, УБ., 2016 он
12. "Төрийн мэдээлэл" сэтгүүл. УБ., 2010. №36 (657)
13. "Төрийн мэдээлэл" сэтгүүл. УБ., 2016. №36 (945)
14. Монгол Улсын Үндсэн хууль. УБ., 1992 он.
15. Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлал. УБ., 2011 он.
16. Абалкин.Л "Экономическая безопасность России: угрозы и их отражение".
17. Монгол Улсын Их Хурлын 2015 оны 85 дугаар тогтоолын хавсралт, "Монгол улсын батлан хамгаалах бодлогын үндэс"
18. Salvatore Schiavo-Campo and Daniel Tommasi, "The Budget Preparation Process," Asian Development Bank, available at [http://www.adb.org/documents/manuals/govt\\_expenditure/Chap4.PDF](http://www.adb.org/documents/manuals/govt_expenditure/Chap4.PDF) assessed 4 May 2001.
19. <http://data.worldbank.org/indicator/NY.GDP.DEFL.KD.ZG>
20. [www.sipri.org](http://www.sipri.org).
21. <http://www.sipri.org/media/expert-comments/exp1>
22. Улсын бүртгэл, статистикийн газар, 19001212, 2015он.
23. Монгол Улсын статистикийн эмхэтгэл, 2011 он, 132 дахь тал, 2013 он, 207 дахь тал.
24. Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдал, 2015 оны 1 сар, 26 дахь тал
25. Статистик мэдээ, Ашигт малтмалын газар, 2016.03, 18 дахь тал
26. [www.Монголбанк.mn](http://www.Монголбанк.mn).
27. Монгол Банк, "Судалгааны ажил" товхимол, №10, УБ., 2015 он.
28. Батлан хамгаалах үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр. УБ., 2016.
29. Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030", 2016 он.